# ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМНЫ 2026 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв, сая.төг | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин 2025 | Зорилтот түвшин 2026 | | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Эхний хагас жил | Жилийн эцэс | | |
| **СТРАТЕГИЙН ЗОРИЛГО 1. ГЭР БҮЛИЙГ ДЭМЖИХ, ГЭР БҮЛД ЭЭЛТЭЙ ХӨГЖИЛ ХАМГААЛЛЫН ТОГТОЛЦООГ БЭХЖҮҮЛЖ, ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЭРХ, ХӨГЖИЛ ХАМГААЛЛЫН ЧИГЛЭЛЭЭРХ ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ ШИНЭЧИЛЖ БОЛОВСРОНГУЙ БОЛГОН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАНА.** | | | | **ХҮРЭХ ҮР ДҮН:** ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ ШИНЭЧИЛЖ, ХҮН АМЫН БҮЛГҮҮДЭД ЧИГЛЭСЭН ҮЙЛЧИЛГЭЭГ ОНОВЧТОЙ ТОДОРХОЙЛЖ, ЭЭЛТЭЙ ОРЧИН БҮРДСЭН БАЙНА. | | | | |
| Зорилт.1 | Хууль тогтоомж, гэр бүл, хүн амын бүлгүүдэд чиглэсэн бодлогыг сайжруулна. | Улсын төсөв | Батлагдсан баримт бичиг /тоо/ | 0 | 0 | 4 | | ГББГ |
| 1.1. | Гэр бүлийн хөгжлийг дэмжих тухай анхдагч хуулийн төслийг боловсруулж Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлнэ.<br><br>*/ЗГҮАХ 2024-2028 2.1.1.2, ГБХНХ-ын салбарын 2025-2028 оны стратеги төлөвлөгөө Зорилт-1-1.1/* | Үйл ажиллагааны зардал | УИХ-д өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /тоо/ | 0 | 1 | 1 | Гэр бүлийн хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөлд яамдын саналыг тусган дахин боловсруулж, 2026 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн 01/1695 дугаар албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. Гэр бүлийн хөгжлийг дэмжих тухай анхдагч хуулийн төслийг боловсруулж, дагалдах хуулийн төслийн хамт 2026 оны 05 дугаар сарын 20-ны өдөр Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсэн. | 100 |
| | | | Боловсруулсан үзэл баримтлал /тоо/ | 0 | 1 | 1 | Засгийн газар шинэчлэн байгуулагдсантай холбогдуулан Гэр бүлийн хөгжлийг дэмжих тухай анхдагч хуулийн төслийн үзэл баримтлалын төслийг 2026 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр дахин батлуулсан. | |
| 1.2. | "Чанартай амьдрал-гэр бүлийн гишүүдийн оролцоо" хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлж эхэлнэ. | Улсын төсөв | Хөтөлбөрийн дагуу үйлчилгээ авсан гэр бүлийн тоо | 0 | 30,000 | 100,000 | “Чанартай амьдрал-гэр бүлийн гишүүдийн оролцоо” хөтөлбөрийг бүрэн боловсруулсан. 2026 оны 06 дугаар сарын 08-ны өдөр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын | 30 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | */ЗГҮАХ 2024-2028- 2.1.1.2, ГБХНХ-ын салбарын 2025-2028 оны стратеги төлөвлөгөө Зорилт-1-1.2/* | | | | | | яамны Төрийн нарийн бичгийн даргын шуурхай хуралдаанд танилцуулж, санал авсан. | |
| 1.3 | Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулга болон, дагалдан нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлнэ.<br><br>*/Алсын хараа 2050- 2.3.3/* | үйл ажиллагааны зардал | УИХ-д өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /тоо/ | 0 | 1 | 1 | Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн төслийн үзэл баримтлалын төслийг боловсруулж, Хууль тогтоомжийн тухай хуулийн холбогдох заалтын дагуу хянан үзэж, хамтран батлуулахаар 2026 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн 01/1749 дугээр албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн сайдад хүргүүлсэн.<br>Тайлант хугацаанд хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон түүнийг дагалдан нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийн зохицуулалтын агуулгыг хянан сайжруулж, холбогдох санал, мэдээллийг нэгтгэн ажиллаж байна. Мөн хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагын тандан судалгаа болон зардлын тооцоо, нөлөөллийн судалгааг боловсруулах ажлыг үргэлжлүүлэн хийж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна | 70 |
| | | | Боловсруулсан үзэл баримтлал /тоо/ | 0 | 1 | 1 | | |
| | | | Хавсаргасан тооцоо, судалгаа /тоо/ | 0 | 3 | 3 | | |
| 1.4 | Дохионы хэлний тухай хуулийн төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлнэ. | үйл ажиллагааны зардал | Хуулийн төсөл /тоо/ | 0 | 1 | 1 | Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2026 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн А/61 дүгээр тушаалаар Монгол дохионы хэлний тухай анхдагч хуулийн төслийг боловсруулах ажлын хэсгийг шинэчлэн байгуулсан. Ажлын хэсгийн уулзалтыг 2026 оны 04 дүгээр сарын 17-ны өдөр зохион байгуулж, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Цахим хөгжил, харилцаа холбооны яам, Эрүүл мэндийн яам, Сэргээн засах, туслах технологийн үндэсний төв, Нийслэлийн ерөнхий | 90 |
| | | | Боловсруулсан үзэл баримтлал /тоо/ | 0 | 1 | - | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | боловсролын 29 дүгээр сургууль, Монгол Улсын Боловсролын Их сургууль болон сонсголгүй иргэдийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулан санал авсан. Уулзалтаар дохионы хэлний хэлмэрч, орчуулагчийг бэлтгэх, мэргэжлийн шалгалт авах, үйл ажиллагааны зөвшөөрөл олгох, бүртгэл мэдээллийн сан бүрдүүлэх, сонсголын бэрхшээлтэй хүний мэдээлэл авах эрх, эрүүл мэнд, боловсрол, төрийн үйлчилгээ, хэвлэл мэдээлэл, цахим үйлчилгээний хүртээмжийн асуудлаар санал нэгтгэсэн.<br>Хуулийн төсөл боловсруулах хүрээнд хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсан судалгааны тайлан болон хуулийн төслийн үзэл баримтлалын төслийг боловсруулж, хамтран батлуулахаар 2026 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 01/1896 тоот албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн. Тайлант хугацаанд сонсголгүй иргэдийн төлөөлөл, төрийн болон төрийн бус байгууллага, боловсрол, эрүүл мэнд, цахим хөгжил, харилцаа холбооны салбарын байгууллагуудыг оролцуулан нийт 4 удаагийн уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулж, хуулийн төсөлд тусгах саналыг нэгтгэн ажилласан. | |
| 1.5. | Гэр бүлийн хөгжлийн цогц үйлчилгээний төвийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр байгуулж, хүн амын бүлгүүдэд чиглэсэн үйлчилгээ нэвтрүүлнэ. | Улсын төсөв | Гэр бүлийн хөгжлийн цогц төв /тоо/ | 4 | 5 | 7 | Гэр бүлийн хөгжлийн цогц үйлчилгээний төвийг 2026 оны эхний хагаст Хэнтий аймгийн Батноров, Бор-Өндөр сумдад, нийслэлийн Баянзүрх дүүргийн 12, 17, 21, 26 дугаар хороонд үргэлжлүүлэн ажиллуулж байна. Нийслэлийн Баянхошуу, Сэлбэ, | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | */ЗГҮАХ 2024-2028 2.1.1.4, 2.1.1.13, 2.1.1.15, 2.1.1.18, УХЖТ-2026-2.9.1.1, ГБХНХ-ын салбарын 2025-2028 оны стратеги төлөвлөгөө Зорилт-1-1.3/* | | | | | | Толгойт дэд төвүүдэд Бизнес инкубатор, сургалтын төвүүдэд Гэр бүлд зөвлөгөө өгөх төв, Архины хамааралтай болон эмзэг бүлгийн иргэдийн сэтгэл заслын өрөө, Хүүхдийн зөвлөл, Номын сан, цахим технологийн өрөөгөөр дамжуулан гэр бүлд сэтгэл зүй, хууль эрх зүйн зөвлөгөө, чадавхжуулах сургалтыг зохион байгуулж байна. 2026 оны 06 дугаар сарын 08-ны өдөр Сонгинохайрхан дүүргийн 28 дугаар хороонд гэр бүлд зөвлөгөө мэдээлэл, сургалт, ахуйн үйлчилгээ үзүүлэх төвийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр байгуулсан. | |
| | | | Хөвсгөл аймаг Үйлчилгээний загвар /тоо/ | 0 | 0 | 1 | 2026 онд Хөвсгөл аймагт ГБХЦҮТ-ийг байгуулахаар ДЗМОУБ-ын хамтран Хөвсгөл аймгийн “Гэр бүлийн цогц төв”-ийн үйлчилгээний загварыг боловсруулсан. Гэр бүлийн цогц үйлчилгээний төв байгуулах судалгаа хийхэд зориулсан жишиг гарын авлагыг эцэслэн боловсруулж, бусад аймаг, дүүрэгт жишиг болгон хүргүүлнэ. | |
| | | | Төвөөр үйлчлүүлсэн гэр бүлийн тоо | 0 | 30,000 | 100,000 | Гэр бүлийн боловсрол олгох сургалтыг 8 модуль 24 сэдвийн хүрээнд аймаг, нийслэл, дүүргийн хэмжээнд зохион байгуулж, 2026 оны эхний хагас жилийн байдлаар гэр бүлийн боловсрол олгох 274 “Сургагч багш”-ийг бэлтгэн 181734 (давхардсан тоогоор) иргэнийг гэр бүлийн боловсрол олгох сургалтад хамруулсан. Үүнд:<br>• Гэрлэлт, гэрлэгчдийн үүрэг хариуцлага 18632 иргэн<br>• Гэр бүл төлөвлөлт сургалтад 15257 иргэн<br>• Гэр бүлийн үнэт зүйл, угийн бичиг хөтлөлт 11776 иргэн | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | • Гэр бүлийн харилцаа, ёс зүй 33814 иргэн<br>• Гэр бүл дэх хүүхдийн хүмүүжил, хөгжил 52726 иргэн<br>• Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх 31367 иргэн<br>• Гэр бүлийн эрүүл мэнд 12756 иргэн<br>Гэр бүлийн эдийн засаг 6297 иргэн тус тус хамрагдсан байна. | |
| | | | Батлагдсан хөтөлбөрийн тоо | 0 | 0 | 2 | Монгол Улсын Засгийн Газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.1.1.13-т “Эхчүүдэд зориулсан төрөлжсөн нийгмийн цогц үйлчилгээг төр, хувийн хэвшилтэй хамтран хэрэгжүүлнэ” зорилтын дагуу Эхчүүд, эмэгтэйчүүдэд зориулсан нийгмийн үйлчилгээний цогц хөтөлбөр боловсруулж, аймаг дүүрэг бүрт байгуулахаар Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан гэр бүлийг дэмжим цогц үйлчилгээний төвөөр дамжуулан хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.<br>Тус хөтөлбөрийг боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 25 хүний бүрэлдэхүүнтэйгээр 2025 оны 10 дугаар сарын 27-ны А/284 дугаар тушаалаар батлуулсан. Ажлын хэсгийн хурлыг өнгөрсөн онд 4 удаа хуралдуулж хөтөлбөрийн ерөнхий зураглалыг боловсруулсан бөгөөд энэ онд 6 хүний бүрэлдэхүүнтэй техникийн ажлын хэсгээр нийт 6 удаа ажиллаж хөтөлбөрийн төслийг бэлэн болгоод байна. 06 сарын 16-ны өдөр ажлын хэсэгт танилцуулан эцсийн саналыг авч, хөтөлбөрийг эцэслэн батлуулахаар ажиллаж байна. Энэхүү хөтөлбөрийн зорилго нь эхчүүд, эмэгтэйчүүдийн эрүүл мэнд, | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | боловсрол, эдийн засаг, нийгмийн хамгаалал, сэтгэл зүй, хувь хүний хөгжил, гэр бүлийн боловсрол зэрэг олон талт хэрэгцээнд нь суурилсан цогц үйлчилгээг төр, хувийн хэвшил болон мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллагуудын хамтын оролцоонд тулгуурлан хүртээмжтэй, үр ашигтай хүргэх замаар тэдний бие даасан байдлыг хангах, амьдралын чанар, аюулгүй байдлыг сайжруулахад оршино.<br>Энэ хөтөлбөрийг боловсруулах ажлын хүрээнд бусад улс орнуудын эхчүүд, эмэгтэйчүүдэд чиглэсэн бодлого, арга хэмжээний талаар судлахаас гадна, Сингапур улсын “white paper” бодлогын баримт бичгийн тайлан, БНХАУ-ын эмэгтэйчүүдийн талаар баримталж буй бодлогын баримт бичиг, өмнө нь боловсруулагдаж байсан хүн амын хөгжил, гэр бүл, жендэрийн талаар баримтлах бодлогын баримт бичгүүд болон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, нийгмийн халамжийн ОНОТХҮ, Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийн хөтөлбөр 2023 зэрэг холбогдох мэдээллүүдийг судлан үзэж Бээжин 30 үйл ажилагааны хөтөлбөрт тусгагдсан зорилтуудыг хангахад чиглэсэн арга хэмжээнүүдийг төлөвлөн тусгасан болно. | |
| 1.6. | Хүүхэд хамгааллын үйлчилгээг шаардлагатай хүүхэд бүрд хүргэнэ.<br><br>*/ЗГҮАХ 2024-2028 2.1.1.5, УХЖТ 2026 2.10.1.2, ГБХНХ-ын салбарын 2025-2028 оны стратеги төлөвлөгөө Зорилт-2-2.1./* | Улсын төсөв | Хүүхэд хамгааллын кейс менежментийн үйлчилгээнд хамрагдсан хүүхэд | 69.3 хувь | 75.0 хувь | 85.0 хувь | 2026 оны эхний хагас жилийн байдлаар хүүхэд хамгааллын үйлчилгээнд 34067, давхардаагүй тоогоор 5007 хүүхдэд хамрагдсан байна. Нийт зорилтод дуудлагаас:<br>- Зөвлөгөө, мэдээлэл хүссэн дуудлага - 2320 буюу 9,85 %<br>- Шуурхай тусламжийн үйлчилгээ үзүүлсэн | 90 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | - 545 буюу 2,31%<br>- Кейс нээсэн 5463 дуудлагаас<br>- Хаасан дуудлага<br>- 3461 буюу шийдвэрлэлт 63,35%<br>- Хяналтад байгаа дуудлага<br>- 2002 буюу 36,64% буюу Кейс шийдвэрлэлт 63,35 хувьтай байна. | |
| 1.7. | Төрийн байгууллага, аж ахуйн нэгжид “Хүүхэд хамгааллын бодлого” мөрдүүлнэ.<br><br>*/ЗГҮАХ 2024-2028 - 2.1.1.5/* | Улсын төсөв | Хүүхэд хамгааллын бодлого мөрдсөн байгууллагын эзлэх хувь | 23.7 | 25 | 40 | 2026 оны хагас жилийн байдлаар улсын хэмжээнд нийт 17,771 байгууллага хүүхэд хамгааллын бодлого батлан хэрэгжүүлж байна. Хүүхэд хамгааллын бодлогоо шинээр баталсан байгууллага өссөн дүнгээр 6031, эцэг, эхийн зөвлөл байгуулсан байгууллага өссөн дүнгээр 10,349, хүүхдийн өрөө тохижуулсан байгууллага өссөн дүнгээр 1,268, хүүхдийн цэцэрлэг байгуулсан байгууллага өссөн дүнгээр 123 байгууллага байна. Нийт 2025 оны байдлаарх төр, хувийн хэвшлийн 60,657 байгууллагад харьцуулахад 29.2 хувьтай байна. Хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх арга зүйн сургалтыг байгууллага, аж ахуйн нэгжийн дэргэдэх “Эцэг эхийн зөвлөл”-ийг арга зүйн удирдлагаар хангах, эцэг эхийн зөвлөлийн гишүүдээр дамжуулан гэр бүлийн боловсрол олгох, хүүхэд хүмүүжлийн зөрөг аргыг түгээх, эцэг эхчүүдийн үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэх сургалт, нөлөөллийн ажлыг тогтмолжуулж, нийт 4394 албан хаагчийг гэр бүлийн боловсрол олгох сургалтад хамруулсан байна. | 100 |
| 1.8. | Хүүхэд хамгааллын асуудал хариуцсан ажилтнуудын ажиллах нөхцөлийг сайжруулж, нийгмийн хамгааллыг | Улсын төсөв | Батлагдсан баримт бичиг | 0 | 0 | 1 | 1.Улсын хэмжээнд нийгм<br>ийг ажилтны ажиллах нөхцөл, ажлын ачааллын судалгаа, дүн шинжилгээ хийсэн.<br>2.Нийгмийн ажлын чиглэлээр батлан мөрдөж буй хууль тогтоомж, | ХБ |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | дэмжих хөтөлбөр хэрэгжүүлнэ.<br><br>*/АХ-2.3.2 ЗГҮАХ-2.1.1.5, 2.1.1.7, УХЖТ-2026 2.10.1.3./* | | | | | | мэргэжлийн чиг үүргээ гүйцэтгэхэд тулгамдаж буй асуудал, ажиллах нөхцөлийг сайжруулах хэрэгцээг тодорхойлох зорилгоор Сайдын А/206 дугаар тушаал гарч, 4 аймаг, 4 дүүрэг сонгон, чанарын судалгаа хийж, дүгнэлт гаргасан. 3.Хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтныг чадавхжуулах, үе шаттай сургалтад хамруулах суурь судалгаа хийж, сургалтын хэрэгцээг тодорхойлох судалгааг 2026 оны 03-06 дугаар сард ГБХНХЯ-ны Гэр бүлийн бодлогын газар хийсэн. Мөн түүнчлэн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар нь “Нийгмийн ажилтны мэргэжлийн ур чадвар”-ын судалгааг 2026 оны 04 дүгээр сард авч судалгаанд 21 аймаг, 9 дүүргийн хорооны хүүхэд гэр бүлийн нийгмийн ажилтан нийт 746 буюу 89,9 хувь нь судалгаанд хамрагдсан. 4.Тус судалгаан нь 833 нийгмийн ажилтны мэргэжлийн ур чадварыг илрүүлэх, үнэлгээний арга зүй, тогтолцоонд нэмэгдүүлэх, мэргэжлийн ур чадварын дутагдалтай хэсгийг илрүүлэх, аль чиглэлийн мэргэжлийн ур чадварын сургалтын хэрэгцээг тодорхойлох, цаашид нийгмийн ажилтныг зөв үнэлэх, дэмжих зорилготой . Дээрх үндсэн гол суурь судалгаа, дүн шинжилгээний дүгнэлтэд тулгуурлан гэр бүл, хүүхэд хамгааллын асуудал хариуцсан нийгмийн ажилтан, албан хаагчдын ажлын нөхцөлийг сайжруулж, нийгмийн хамгааллыг дэмжих хөтөлбөрийн төслийг боловсруулж байна. Газрын 2026 оны батлагдсан төлөвлөгөөний дагуу 4-р | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | улиралд хөтөлбөрийн төслийг хэлэлцүүлж, батлуулна. | |
| 1.9. | “Хүүхдийн шинжлэх ухаан, технологийн парк”-ыг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд барьж байгуулах, техник эдийн засгийн үндэслэл боловсруулахад шаардагдах тооцоо, судалгаа хийнэ.<br><br>*/ЗГҮАХ-2.1.1.5, УХЖТ 2026 2.9.1.2, ГБХНХ-ын салбарын 2025-2028 оны стратеги төлөвлөгөө Зорилт-2-2.4/* | Улсын төсөв | Суурь судалгаа | 0 | 0 | 1 | Хүүхдийн хөгжлийг дэмжих шинжлэх ухаан, технологийн паркын зураг төслийг боловсруулж өгөх хүсэлтийг 2026 оны 04 дүгээр сарын 03-ны өдөр Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын Төрийн нарийн бичгийн дарга М.Баяраад “Хамтран ажиллах тухай” 02/1119 дүгээр албан бичгийг хүргүүлсэн.<br>Цаашид төслийн байршлыг тухайн аймаг, нийслэлийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан сонгох, Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлд заасны дагуу газар олголтын шийдвэрийг баталгаажуулж, зураг төслийн даалгаврыг холбогдох норм, дүрмийн дагуу боловсруулж, аймаг, нийслэлийн Ерөнхий архитектороор батлуулсны үндсэн дээр зураг төсөл боловсруулах, Барилгын тухай хуулийн 25 дугаар зүйлд заасны дагуу төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх магадлалын зөвлөлөөр заавал магадлал (экспертиз) хийлгэж, дүгнэлт гаргуулах, төслийн нийгмийн ач холбогдол, технологийн шийдлийг харгалзан байршил сонгох, зураг төслийн даалгавар боловсруулах шатанд холбогдох байгууллагуудын төлөөллөөс бүрдсэн "Ажлын хэсэг" байгуулж ажиллахаар төлөвлөсөн. | ХБ |
| 1.10. | Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр арга хэмжээ зохион байгуулна. | Улсын төсөв | Зохион байгуулсан арга хэмжээ (тоо) | 0 | 1 | 2 | 2026 онд Жайка ОУБ-д төсөл хэрэгжүүлэх санал хүргүүлж, уулзалт зохион байгуулсны үр дүнд Монгол Улсад жендэрт суурилсан хүчирхийлэлд өртөгсдийг нөхөн сэргээх болон эдийн засгийн чадавхыг бэхжүүлэх төслийн хэрэгжүүлэхээр | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | тохиролцож, төслийн хүрээгээ баталгаажуулсан. Энэ баримт бичгийн хүрээнд Япон улсаас төслийн зөвлөх 9 сард МУ-д ирж ажиллахаар боллоо. | |
| 1.11. | Хүүхэд хамгааллын салбар дундын төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлнэ. | Улсын төсөв | Батлагдсан төлөвлөгөө/тоо/ | 0 | 1 | - | Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2026 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн А/71 дүгээр тушаалаар Хүүхдийн эрх, хамгааллын салбар дундын ажлын хэсэг байгуулж, холбогдох байгууллагуудад мэдэгдсэн.<br>-Төлөвлөгөөний төсөлд тусгах саналын тухайд 2026 оны 02 сард Эрүүл мэндийн яаманд, 2026 оны 4 дүгээр сард Боловсролын яаманд танилцуулж, санал солилцсон. Мөн Хүүхдийн эрх, хамгааллын төлөвлөгөөний төслийг боловсруулсан. | 30 |
| | | | Хэрэгжилтийн хувь | 0 | 30% | 70% | | |
| 1.12. | Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн хорооноос Монгол Улсын Засгийн газарт ирүүлсэн зөвлөмжийг 2025-2031 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллана. | Улсын төсөв | Хэрэгжилтийн хувь | 0 | 20% | 30% | Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн хорооноос гаргасан зөвлөмжийг 2025-2031 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийг яамд, аймаг, нийслэлээс авч нэгтгэн боловсруулсан. Тайлант хугацаанд төлөвлөгөөний биелэлт, танилцуулга, Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт 2026 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн 01/1231 тоот албан бичгээр хүргүүлсэн.<br>Төлөвлөгөөнд тусгагдсан нийт 81 арга хэмжээнээс 25 арга хэмжээ хэрэгжсэн, 45 арга хэмжээ хэрэгжих шатандаа, 11 арга хэмжээ хэрэгжээгүй байгаа бөгөөд хэрэгжилт 30 хувьтай байна.<br>Мөн Засгийн газрын 2025 оны 160 дугаар тогтоолоор баталсан | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | төлөвлөгөөний тайлагналын хугацаа, давтамжийг Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний шинэчилсэн зохицуулалттай нийцүүлэх зорилгоор “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Засгийн газрын тогтоолын төсөл, танилцуулгыг боловсруулж, санал авахаар 2026 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн 01/1829 тоот албан бичгээр Засгийн газрын гишүүдэд хүргүүлсэн. | |
| 1.13. | НҮБ-ын Эмэгтэйчүүдийг алагчилах бүх хэлбэрийг устгах конвенцийн хэрэгжилтийн МУ-ын 11 дүгээр тайлан илтгэлтийг боловсруулж хороонд хүргүүлнэ. | ОУБ | Боловсруулсан тайлангийн тоо | 0 | 1 | - | 1/ 2025 оны 10 дугаар сарын 01-ний А/188 дугаар тушаалаар “НҮБ-ын Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай Конвенц”-ийн хэрэгжилтийн талаарх 10 дугаар тайлангийн зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулах, тайлагнах салбар дундын ажлын хэсгийг ГБХНХЯ-ны ТНБД -аар ахлуулан ажлын хэсгийн нарийн бичгийн даргаар ажиллаж байгаа бөгөөд тус ажлын хэсгийг 30 байгууллагын 45 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан. Тус ажлын хэсгийн гишүүд ХНХС-ын 2024 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн А/101 дүгээр тушаалаар батлагдсан НҮБ-ын “Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенц”-ын зөвлөмжийн 2024-2026 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг салбар салбараар нь авч нэгтгэх, мэдээллийн сан бүрдүүлэх, Зөвлөхөд шаардлагатай тоо, дата мэдээллээр хангах ажлыг амжилттай зохион байгуулж Конвенцын Хорооноос МУ-ын 10 дугаар тайлан илтгэлд ирүүлсэн 93 зөвлөмжийн хэрэгжилтийн тайлан буюу 11 дүгээр тайлан илтгэлийг боловсруулж гадаад харилцааны хэлтсийн албан хаагчдаар англи хэл дээр орчуулга хийлгэхээр 2026 оны 05 | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | сарын 25-ны өдөр хүргүүлсэн. ГХЯ-руу 2026 оны 03 сарын 04-ны 02/681 дугаар албан бичгээр Хорооноос Монгол Улсын 11 дүгээр тайлан илтгэлийг очиж хамгаалах тов, илтгэлд тавигдах шалгуур үзүүлэлт болон холбогдох бусад мэдээллийг тодруулж өгөх хүсэлтийг хүргүүлэн хариуг албан бичгээр авч тайлан боловсруулалтанд тусгасан. 2/ ЗГХЭГ-аас Засгийн газрын хуралдаанд танилцуулах байдлаар танилцуулгыг бэлтгэн тайлангийн хамт ирүүлэх чиглэл өгсөн тул 2026 оны 05 сарын 13-ны01/1630 дугаар албан бичгээр Засгийн газрын хэрэг эрхлэх газарт холбогдох бүрдүүлбэрийн хамт хүргүүлсэн. ЗГХЭГ-аас Засгийн газрын хуралдаанд танилцуулах бус хэлэлцүүлэх шаардлагатай тайлан тул яамдаас санал авч дахин ирүүл гэсэн чиглэлийг 06 сарын 02-ны өдөр өгсөн тул 01/1909 дугаар албан бичгийг яамдад хүргүүлээд байна. 2026 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн Засгийн газрын хуралдаанд танилцуулах урьдчилсан тов гараад байна. | |
| 1.14. | Хүүхдийн хөдөлмөрийг илрүүлэх заавар боловсруулж батлуулна. | Улсын болон ОУБ | Боловсруулсан баримт бичгийн тоо | 0 | - | 1 | 2025 онд зохион байгуулсан “Ахиц гарсан ч ахиад урагшлахад хүчээ нэмье!” уриан дор “Хүүхдийн хөдөлмөрт хяналтын тогтолцоог бэхжүүлэх нь” зөвлөлдөх уулзалтаас гарсан саналын дагуу Хүүхдийн хөдөлмөрийг илрүүлэх зааврыг боловсруулж, Хүүхдийн эрхийн улсын байцаагч нарт танилцуулж санал авах уулзалтыг 2026 оны 4, 5 дугаар сард тус тус зохион байгуулсан. Мөн Олон Улсын Хөдөлмөрийн байгууллагад цахим шуудангаар илгээж, санал авч байна. Хэрэгжилт 80 хувьтай. | ХБ |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1.15. | Гэмт хэрэгт холбогдсон хүүхдийг гэр бүлийн хамт нийгэмшүүлэх хөтөлбөрт хамруулна. | Улсын төсөв | Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авсан бүх хүүхэд | 0 | 100 | 200 | 1/ Улсын хэмжээнд 38 хууль зүйн хороо 494 гишүүнтэйгээр үйл ажиллагаа явуулж байна. ГБХНХЯ-аас 2026 оны 02, 04 сард аймаг, дүүргийн дарга нартай уулзалт, сургалт хийж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь хүүхэд хамгаалал, Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны үйл ажиллагааг эрчимжүүлэх чиглэлээр зөвлөмж арга зүй өгч ажилласан. Мөн Сэлэнгэ, Дорнод аймгийн Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны сургалтад цахимаар оролцож, хууль тогтоомж болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь хүүхэд хамгааллын сэдвээр сургалт орсон.<br>2/ Хүүхэд гэр бүлийн хөгжил, хамгааллын газар/хэлтэс 2026 оны хагас жилийн байдлаар Гэмт хэрэг үйлдэж хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан 280 хүүхдийг сар бүр төлөвлөгөөний дагуу нийгэмшүүлэх арга зүйн сургалтад хамруулж, аймаг, дүүргийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт тайланг сар бүр хүргэж, шүүхээс даалгасан үүргийн биелэлтийг 100 хувь хангаж ажиллаж байна. | 100 |
| 1.16. | Хүүхэд харах үйлчилгээ, өдөр өнжүүлэх үйлчилгээний хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж, эмэгтэйчүүдийн болон ганц бие эх, эцгийн хөдөлмөр эрхлэлт, асрахуйн эдийн засгийн бодлого баримтална. | Улсын төсөв | Хөдөлмөр эрхлэлт, асрахуйн эдийн засгийг дэмжих чиглэлээр хууль,эрх зүйн зохицуулалт бий болгох | 0 | - | 1 | 1. 2026 оны эхний хагас жилийн байдлаар агентлагийн А/17 дугаар тушаалын хэрэгжилтийн хүрээнд улсын хэмжээнд 99 төвд 252 хүүхэд харагч ажиллаж, нийт 1193 хүүхэд хамрагдсанаас 123 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд хамрагдсан байна. 21 мэргэжилтэнд арга зүйн сургалт, зөвлөгөө өгч, 63 иргэнийг хүүхэд харагчийн сургалтад хамруулан гэрчилгээ олгож, алслагдсан бүсийн 425, дүүргийн 768 хүүхдийг хамруулан, 88 төвд хяналт шалгалт хийж, 1 төвд торгуулийн арга | ХБ |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хэмжээ авч, 64 төвд зөвлөмж, 1 төвд албан шаардлага хүргүүлэн, 16 төвд гүйцэтгэлийн хяналт хийж, нийт 1.5 тэрбум төгрөгийн төсөв зарцуулсан байна.<br>2. Асрахуйн эдийн засгийн замын зураглал боловсруулах ажлын бэлтгэлийг ханган ажиллаж байна. Энэ хүрээнд НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөртэй хамтран тус байгууллагын санхүүжилтээр Оролцоо төслийн хүрээнд Тэргэнцэртэй иргэдийн холбоо ТББ-аар Багануур дүүрэгт амьдарч буй ХБИ болон тэдний асран хамгаалагчдын нөхцөл байдал, эрэлт хэрэгцээг тодорхойлох чанарын судалгааг хийж гүйцэтгүүлсэн. Судалгаа нь дараах агуулгыг багтаасан. Үүнд:<br>а/ Багануур дүүргийн ХБИ болон тэдний асран хамгаалагчдын нийгэм эдийн засгийн өнөөгийн байдал,<br>б/Асрахуйн урт хугацааны цалин хөлсгүй хөдөлмөр нь асран хамгаалагчдын орлого, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгааалалд хэрхэн нөлөөлдөг,<br>в/ Одоогийн эрх зүйн орчин мэдээллийн тогтолцоо нь асрахуйн эдийн засгийг дэмжихэд ямар сул тал, боломжийг илэрхийлж байна,<br>г/ МУ-ын хэмжээнд өргөтгөн хэрэгжүүлэх боломжтой “Асрахуйн эдийн засгийн хүртээмжтэй загвар” -ын бүрэлдэхүүн хэсэг, бодлогын чиглэл, үйлчилгээний багц бүхий загварыг боловсруулан гаргасан.<br>3. Азийн сан, Монфеминет Үндэсний сүлжээний зохицуулагч нартай Асрахуйн эдийн засгийн замын зураглал боловсруулах хэрэгцээ шаардлагын талаар зөвлөлдөх | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | уулзалтыг зохион байгуулж санал солилцлоо. Энэ уулзалтаар дараах ажлуудыг хийхээр тохирсон. Үүнд:<br>1. Асрахуйн эдийн засгийн замын зураглал гаргахад суурь мэдээлэл дата хэрэгтэй байгаа. Иймд асрахуйн эдийн засгийн чиглэлээр суурь мэдээлэл судалгаа хийж буй МУИС-ын багш Отгонтөгс нарын судлаачидтай санал солилцох уулзалт хийх, дутуу судалгааг гүйцээж хийлгэх тал дээр Азийн сангаас дэмжлэг үзүүлэх талаар боломж судлах<br>2. Асрахуйн чиглэлээр ажиллаж буй байгууллагуудыг оролцуулсан өндөр түвшний хэлэлцүүлэг зохион байгуулахтай холбоотой бэлтгэл ажил хангахаар боллоо." | |
| 1.17. | Хүүхдийн эрхийн конвенцын хэрэгжилтийн 6, 7 дугаар тайлан боловсруулан бэлтгэл ажлыг хангана. | Улсын төсөв | Сургалт | 0 | 1 | 2 | НҮБ-ын Хүүхдийн эрхийн хорооны тогтоол гараагүй байгаа бөгөөд Монгол Улсын тайлангийн цикл тавигдаагүй, НҮБХС -аас мөн албан бусаар асуухад “ГХЯ-аас асуухад удахгүй МУ-ын тайлангийн хуваарь хэлэлцэнэ.” гэсэн тул хугацаа хойшилсон. НҮБ-ын Хүүхдийн эрхийн хорооноос Хүүхдийн эрхийн конвенцын тайлан бичих хугацаа болон тусгай асуулт ирээгүй байна. Хугацаа болоогүй.<br>https://tbinternet.ohchr.org/_layouts/15/TreatyBodyExternal/SessionsList.aspx?Treaty=CRC | ХБ |
| | | | Удирдамж | 0 | 1 | 1 | | |
| | | | Урьдчилсан тайлан | 0 | - | 1 | | |
| 1.18. | Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлнэ. | Улсын төсөв | Эрсдэлийн үнэлгээнд шинээр хамрагдсан хүүхдийн тоо | 9953 | 6000 | 9000 | Хүүхдийг эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хүүхдэд шаардлагатай тусламж, үйлчилгээг үр дүнтэй үзүүлэх, кейс шийдвэрлэлтийг эрчимжүүлэх зорилгоор Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны А/203 дугаар тушаалаар улсын хэмжээнд “Хүүхэд | 90 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хамгааллын асуудал шийдэл” аяныг зохион байгуулсан.<br>2026 онд Хүүхэд хамгааллын асуудал шийдэл аяны хүрээнд Эрсдэлийн үнэлгээний 50 асуумжаар нийт улсын хэмжээнд 120,075 өрхийн 92,755 эрсдэлд нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлж, үнэлсэн. Үүнээс:<br>-НҮБ-ын Цогц үнэлгээний маягтын дагуу нийт 40,449 хүүхэд үнэлсэн байна.<br>Нийт илрүүлсэн эрсдэлт нөхцөлд байгаа 36,626 хүүхдэд хамгааллын үйлчилгээ үзүүлж 9,796 хүүхдэд кейс нээж, 5,639 хүүхдийн буюу 57.5 хувийг шийдвэрлэж ажилласан. | |
| 1.19. | Хүүхдийн шударга байдалд сөргөөр нөлөөлж байгаа хүчин зүйлсийг бууруулах арга хэмжээг АТГ-тай хамтран хэрэгжүүлнэ. | үйл ажиллагааны зардал | Тухайн онд сургалтад хамрагдсан зорилтот гэр бүл /тоо/ | 0 | 15 | 30 | Хүүхдийн шударга байдалд сөргөөр нөлөөлж байгаа хүчин зүйлсийг бууруулах арга хэмжээг АТГ-тай хамтран хэрэгжүүлэх хүрээнд 2026 оны 04 дүгээр сарын 09-ний өдөр Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн хамт олонтой хамтарсан уулзалтыг зохион байгуулж, санал солилцсон. 2026 оны 05 дугаар сарын 27-ны өдөр Авлигатай тэмцэх газрын Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хэлтэстэй хамтарсан уулзалтуудыг тус тус зохион байгуулсан. Мөн хүүхдийн шударга байдалд сөргөөр нөлөөлж байгаа хүчин зүйлсийг бууруулах арга хэмжээний хамтарсан төлөвлөгөө ХГБХХЕГ, АТГ хамтран баталж, хамтын ажиллагааны санамж бичиг байгуулахаар төлөвлөн ажиллаж байна. | 30 |
| | | | Хүүхдийн шударга байдлын үнэлгээний өссөн хувь | 2024 онд 4.08 хувь | 4.1-ээс доошгүй | 4.5-аас доошгүй | | |
| Зорилт.2. | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх үйлчилгээг сайжруулна. | Улсын төсөв | Үйл ажиллагаа явуулах төв (нийт тоо) | 18 | 21 | 23 | | ГББГ |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Аргачлалыг турших аймаг, дүүрэг /тоо/ | 0 | - | 4 | | |
| 2.1. | Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийг аймаг, дүүрэгт байгуулна. */ЗГҮАХ 2024-2028 -2.1.1.26, УХЖТ-2026-2.11.1.1/* | Улсын төсөв 6.000.0 | Хөгжлийн төвтэй болсон аймаг, дүүрэг (тоо) | 6 | 7 | 9 | “Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 164 дүгээр тогтоолоор Архангай, Дархан-Уул, Дорнод, Дундговь, Ховд, Хөвсгөл аймаг дахь “Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төв”-ийг байгуулсан үйл ажиллагаа эхэлсэн байна.<br>Мөн Өмнөговь аймаг орон нутгийн хөрөнгөөр Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийг барьсан бөгөөд, аймгийн Засаг даргын хүсэлтийн дагуу Засгийн газрын 2025 оны “Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 212 дугаар тогтоолоор Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын харьяанд шилжүүлж, үйл ажиллагааг нь 2026 оноос эхлүүлсэн.<br>Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжүүлэх арга хэмжээний 2.1.1.26-т “Хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн халамж, үйлчилгээний чанарыг сайжруулж, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд бүх аймаг, дүүрэгт байгуулна” гэж заасан.<br>Монгол Улсын Засгийн газар Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлийн хүрээнд 2026 онд Завхан аймаг, Баянзүрх дүүрэгт, улсын төсвийн хөрөнгөөр Өвөрхангай аймагт баригдаж буй “Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төв” 2027 онд ашиглалтад орох тул дээрх аймаг, дүүрэгт шинээр байгуулахаар Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 164 | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | дугээр тогтоолд нэмэлт оруулах тогтоолын төсөл боловсруулан яамдуудаас санал авсан. Энэхүү тогтоолын төслийг Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхээр 2026 оны 6 дугаар сарын 25 өдөр хүргүүлж, 7 дугаар сарын 1-ний өдрийн Засгийн газрын хурлаар хэлэлцүүлэхэд бэлэн болсон байна. | |
| 2.2. | Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийг дэмжих төвийг аймгийн төв, орон нутагт ажиллуулна. | үйл ажиллагааны зардал | Үйл ажиллагаа явуулах төв (тоо) | 12 | 14 | 14 | 2026 оны эхний хагас жилийн байдлаар байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийг дэмжих төвийн үйлчилгээг 11 байгууллага гэрээлэн хэрэгжүүлж, 465 хүүхэд хамрагдаж байна.<br>Тайлант хугацаанд дэмжих төвийн үйл ажиллагаанд арга зүйн дэмжлэг үзүүлэх, үйлчилгээний хэрэгжилттэй танилцах, шаардлагатай зөвлөгөө, мэдээлэл хүргэх чиглэлээр ажилласан. 2026 оны 05 дугаар сарын 11-ний өдрөөс 05 дугаар сарын 15-ны өдрүүдэд нийслэлд үйл ажиллагаа явуулж буй Гэгээн нарлаг ирээдүй, Хүүхэд эрдэнэ цэцэрлэг, Энх гэр бүл, Энэрэлийн түүчээ, Ээлтэй ертөнц, Реха сентр, Эрхэм нандин сувд, Цаг чиг цэцэрлэг зэрэг нийт 8 төвийн үйл ажиллагаатай танилцаж, бичиг баримт, хүний нөөц, хүүхдийн ирц, үйлчилгээний зохион байгуулалтын талаар зөвлөгөө, мэдээлэл өгч ажилласан.<br>Мөн дэмжих төвийн үйлчилгээний чанар, арга зүйг сайжруулах хүрээнд 2026 оны 05 дугаар сарын 24-ний өдөр “Эрхэм нандин сувд” НҮТББ-тай хамтран “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрт үеийн оролцоо, хөгжлийг дэмжих цогц арга барил” сургалтыг зохион байгуулж, эцэг эх, асран | 90 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хамгаалагч, багш, сурган хүмүүжүүлэгч нийт 60 гаруй хүнийг хамруулсан. Уг сургалтад 6 дэмжих төвийн 24 багш, ажилтан хамрагдсан байна.<br>Дэмжих төвийн үйлчилгээг иргэд, олон нийтэд таниулах, орон нутагт дэмжих төв байгуулахад дэмжлэг үзүүлэх чиглэлээр аймаг, дүүргийн Засаг дарга нарын 2026 оны гэрээнд холбогдох заалт тусгах, аймаг, дүүргийн Хүүхэд, залуучуудын хөгжил, хамгааллын газрын дарга нарын сургалтад мэдээлэл өгөх, хэвлэл мэдээллийн хэрэгслээр дэмжих төвийн үйлчилгээний талаар мэдээлэл хүргэх ажлыг зохион байгуулсан. | |
| 2.3. | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссын холбогдох дүрэм, журмыг шинэчилнэ. | үйл ажиллагааны зардал | Засгийн газрын тогтоол (тоо) | 0 | 1 | - | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссын дүрмийг шинэчлэн боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг ханган ажилласан. Тус дүрмийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх тухай албан бичгийг 2026 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 01/701 тоот албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн.<br>Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссын дүрмийг Засгийн газрын 2026 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 93 дугаар тогтоолоор шинэчлэн батлуулсан. Тус тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллах чиглэлийг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссуудад 2026 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн 02/1292 | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | тоот албан бичгээр хүргүүлж ажилласан. | |
| 2.4. | Хөгжлийн бэрхшээлийн үйлдлийн чадамжийг тогтоох олон улсын аргачлалыг туршина.<br><br>*/ЗГҮАХ 2024-2028 -2.1.1.25, ГБХНХ-ын салбарын 2025-2028 оны стратеги төлөвлөгөө -Зорилт-3-3.5/* | Улсын төсөв 50 | Туршилт хийх аймаг, дүүрэг /тоо/ | 0 | 2 | 4 | Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан хөгжлийн бэрхшээлийн үйлдлийн чадамжийг тогтоох олон улсын аргачлал /ICF/-ыг үе шаттайгаар нэвтрүүлэх зорилтын хүрээнд салбар дундын зохицуулалт, арга зүйн бэлтгэл ажлыг ханган ажилласан.<br>Тайлант хугацаанд ICF-ийн замын зураглалыг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний санал авахаар Эрүүл мэндийн яам, Боловсролын яаманд 2026 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 01/1391 дүгээр албан бичгийг хүргүүлсэн.<br>Мөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын гишүүдийг чадавхжуулах сургалтын хөтөлбөрт “Хөгжлийн бэрхшээлийн үйлдлийн чадамжийг тогтоох олон улсын аргачлалыг салбар комиссын үйл ажиллагаанд ашиглах нь” сэдвийг тусгаж, сургалт зохион байгуулах бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. | 30 |
| **СТРАТЕГИЙН ЗОРИЛГО 2. ХӨДӨЛМӨРИЙН БҮТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЖ, ЭРҮҮЛ, АЮУЛГҮЙ ОРЧИНД ХӨДӨЛМӨРЛӨХ ЭРХИЙГ ХАНГАХ, ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОН, ШИНЭЧЛЭНЭ.** | | | | **ХҮРЭХ ҮР ДҮН:** ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ ШИНЭЧИЛЖ, ЭРҮҮЛ, АЮУЛГҮЙ ОРЧИНД ХӨДӨЛМӨРЛӨХ ЭРХИЙГ ХАНГАХ. | | | | |
| Зорилт.3 | Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцааны бодлого, хууль тогтоомжийг боловсронгуй болгох замаар хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийг дэмжин, тэнцвэрийг хангах | үйл ажиллагааны зардал | Ажлын байрны захиалгын гүйцэтгэл /хувь/ | - | 20 | 25 | Жилийн турш | ХХХЭБГ |
| 3.1. | Төрийн албан хаагчдын үндсэн цалинг инфляцын түвшинтэй уялдуулан нэмэгдүүлнэ. | Улсын төсөв | Нэмэгдсэн хувь | - | - | 8 | Засгийн газраас төрийн албан хаагчийн цалин хөлсийг нэмэгдүүлэх, албан тушаалын цалингийн хэт олон сүлжээг нэгтгэх, салбар хооронд болон | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | */Алсын хараа-2050 2.6.6. ЗГҮАХ 2.1.2.7, ГБХНХ-ын салбарын 2025-2028 оны стратеги төлөвлөгөө-Зорилт-2-2.1/* | | | | | | салбар доторх цалин хөлсний зөрүүтэй байдлыг арилгахад чиглэсэн тодорхой ажлуудыг хийж ирсэн. 2026 оны хувьд өмнөх жилүүдээс онцлогтойгоор “Боловсрол, шинжлэх ухааны яам болон Монголын боловсрол, шинжлэх ухааны үйлдвэрчний эвлэлийн холбооны хооронд 2024-2026 онд байгуулсан хамтын хэлэлцээр”-ийн нэмэлт хэлэлцээрээр багш, ажилтны үндсэн цалингийн хэмжээг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 50 хувиар, “Эрүүл мэндийн салбарын 2024-2026 оны хамтын /тариф/-ын хэлэлцээр"-ийн нэмэлт хэлэлцээрээр эмч, ажилтны үндсэн цалинг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 30 хувиар, Эдийн засаг, хөгжлийн яам болон Монголын боловсрол, шинжлэх ухааны үйлдвэрчний эвлэлийн холбоо хоорондын 2026-2028 оны хамтын хэлэлцээрээр шинжлэх ухааны салбарын ажилтан, албан хаагчдын үндсэн цалинг 2026 онд 50-иас багагүй хувиар тус тус нэмэгдүүлэхээр тохиролцсон. Мөн нийслэл дэх төрийн захиргааны байгууллагын албан хаагчдын цалин хөлсийг 10-15 хувиар нэмэгдүүлэхээр болсон. Уг арга хэмжээтэй уялдуулан төрийн албан хаагчийн цалин хөлсийг тодорхой хувиар нэмэгдүүлэх хувилбар, холбогдох тооцоог тухай бүр хийсэн. Дээр дурдсан салбарын хамтын хэлэлцээрийн дагуу Засгийн газрын 2025 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 224 дүгээр тогтоолоор холбогдох сайд нарт салбарын төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн хэмжээг нэмэгдүүлэн тогтоох эрхийг олгосон. Үүний дагуу | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | холбогдох сайд нар салбарын төрийн үйлчилгээний албан хаагчдын цалин хөлсийг нэмэгдүүлэх шийдвэрийг гаргасан.<br>Тухайлбал:<br>•Боловсролын сайдын 2026 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/20 дугаар тушаалаар боловсролын салбарын багш, ажилтны үндсэн цалингийн хэмжээг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 50 хувиар нэмэгдүүлэн тогтоосон.<br>•Эрүүл мэндийн сайдын 2026 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн А/11 дүгээр тушаалаар эрүүл мэндийн салбарын эмч, ажилтны үндсэн цалингийн хэмжээг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 30 хувиар нэмэгдүүлсэн.<br>•Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засгийн, хөгжлийн сайдын 2026 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн А/10 дугаар тушаалаар шинжлэх ухааны байгууллагын албан хаагчдын үндсэн цалингийн хэмжээг 15 хувиар нэмэгдүүлсэн.<br>Мөн үндсэн цалингаас тооцдог нэмэгдэл, нэмэгдэл хөлсийг царцаасан байсныг өөрчлөн Засгийн газрын 2026 оны 135, 151 дүгээр тогтоолоор 2026 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс нэмэгдсэн цалингаас нэмэгдлийг тооцож олгохоор шийдвэрлэсэн. Түүнчлэн 2027 онд төрийн албан хаагчдын цалин хөлсийг нэмэгдүүлэх, цалин хөлсний ялгаатай байдлыг арилгах хүрээнд төрийн албан хаагчдын цалин хөлсийг боломжит хувь, хэмжээгээр нэмэгдүүлэх хувилбар, тооцоог боловсруулан Сангийн яаманд хүргүүлсэн. | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3.2. | Төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн үр дүнд суурилсан цалин хөлсний тогтолцоог бий болгох арга хэмжээний саналыг холбогдох яамд, байгууллагуудтай хамтран боловсруулна.<br>*ЗГХЭГ-аас ирүүлсэн 2026 оны ХЭГ/142 дугаар албан бичгийн 4 дэх заалт/* | үйл ажиллагааны зардал | Боловсруулсан баримт бичиг /тоо/ | 0 | - | 1 | Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2026 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн А/13 дугаар тушаал болон Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2026 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн А/88 дугаар тушаалаар хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийг тус тус шинэчлэн байгуулж, Төрийн албан хаагчийн цалин хөлс, нийгмийн баталгааны тухай хуулийн төслийн үзэл баримтлалын төслийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Сангийн сайдтай хамтран батлахаар ажиллаж байна.<br>Мөн Төрийн албан хаагчийн цалин хөлс, нийгмийн баталгааны тухай хуулийн төслийг анхдагч хуулийн төсөл хэлбэрээр боловсруулж, хуулийн төсөлтэй холбогдуулан Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, 35 хуулийн холбогдох заалтыг хүчингүй болгох тухай хуулийн төсөл болон холбогдох танилцуулга, тооцоо судалгааг боловсруулаад байна.<br>Хуулийн төсөлд төрийн албан хаагчийн цалин хөлс, нөхөх төлбөр, тусламж болон нийгмийн баталгаатай холбоотой 35 хуульд ялгаатай, харилцан адилгүй тусгагдсан заалтуудыг нэг мөр цэгцлэх, давхардлыг арилгах, шалгуур үзүүлэлт, хамрах хүрээг нэг жишигт нийцүүлэх байдлаар боловсруулаад байна. Хуулийн төсөлд:<br>•Нэгдсэн үнэлгээний системийг нэвтрүүлэн гүйцэтгэл, үр дүнг бодитой үнэлж, гүйцэтгэлийн урамшууллыг хавтгайруулан олгодог байдлыг | ХБ |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | зогсоож, үр дүнд суурилсан урамшууллыг нийт албан хаагчдын 40 хүртэл хувьд олгох;<br>•Байгууллагын гүйцэтгэл, үр дүнгийн урамшууллыг байгууллагын гүйцэтгэл 90-ээс дээш хувь үнэлэгдсэн болон төсвийг зохистой удирдаж, үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулсны үр дүнд тухайн төсвийн жилийн хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр бий болсон төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогын эх үүсвэрээр тухайн ажлын жилд бүрэн ажилласан, ёс зүйн болон хөдөлмөрийн сахилгын зөрчилгүй төрийн жинхэнэ албан хаагчид олгож болохоор тусгасан.<br>Хуулийн төслийг 2026 оны 05 дугаар сарын 25-ны өдөр Ерөнхий сайд, зөвлөхүүдэд, 2026 оны 06 дугаар сарын 08-ны өдөр Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд даргад тус тус танилцуулсан.<br>**Хугацаа хараахан болоогүй байна**. | |
| 3.3. | Төрийн зарим албан тушаалын ангилал, зэрэглэлд өөрчлөлт оруулна.<br><br>*/Алсын хараа-2050 2.6.6. МУЗГҮАХ 2.1.2.7/* | Улсын төсөв | Засгийн газрын тогтоол<br>/тоо/ | - | 1 | - | Төрийн албаны ангилал, зэрэглэл, түүнд хамаарах албан тушаалын жагсаалтад нэмэлт, өөрчлөлт оруулах дараах Засгийн газрын тогтоолын төслүүдийг боловсруулан, яамд болон холбогдох бусад байгууллагаас санал авч, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2026 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн 01/1473 дугаар албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн.<br>1.“Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн батлах тухай” Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 487 | 90 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | дугаар тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай Засгийн газрын тогтоолын төсөл;<br>2.“Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн тогтоох тухай” Засгийн газрын 2023 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн 240 дүгээр тогтоолын хавсралтыг шинэчлэн баталж, хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Засгийн газрын тогтоолын төсөл. | |
| 3.4. | Хөдөлмөрийн маргаан зохицуулалтын асуудлаар дүрэм, журмыг шинэчлэн боловсруулна.<br><br>*/ГБХНХ-ын салбарын 2025-2028 оны стратеги-Зорилт-1-1.1/* | үйл ажиллагааны зардал | Засгийн газрын тогтоол, ХНТГТҮХ-ны тогтоол<br>/тоо/ | 0 | 2 | 3 | Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт Үндэсний хорооны 2026 оны 01 дүгээр сарын 13-ны 02 дугаар тогтоолоор Хөдөлмөрийн арбитрчдын нэрсийн жагсаалтыг батлуулав. Ингэснээр улсын хэмжээнд 95 хөдөлмөрийн арбитрч хөдөлмөрийн маргаан шийдвэрлэхээр ажиллах боломжтой болсон.<br>Засгийн газрын 2023 оны 05 дугаар тогтоолоор баталсан “Хөдөлмөрийн арбитрын дүрэм”-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Засгийн газрын тогтоолын төсөл, ХНТГТҮХ-ны 2023 оны 03 дугаар тогтоолын дагуу арбитрчийн Ёс зүйн хороог байгуулахаар Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт Үндэсний хорооны тогтоолын төслийг тус тус боловсруулаад байна. 2026 оны 06-08 дугаар сард тогтоолын төслүүдийг батлуулахаар төлөвлөн ажиллаж байна. | 70 |
| 3.5. | Хөдөлмөрийн хууль тогтоомжийн асуудлаар чадавхжуулах сургалт, Хөдөлмөрийн зуучлагч, хөдөлмөрийн арбитрчид, Сум, дүүргийн хөдөлмөрийн эрхийн | үйл ажиллагааны зардал, ХЭДС ОУБ | Зохион байгуулсан сургалтын тоо | 0 | 3 | - | Хөдөлмөрийн тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай, Нийгмийн даатгалын хууль тогтоомжийн талаар зөвлөх үйлчилгээ үзүүлэх, зөвлөгөө мэдээлэл өгөх, сургалт зохион байгуулах, аж ахуйн нэгж, байгууллагад ажил олгогч, | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | маргаан зохицуулах гурван талт хорооны гишүүдийг чадавхжуулах сургалт зохион байгуулна. | | | | | | ажилтны хоорондын хөдөлмөр эрхлэлтийн харилцааг төлөвшүүлэх зорилгоор “Хөдөлмөрийн харилцааны хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж байна.<br>2026 оны 1 дүгээр улирлын байдлаар уг хөтөлбөрийн хүрээнд 18 аймаг, 7 дүүргийн 113 аж ахуйн нэгж, байгууллагыг хамруулж, сургалт мэдээлэл өгсөн байна. Мөн давхардсан тоогоор 158 зөвлөх 639 дүрэм, журам, тушаал баримт, бичиг боловсруулсан байна.<br>Монголын Үйлдвэрчний Эвлэлийн Холбоо, ХБНГУ-ын Фридрик Эбертийн Сантай хамтран “Хөдөлмөрлөх эрх” зүүн бүсийн сургалтыг 06 дугаар сарын 10-11-ний өдрүүдэд Хэнтий аймагт зохион байгуулсан. Сургалтад зүүн бүсийн нийгмийн түншлэгч талуудын нийт 60 гаруй төлөөлөл оролцож хөдөлмөрлөх эрх, хөдөлмөрийн хууль тогтоомжийн талаар мэдлэгээ нэмэгдүүлсэн. Уг сургалтад манай яамнаас хөдөлмөрийн харилцааны хууль тогтоомжийн талаар мэдээлэл өгч оролцсон.<br>Түүнчлэн 2026 оны 06 дугаар сарын 02–05-ны өдрүүдэд Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газраас зохион байгуулсан “Ажлын байрны дадлагажуулагч бэлтгэх сургалтын хөтөлбөр”-т оролцогчдод “Хөдөлмөрийн тухай хууль, хөдөлмөрийн харилцаа” сэдвээр мэдээлэл, танилцуулга хийсэн. Сургалтын хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг зохицуулсан хууль тогтоомж, хөдөлмөрийн харилцааны үндсэн ойлголт, ажил олгогч болон ажилтны эрх, үүрэг, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого, арга | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хэмжээний талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгсөн. | |
| 3.6. | Хууль тогтоомжийн тухай хуулийн 51.3-т заасны дагуу Хөдөлмөрийн хуулийн хэрэгжилтэд үр дагаврын үнэлгээ хийнэ. | үйл ажиллагааны зардал, ХЭДС ОУХБ | Ажлын даалгавар | 0 | 1 | - | Хөдөлмөрийн тухай хуулийн хэрэгжилтэд үр дагаврын судалгаа хийх тухай, ажлын даалгавар (ToR) боловсруулан 2026 оны 04 дүгээр сард Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагад хүргүүлсэн.<br>Энэ дагуу Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагаас энэ чиглэлээр дэмжлэг үзүүлж, хамтран ажиллахаар тохиролцсон бөгөөд ажлын даалгаврыг хянах үйл ажиллагаа үргэлжилж байна. | 70 |
| 3.7. | Хөдөлмөрийн харилцааны хөтөлбөрийг шинэчлэн баталж, хэрэгжилтийг хангана.<br><br>*/Алсын хараа-2050 2.6.3, 3.3, МУЗГҮАХ 2024-2028 2.1.2.10/* | ХЭДС 1.7 тэрбум төгрөг | Шинэчлэн боловсруулсан баримт бичиг /тоо/ | - | 1 | - | Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2026 оны 03 дугаар тогтоолоор “Аймаг, дүүргийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэст тухайн жилд зөвлөх үйлчилгээнд хамрагдах хүсэлт ирүүлсэн байгууллагын 30 хүртэл хувьд тухайн орон нутгийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, эмнэлгийн байгууллагын хүсэлтийг үндэслэн хамруулж болно” гэсэн нэмэлт өөрчлөлтийг Хөдөлмөрийн харилцааны хөтөлбөрт оруулж батлуулсан. Тус тогтоолыг аймаг, дүүргийн ХХҮГ-уудад хүргүүлсэн.<br>**Шинэчлэн батлуулсан хөтөлбөр-1** | 100 |
| 3.8. | Төрийн албан хаагчдын зайнаас, цахимаар, цагаар ажиллах журам боловсруулан батлуулна.<br><br>*/ЗГҮАХ 2024-2028 2.1.2.9./* | Үйл ажиллагааны зардал | Боловсруулсан баримт бичиг /тоо/ | - | 1 | - | Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Нэгдсэн Үндэстний байгууллагын Хүүхдийн Сантай хамтран “Гэр бүлд ээлтэй ажлын байрны бодлогын хэрэгжилтийн өнөөгийн нөхцөл байдал” үндэсний судалгааг 2025 оны 10 дугаар сараас | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | эхлүүлж, үр дүнг 2026 оны 3 дугаар сард хэлэлцүүлэн, танилцуулсан.<br><br>Судалгааг IRIM судалгааны хүрээлэн гүйцэтгэсэн бөгөөд уг судалгаанд төр, хувийн хэвшлийн том, жижиг, дунд аж ахуйн нэгж, байгууллага, яам, агентлаг, орон нутгийн захиргааны байгууллага зэргээс 1100 орчим ажилтан, албан хаагч хамрагдсан.<br>Үндэсний судалгааны дүн, аргачлалын төслийг үндэслэн "Төрийн албан хаагчийг зайнаас цахимаар ажиллуулахад баримтлах нийтлэг аргачлал"-ын төслийг боловсруулан яамд, Төрийн албаны зөвлөл, холбогдох бусад байгууллагаас санал авч, тусган Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн А/85 дугаар тушаалаар "Төрийн албан хаагчийг зайнаас цахимаар ажиллуулахад баримтлах нийтлэг аргачлал"-ыг батлуулсан.<br>Аргачлал -1 | |
| 3.9. | Аж ахуйн нэгж, байгууллагад зайнаас, цахимаар ажиллах хөдөлмөрийн дотоод журам боловсруулах аргачлал, зөвлөмжийг боловсруулан батлуулна.<br><br>*/МУЗГҮАХ 2024-2028 2.2.9/* | Үйл ажиллагааны зардал | Боловсруулсан баримт бичиг /тоо/ | - | 2 | - | Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, НҮБ-ын Хүүхдийн Сантай хамтран "Гэр бүлд ээлтэй ажлын байрны бодлогын хэрэгжилтийн өнөөгийн нөхцөл байдал" үндэсний судалгааг 2025 оны 10 дугаар сараас эхлүүлж, үр дүнг 2026 оны 3 дугаар сард хэлэлцүүлэн танилцуулсан. Улмаар 2026 оны 04 дүгээр сарын 15-нд эцэслэв. Тус судалгааг IRIM судалгааны хүрээлэн гүйцэтгэсэн бөгөөд уг судалгаанд төр, хувийн хэвшлийн 50 байгууллагын /том, жижиг, дунд ААНБ, яам, агентлаг/ 1100 орчим ажилтан хамрагдсан. Судалгаанаас гарсан үр дүнтэй уялдуулан "Төрийн албан хаагчийг | 30 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | зайнаас цахимаар ажиллуулахад баримтлах нийтлэг аргачлал”-ын төслийг боловсруулан яамд, Төрийн албаны зөвлөл, холбогдох бусад байгууллагаас санал авч, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн А/85 дугаар тушаалаар “Төрийн албан хаагчийг зайнаас цахимаар ажиллуулахад баримтлах нийтлэг аргачлал”-ыг баталсан.<br>Судалгааны тайлан болон “Төрийн албан хаагчийг зайнаас цахимаар ажиллуулахад баримтлах нийтлэг аргачлал”-ыг бүх аймгийн Засаг дарга нар болон Засгийн газрын гишүүдэд хүргүүлээд байна.<br>Түүнчлэн “Аж ахуйн нэгж, байгууллагад зайнаас, цахимаар ажиллах хөдөлмөрийн дотоод журам боловсруулах зөвлөмж”-ийг боловсруулан ойрын хугацаанд батлуулахаар төлөвлөн ажиллаж байна.<br>Аргачлал -1 | |
| 3.10. | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлнэ.<br><br>*/МУЗГҮАХ 2024-2028 2.1.2.11, ГБХНХ-ын салбарын 2025-2028 оны стратеги төлөвлөгөө - Зорилт-2-2.2/* | ОУ-ын төсөл хөтөлбөр | Хуулийн төсөл - 1 | - | 1 | - | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу боловсруулан хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагын урьдчилсан тандан судалгаа, хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ, хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ болон зардлын тооцооны судалгааг тус тус хийж, Олон Улсын гэрээ, конвенцын шаардлага, салбарын хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн төслийг боловсруулсан.<br>Хуулийн төслийг 2026 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжээд, | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | УИХ-д 2025 оны 05 дугаар сарын 29-ны өдөр өргөн мэдүүлсэн.<br>**Хуулийн төсөл-1** | |
| 3.11. | Ажлын байран дахь асбестийн өртөлтөөс ажилтны эрүүл мэндийг хамгаалахад мөрдөх техникийн зохицуулалтыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулна. | Үйл ажиллагааны зардал | Дүгнэлт-1<br>Засгийн газрын тогтоол-1 | - | Дүгнэлт-1 | ЗГ-ын тогтоол-1 | Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны А/97 дугаар тушаалаар батлагдсан “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандарт, техникийн зохицуулалтыг шинэчлэх 2025-2027 оны төлөвлөгөө”-ний хэрэгжилтийн хүрээнд “Ажлын байран дахь асбестийн өртөлтөөс ажилтны эрүүл мэндийг хамгаалахад мөрдөх техникийн зохицуулалт”-ын төслийг боловсруулан Стандарт, хэмжил зүйн газраас дүгнэлтийг гаргуулан, салбарын яамдаас саналыг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2026 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн 01/1166 дугаар албан бичгээр авч техникийн зохицуулалтын төсөлд тусгасан.<br>Дээрх техникийн зохицуулалтын төслийг 09 дүгээр сард багтаан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.<br>**Дүгнэлт-1** | 100 |
| 3.12. | Хязгаарлагдмал орчинд ажил гүйцэтгэхэд мөрдөх аюулгүй ажиллагааны техникийн зохицуулалтыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулна. | Үйл ажиллагааны зардал | Засгийн газрын тогтоол-1 | - | Дүгнэлт-1 | ЗГ-ын тогтоол-1 | Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны А/97 дугаар тушаалаар баталсан “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандарт, техникийн зохицуулалтыг шинэчлэх 2025-2027 оны төлөвлөгөө”-ний хэрэгжилтийн хүрээнд “Хязгаарлагдмал орчинд ажил гүйцэтгэхэд мөрдөх аюулгүй ажиллагааны техникийн зохицуулалт”-ын төслийг боловсруулан Стандарт, хэмжил зүйн газраас дүгнэлтийг гаргуулан, салбарын яамдаас саналыг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хамгааллын сайдын 2026 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн 01/1166 дугаар албан бичгээр авч техникийн зохицуулалтын төсөлд тусгасан.<br>Дээрх техникийн зохицуулалтын төслийг 09 дүгээр сард багтаан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.<br>**Дүгнэлт-1** | |
| 3.13. | ОУХБ-ын “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн суурь тогтолцооны тухай” 187 дугаар конвенцод нэгдэн орох бэлтгэл ажлын хүрээнд судалгаа хийнэ. | Үйл ажиллагааны зардал | Холбогдох судалгаа-1 | - | - | 1 | Олон Улсын хөдөлмөрийн байгууллагын “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн суурь тогтолцооны тухай” 187 дугаар конвенцод нэгдэн орох хэрэгцээ, шаардлагын тандан судалгааг ОУХБ-ын дэмжлэгтэй хийж ажиллах зөвлөхийн ажлын даалгавар боловсруулан хүргүүлсэн.<br>Дээрх судалгааны ажлыг ОУХБ дэмжин 2026 оны 09 дүгээр сараас судалгааг эхлүүлэхээр төлөвлөж байна.<br>**Хугацаа хараахан болоогүй байна.** | ХБ |
| 3.14. | Салбарын хамтын хэлэлцээрүүдийг хууль тогтоомжийн дагуу бүртгэн, мэдээллийн санг бүрдүүлнэ. | үйл ажиллагааны зардал | Салбарын хэлэлцээр /тоо/, салбар, аймаг, нийслэлийн хороод /тоо өссөн дүнгээр/ | 0 | 1 | 2 | Салбарын хамтын хэлэлцээрийн бүртгэл, хөдөлмөрийн маргаан зохицуулалтын мэдээллийн сан бүрдүүлэх талаар ажлын даалгавар (ToR) боловсруулан 2026 оны 04 дүгээр сард ОУХБ-д хүргүүлэв.<br>Энэ дагуу ОУХБ-аас энэ чиглэлээр хамтран ажиллахаар тохиролцоонд хүрсэн бөгөөд ОУХБ-ын Бээжин, Тайландын товчоотой холбогдон ажлын даалгаврыг хянуулж байна.<br>Хянах үйл ажиллагааг 2026 оны 06 дугаар сарын 19-ний хугацаанд дээрх товчооны ажилтнууд дуусгах бөгөөд 2026 оны 06 дугаар сарын 24-26-ны хооронд гурван талт семинар хийхээр төлөвлөж байна. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | -Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам болон Монголын ажилтан, албан хаагчдын үйлдвэрчний эвлэлийн холбооны хоорондын 2026-2028 оны хамтын /тариф/ хэлэлцээрийг 2026 оны 02 дугаар сарын 13-нд;<br>-Хот байгуулалт, барилга орон сууцжуулалтын яам болон Монголын барилгачдын нэгдсэн холбоо, Монголын барилгачдын үйлдвэрчний эвлэлүүдийн холбооны хооронд байгуулсан "Барилгын салбарын 2026-2028 оны гурван талт хамтын хэлэлцээрийг 2026 оны 04 дүгээр сарын 13-нд;<br>-Хот байгуулалт, барилга орон сууцжуулалтын яам болон Монголын орон сууц, нийтийн аж ахуйн үйлчилгээний ажилтны үйлдвэрчний эвлэлийн холбоо, Монголын нийтийн аж ахуйн үйлчилгээний холбоо МТББ-ын хооронд байгуулсан "Орон сууц, нийтийн аж ахуйн салбарын 2026-2028 оны гурван талт хамтын хэлэлцээрийг 2026 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр тус тус Хөдөлмөрийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2 дахь хэсэгт заасны дагуу хянан бүртгэсэн. | |
| 3.15. | ”Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай” хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлнэ.<br><br>*/Алсын хараа-2050 2.6.2, МУЗГҮАХ 2024-2028 2.1.2.1, ГБХНХ-ын салбарын 2025-2028 оны* | Үйл ажиллагааны зардал | Хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн эсэх /тийм-1, үгүй-0/ | 0 | 0 | 1 | Монгол Улсын Засгийн газрын бүрэлдэхүүн өөрчлөгдсөнтэй холбогдуулан хуулийн төслийн үзэл баримтлалыг дахин батлуулах, салбарын яамдаас дахин санал авах шаардлага үүссэн. Улмаар Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалыг ХЗДХЯ-тай хамтран 2026.05.19-ний өдрийн 1/2650 тоот албан бичгээр батлуулсан. Хуулийн төсөлд салбарын яамдаас дахин санал авахаар бэлтгэж байна. | ХБ |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | *стратеги төлөвлөгөө - Зорилт-3-3.1/* | | | | | | Хуулийн төслийг 2026 оны 3 дугаар улиралд багтаан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д өргөн барихаар төлөвлөсөн.<br>**Хугацаа хараахан болоогүй байна.** | |
| 3.16. | Бүс, орон нутгийн хөгжил болон эдийн засгийн тэргүүлэх салбарын бүтээн байгуулалтын ажлын ажиллах хүчний хэрэгцээг хангах хүрээнд хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийг тэнцвэржүүлэхтэй холбоотой бодлого, арга хэмжээг хэрэгжүүлнэ.<br><br>*/Алсын хараа-2050 2.6.17, МУЗГҮАХ 2024-2028 2.1.2.1/* | Үйл ажиллагааны зардал | Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн баримт бичгийн тоо | 0 | 0 | 2 | “Ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх тухай” дараах Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулсан: Үүнд:<br>- Нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон “Жи Эл эвентс” компани хооронд байгуулсан 2026 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 01/101 дугаартай “Нэгдсэн Үндэстний Байгууллагын Цөлжилттэй тэмцэх конвенцын Талуудын 17 дугаар Бага хурал Хөх бүс дэх түр байгууламжийг угсрах, суурилуулах, буулгах болон холбогдох бусад үйлчилгээ үзүүлэх түлхүүр гардуулах/инженерчлэл, худалдан авалт болон барилга угсралтын нөхцөлтэй (EPC) төслийн гэрээний дагуу ажиллах 100 гадаад ажилтныг ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан санал авахаар 2026 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 01/1322 дугаар албан бичгээр яамдад хүргүүлсэн.<br>- Засгийн газрын шугамаар авсан гадаадын хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжийн хүрээнд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх болон стратегийн ач холбогдол бүхий дэд бүтэц, үйлдвэрлэлийн бүтээн байгуулалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх энэ тогтоолын хавсралтад заасан 8 аж ахуйн нэгж, байгууллагын 442 гадаад ажилтныг ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх тухай Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан 2026 оны 05 | ХБ |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | дугаар сарын 19-ний өдрийн 01/1745 дугаар албан бичгээр санал авахаар яамдад хүргүүлсэн. Дээрх “Ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх тухай” Засгийн газрын тогтоолын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр 2026 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 01/1901 дугаар албан бичгээр хүргүүлсэн. "Гадаад ажилтны ажлын байрны төлбөр төлөх, хөнгөлөх, чөлөөлөх, төлбөрийн зөрүүг буцаан олгох, тэдгээрийн бүртгэлийг хөтлөх журам”-ыг шинэчлэн боловсруулж, 2026 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн 01/1503 дугаар албан бичгээр санал авахаар Сайд нарт хүргүүлсэн.<br>Засгийн газрын шугамаар авсан гадаадын хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжийн хүрээнд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх болон стратегийн ач холбогдол бүхий дэд бүтэц, үйлдвэрлэлийн бүтээн байгуулалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх 12 аж ахуйн нэгж, байгууллагын 1801 гадаад ажилтныг ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх тухай Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр 2026 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 01/1901 дугаар албан бичгээр хүргүүлсэн.<br>**Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх төсөл-2**<br>**Хугацаа хараахан болоогүй байна.** | |
| 3.17. | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээг гүйцэтгэлийн үр дүн, чанарт суурилсан байдлаар шинэчлэн | ХЭДС 106.6 тэрбум төгрөг | ХЭҮЗ-ийн тогтоол /тоо/ | 0 | 1 | - | Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2026 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн хуралдаанаар хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа, арга хэмжээтэй холбоотой ХЭҮЗ-ийн 01 дүгээр тогтоол, ХЭДС-ийн төсвийн | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | боловсруулж, хэрэгжилтийг ханган ажиллана.<br><br>*/Алсын хараа-2050 2.6.3, 3.3.1, 3.3.3, 3.3.4, МУЗГҮАХ 2024-2028 2.1.1.12, 2.1.1.17, 2.1.1.20, 2.1.1.28, 2.1.1.30, 2.1.2.3, 2.1.2.5, 2.1.2.8-9, 2.1.3.12, 2.1.3.15-16, 3.2.2.5 /* | | ГБХНХ-ын сайдын тушаал /тоо/ | 0 | 1 | - | хуваарь батлах тухай ХЭҮЗ-ийн 02 дугаар тогтоол, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих туршилтын төсөл, хөтөлбөрүүдэд нэмэлт өөрчлөлт оруулах тухай ХЭҮЗ-ийн 03 дугаар, Зорилтот өрхийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, амьжиргааг дээшлүүлэх хөтөлбөр батлах тухай ХЭҮЗ-ийн 04 дүгээр, Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр батлах тухай ХЭҮЗ-ийн 05 дугаар, Тогтоолын хэрэгжилтийг хангуулах, зөвлөмж гаргах тухай 06 дугаар, Тогтоолын хавсралтат өөрчлөлт оруулах тухай 07 дугаар тогтоолыг тус тус баталсан.<br>ГБХНХ-ын сайдын А/25 дугаар тушаалаар “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр 2026-2027 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа, хөтөлбөрийн зардлын жишиг хэмжээ”-г баталсан.<br>Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр 2026-2027 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа, хөтөлбөрийг боловсруулж, ХЭҮЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.<br>**ХЭҮЗ-ийн тогтоол-7**<br>**ГБХНХ-ын сайдын тушаал-1**<br>**Боловсруулж батлуулсан ХЭД хөтөлбөр-3**<br>**Хэрэгжилтийн тайлан, мэдээ-1** | |
| | | | Боловсруулж батлуулсан ХЭД хөтөлбөр /тоо/ | 0 | 1 | - | | |
| | | | Хэрэгжилтийн тайлан, мэдээ-1 | 0 | 1 | 2 | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3.18. | Зорилтот бүлгийн хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, ажиллах хүчний оролцоог нэмэгдүүлнэ. /2026-2027 онд хэрэгжүүлнэ/<br><br>*/МУЗГҮАХ-н 2.1.1.12, 2.1.1.17, 2.1.1.20, 2.1.1.28, 2.1.2.3, 2.1.2.5, 2.1.3.12, 2.1.2.14/* | ХЭДС<br>9.5 тэрбум төгрөг | Боловсруулж батлуулсан ХЭД хөтөлбөрийн тоо | 0 | 2 | - | Монгол Улсын Засгийн газрын Эдийн засгийг эрчимжүүлэх 300 хоногийн үйл ажиллагааны төлөвлөгөөний “Халамжаас хөдөлмөрт зорилтот хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх” арга хэмжээний хүрээнд Зорилтот өрхийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, амьжиргааг дээшлүүлэх хөтөлбөрийг боловсруулж, ХЭҮЗ-ийн 2026 оны 04 дүгээр тогтоолоор батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. 2 жилийн хугацаанд 5000 өрхийг хөтөлбөрт хамруулж, амьжиргааг дээшлүүлнэ.<br>Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын хэмжээнд 2026 оныг "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих жил" болгон зарласантай холбогдуулан "Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр"-ийг боловсруулж ХЭҮЗ-ийн 2026.01.26-ны өдрийн 05 дугаар тогтоолоор баталж, хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.<br>“Залуучуудад ээлтэй байгууллагын соёлыг сурталчлах болон байгууллагын хүний нөөцийн хөгжлийг дэмжих” хүрээнд хүний нөөц, залуу ажилтны хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэх, идэвхжүүлэх, хөгжүүлэхэд чиглэсэн SCORE хөтөлбөрийг ноос, ноолуурын болон зочлох үйлчилгээ/зочид буудлын салбарын аж ахуйн нэгж, байгууллагад нэвтрүүлэх дэмжлэгийн арга хэмжээг түншлэгч талуудтай хамтран зохион байгуулж ажиллаж байна.<br>**Боловсруулж батлуулсан ХЭД хөтөлбөр-3**<br>**Хэрэгжилтийн тайлан, мэдээ-1** | 100 |
| | | | Хэрэгжилтийн тайлан, мэдээ-1 | 0 | 1 | 2 | | |
| 3.19. | Хилийн чанадаас эх орондоо эргэн суурьших Монгол иргэдэд чиглэсэн | - | Боловсруулсан төслийн баримт бичгийн тоо | 0 | - | 1 | НҮБ-ын Олон улсын шилжих хөдөлгөөний байгууллагаас гадаадад суралцаж, ажиллаж байгаа өндөр ур | ХБ |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | цогц хөтөлбөр батлуулж хэрэгжүүлнэ.<br><br>*/ЗГҮАХ 2024-2028 2.1.2.5, 2.1.3.16, ГБХНХ-ын салбарын 2025-2028 оны стратеги төлөвлөгөө-Зорилт-5-5.4, ГБХНХЯ 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө 1.3.2.3/* | | | | | | чадвартай иргэдийг эх орондоо эргэн ирэх, хөдөлмөр эрхлэхэд нь дэмжих чиглэлээр богино хугацаанд Монгол Улсад ажиллах хоёр туршилтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа бөгөөд судалгаа, туршилтын хөтөлбөрийн ажлын даалгавартай танилцан санал хүргүүлсэн.<br>БНСУ-ын Засгийн газраас Хөгжлийн албан ёсны тусламжийн санхүүжилтээр БНСУ-д хөдөлмөрийн гэрээт ажилтнаар ажиллаж байгаад нутаг буцсан иргэдийг хөдөлмөрийн зах зээлд үр дүнтэй дахин нийгэмшүүлэхэд чиглэсэн хөтөлбөрийг Монгол Улсад хэрэгжүүлэхээр БНСУ-ын Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн яам хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүсэлтийг тус улсын Гадаад харилцааны яаманд хүргүүлэхтэй холбоотойгоор Монгол Улсын Засгийн газрын хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүсэлтэй байгаа тухай албан ёсны байр суурыг илэрхийлсэн албан бичгийг Монгол улсын Сангийн яамнаас 2026 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 03/1395 дугаар албан бичгээр Бүгд Найрамдах Солонгос Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яаманд хүргүүлсэн байгаа болно.<br>**Хугацаа хараахан болоогүй байна.** | |
| 3.20. | Бүтээмжийн мастер төлөвлөгөөний төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлнэ.<br><br>*/МУЗГҮАХ 2024-2028 2.1.2.4/* | Үйл ажиллагааны зардал | Боловсруулсан төсөл /тоо/ | - | 1 | - | Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам Азийн бүтээмжийн байгууллага, Монголын бүтээмжийн холбоотой хамтран “Үндэсний бүтээмжийн мастер төлөвлөгөө (2026–2035)”-ний төслийг боловсруулж 2026 оны 6 дугаар сард багтаан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэж байна. Энэ хүрээнд эхний | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хагас жилд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ:<br>-Үндэсний бүтээмжийн мастер төлөвлөгөөний төслийг оролцогч талуудад танилцуулах, төлөөллийг чадавхжуулах, хяналт шинжилгээ үнэлгээний ур чадвар олгох 2 өдрийн сургалтыг 2026 оны 01 дүгээр сарын 27, 28-ны өдөр зохион байгуулж, ҮСХ, ЗГХХГ, Сургалтад яам, агентлаг, МҮЭХ, МҮХАҮТ, ШУТС зэрэг 15 байгууллагын 40 гаруй төлөөлөл оролцов.<br>-“Үндэсний бүтээмжийн мастер төлөвлөгөө (2026–2035)”-ний төслийг 2026 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр Монгол Улсын Шадар сайд Х.Ганхуягт танилцуулав.<br>- Үндэсний бүтээмжийн мастер төлөвлөгөөг хэрэгжүүлэх хүрээнд бодлого боловсруулах, судалгаа шинжилгээ хийх, оролцогч талуудын чадавх бэхжүүлэх, мэдлэг түгээх үйл ажиллагааг хамтран хамтран хэрэгжүүлэхээр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Азийн бүтээмжийн байгууллага, Монголын бүтээмжийн төвтэй 3 жилийн хугацаанд хамтран ажиллах санамж бичгийг 2026 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр байгуулав.<br>-“Төлөвлөгөө батлах тухай” Засгийн газрын тогтоолын төсөл, танилцуулга, хавсралтаар батлах Үндэсний бүтээмжийн мастер төлөвлөгөөний төсөл, шалгуур үзүүлэлтийн хүснэгтийн хамт боловсруулж, ГБХНХ-ын сайдын 2026 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн 01/848 дугаар албан бичгээр Засгийн газрын гишүүд, холбогдох агентлаг болон ҮСХ, Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | газар, МҮХАҮТ, МАОЭНХ, МҮЭХ зэрэг 24 байгууллагын санал авч нэгтгэв.<br>-Үндэсний бүтээмж мастер төлөвлөгөөний төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл ажилтай холбоотой Засгийн газрын тогтоолын төсөл, танилцуулга, сайдын хэлэх үг, тогтоолын 2 хавсралт болох төлөвлөгөөний төсөл болон хяналт шинжилгээ үнэлгээний хүснэгт, танилцуулга /пресентшн/ мэдээллийг тус тус эцэслэн боловсруулав.<br>Мөн МТБ-тэй хамтран 2026 оны 06 дугаар сарын 03-10-ны өдрүүдэд яам, агентлагуудтай уулзалт хийж төлөвлөгөөний төслийн тоо мэдээллийг нягтлан ажилласан.<br>Төлөвлөгөөний төслийг Засгийн газрын 2026 оны 06 дугаар сарын 17-ны хуралдаанаар хэлэлцүүлэхээр төлөвлөж байна. | |
| 3.21. | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтын бүртгэл, мэдээлэл, шалгалтын цахим систем ашиглалтад оруулна. | Үйл ажиллагааны зардал | Цахим систем-1 | 0 | - | 1 | Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны А/130 дугаар тушаалаар баталсан “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт зохион байгуулах журам”-ын хэрэгжилтийг зохицуулах хүрээнд ХАБЭА-н сургалтын цахим системийг (https://Student.osh.gov.mn; https://Exam.osh.gov.mn) үе шаттайгаар 2026 оны 3 дугаар сард нэвтрүүлж эхэлсэн. Сургалтын цахим систем нь ХАБЭА-н сургалтын байгууллагуудын бүртгэл, сургалтын тайлан мэдээ, төгсөгчдийн мэдээлэл, сорилын цахим үнэлгээ, сургалтын хөтөлбөрийн нийцэл зэрэг мэдээллийг нэгдсэн байдлаар бүртгэх, хянах, баталгаажуулах зорилготой. Цахим системийг ашиглалтад оруулсантай холбогдуулан сургалтын байгууллагуудад системийн талаар | ХБ |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | мэдээлэл түгээх, цахим уулзалт зохион байгуулах, бүртгэлийн хүсэлтийг хянаж баталгаажуулах, улирлын тайлан мэдээг хүлээн авах, төгсөгчдийн мэдээллийг бүртгэх зэрэг ажлуудыг үе шаттайгаар хэрэгжүүлсэн байна.<br>Цаашид цахим системийн хэрэглээг тогтворжуулах, сургалтын байгууллагуудын мэдээллийг тогтмол шинэчлэх, тайлан мэдээний чанар, үнэн зөв байдлыг сайжруулах ажлууд хийгдэнэ.<br>**Цахим систем-1** | |
| 3.22. | Олон улсын түвшинд ажил олгогчийн хэрэгжүүлж буй шинэ техник, технологи, инновацийг Монгол Улсад нэвтрүүлэх, олон нийтэд сурталчлах зорилготой “Азийн хөдөлмөрийн эрүүл ахуйн олон улсын чуулган” зохион байгуулна. | ОУБ, ҮОМШӨДС | Зохион байгуулсан чуулган /тоо/ | 0 | 0 | 1 | “Азийн хөдөлмөрийн эрүүл ахуйн олон улсын чуулган”-ыг Азийн хөдөлмөрийн эрүүл ахуйчдын холбоо, Монголын хөдөлмөрийн эрүүл ахуйчдын үндэсний холбоо, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төв, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуультай хамтран зохион байгуулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.<br>Уг чуулганыг 2026 оны 09 дүгээр сарын 14-18-ны өдрүүдэд зохион байгуулахаар төлөвлөж, чуулганд гадаад дотоодоос оролцох оролцогчдын бүртгэл, эрдэм шинжилгээний материал зэргийг https://anoh2026.mn/ сайтаар дамжуулан хүлээн авч байна. Мөн чуулганы урьдчилсан хөтөлбөрийг тус сайтад байршуулаад байна.<br>Чуулганд илтгэл, мэдээлэл тавьж оролцохоор гадаад, дотоодын 70 гаруй экспертүүдээс эрдэм шинжилгээний материал ирүүлсэн байна. Уг эрдэм шинжилгээний ажлуудыг Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн | ХБ |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | төвөөс сонгон шалгаруулж, оролцуулах юм. **Хугацаа хараахан болоогүй байна.** | |
| 3.23. | “Тэрбум мод хөтөлбөр”-ийг дэмжих хүрээнд хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээнд хамрагдах иргэдийг мод тарих арга хэмжээнд хамруулна.<br><br>*/ГБХНХЯ-ны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелээгүй, цаашид үргэлжлүүлэн хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээ 2.3.1.1/* | Улсын төсөв (ХЭДС) | Мод тарих арга хэмжээнд хамрагдсан иргэн /тоо/ | - | 2000 | 3250 | Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2026 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр 2026-2027 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа (хөтөлбөр)-г баталсан. Энэ хүрээнд Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, амьдарч буй орчны нийтийн эзэмшлийн зам, талбайг сайжруулах чиглэлээр ажилгүй иргэн, ажил олоход хүндрэлтэй иргэн болон эзэмшсэн мэдлэг, туршлагадаа үндэслэн зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх, хөдөлмөр эрхлэх хүсэлтэй ахмад настныг түр ажлын байраар хангах замаар хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ. МУ-ын Ерөнхийлөгчийн санаачилгаар хэрэгжүүлж буй “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хэрэгжилтийг хангах хүрээнд байгаль орчинд ээлтэй үйл ажиллагааг дэмжих, ахмад настны оролцоог хангах, тэдний орлогыг нэмэгдүүлэх зорилгоор мод тарих, услах, арчлах, орчныг хамгаалах арга хэмжээг зохион байгуулна. Тус арга хэмжээнд 3000 иргэнийг хамруулж, ХЭДС-аас 1.8 тэрбум төгрөг зарцуулахаар төсөвлөснөөс энэ оны хагас жилийн урьдчилсан мэдээгээр 2000 орчим иргэнийг хамруулж, 535.4 сая төгрөг зарцуулсан байна. | 100 |
| 3.24. | Хөдөлмөрийн зах зээлийн бодлого, төлөвлөлтийг сайжруулах, ажиллах хүчний эрэлт, нийлүүлэлтийн уялдааг хангах зорилгоор хөдөлмөр эрхлэлтийн их өгөгдөл | Үйл ажиллагааны зардал | Боловсруулсан баримт бичиг /тоо/ | 0 | - | 1 | Хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн “И-Жоб” платформоор үзүүлж буй ажилд зуучлах үйлчилгээг ажил хайгч, ажил олгогч нарт хүртээмжтэй, хялбар хүргэх, хөдөлмөрийн гэрээг цахимаар байгуулах, хөдөлмөрийн харилцаатай | ХБ |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | суурилсан бодит цагийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн тогтолцоог хөгжүүлнэ.<br><br>*/ЗГХЭГ-аас ирүүлсэн 2026 оны ХЭГ/142 дугаар албан бичгийн 1 дэх заалт/* | | | | | | холбоотой өргөдөл, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх механизмыг бүрдүүлэх зорилгоор “И-Монгол” платформтой холбох ажлыг төлөвлөн хэрэгжүүлж байна.<br>Уг ажлын хүрээнд үйл ажиллагааны бизнес үйл явц, программ хөгжүүлэлт, бүртгэлийн маягт, гэрээний загварыг шинэчлэх ажлыг зохион байгуулахаар ГБХНХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын А/77 дугаар тушаалаар байгуулсан ажлын хэсэг ажиллаж байна.<br>Ажлын хэсэг 5 үе шат (33 заалт) бүхий төлөвлөгөөний төслийг боловсруулж, программ хөгжүүлэлтийг гүйцэтгэх тал болох “И-Монгол академи” УТҮГ-т ГБХНХЯ-ны 2026 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 02/1887 дугаар албан бичгээр хамтран батлуулахаар хүргүүлсэн ба төлөвлөгөөний дагуу дээр дурдсан үйлчилгээг 2026 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор бодит хэрэглээнд нэвтрүүлнэ.<br>Өгөгдөлд суурилсан шийдвэр гаргалтыг дэмжих, хөдөлмөрийн зах зээлийн бодлого, төлөвлөлтийг сайжруулах хүрээнд харьяа агентлаг, байгууллагуудын мэдээллийн сангуудыг үе шаттай нэгтгэн, яам, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн даатгал, нийгмийн халамж, өрхийн мэдээллийн сан, төсвийн гүйцэтгэлийн мэдээлэлд суурилсан үндсэн 6 бүлгийн 80 гаруй төрлийн өгөгдөлд шинжилгээ хийх боломжтой салбарын нэгдсэн мэдээллийн санг бүрдүүлэх ажлыг тендер шалгаруулалтаар Новел софт ХХК-тай 2025 онд гэрээ байгуулан, гүйцэтгүүлээд байна. Улмаар тус өгөгдлийн шинжилгээний хэрэгсэлд тулгуурлан хөдөлмөрийн зах зээлийн | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | эрэлт, нийлүүлэлтийн уялдааг илүү бодитой тодорхойлох, бодлого боловсруулах, хэрэгжилтийн үр дүнг үнэлэх, шийдвэр гаргалтыг нотолгоонд суурилан хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлээд байна. **Хугацаа хараахан болоогүй байна.** | |
| Зорилт.4. | Салбарын хууль тогтоомж, бодлого, стратеги, хөтөлбөр боловсруулахад судалгаа, шинжилгээ, бодлогын удирдамжаар хангах | Улсын төсөв | Арга хэмжээ /тоо/ | 0 | 2 | 3 | | ХХХЭБГ |
| 4.1. | Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын бүртгэлийн цахим системд 2021-2025 онд бүртгэгдсэн болон 2025 онд шинээр бүртгэгдсэн үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын мэдээллийг нэгтгэж, дүн шинжилгээ хийнэ. (салбараар) | Улсын төсөв | Дүн шинжилгээ | 0 | - | 1 | Сүүлийн 5 жилд буюу 2021-2025 онд бүртгэгдсэн үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын мэдээг /http://om.inspection.gov.mn, inspection.hudulmur-halamj.gov.mn/ цахим бүртгэлийн системүүдээс, 2025 онд бүртгэгдэж баталгаажсан үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын мэдээг /http://inspection. hudulmur-halamj.gov.mn цахим системээс тус тус татан авч, дүн шинжилгээ хийн, ХХХЭБГ, ХАБЭМТ-д хүргүүлсэн. Эдийн засгийн үйл ажиллагааны салбаруудаас уул уурхай, олборлолт (459 хүн), боловсруулах үйлдвэрлэл (322 хүн) тээвэр болон агуулахын үйл ажиллагаа (264 хүн), барилга (235 хүн), төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгааллын салбар (395 хүн) -т хамгийн их үйлдвэрлэлийн осол гарсан байна. Үүнээс уул уурхай, олборлолт болон барилгын салбарт нас баралт хамгийн өндөр байна. | ХБ |
| 4.2. | Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний улмаас 2016-2025 онд тэтгэвэр, тэтгэмж тогтоолгосон | Улсын төсөв | Дүн шинжилгээ /хувь/ | 0 | 45% | 55% | 2016–2025 оны үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын бүртгэлийн мэдээллийг холбогдох цахим системүүдээс /http://om.inspection.gov.mn, | 0 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | даатгуулагчдын тэтгэвэр, тэтгэмж тогтоолгосон суурь нөхцөлд ҮОМШӨДС-ийн мэдээлэлд үндэслэн судалгаа, дүн шинжилгээ хийнэ. | | | | | | inspection.hudulmur-halamj.gov.mn/ гаргаж, нэгтгэн боловсруулсан. Үүний хүрээнд үйлдвэрлэлийн осол, хурц хордлогод өртсөн иргэн болон тэдгээрийн ар гэрийн гишүүдээс ҮОМШӨДС-аас тэтгэвэр, тэтгэмж тогтоолгосон даатгуулагчдын тоо, тэтгэвэр, тэтгэмж олгож буй хугацаа, түүнд зарцуулж буй зардлын хэмжээг судлан, дүн шинжилгээг 2026 оны 3–4 дүгээр улиралд хийж гүйцэтгэнэ. | |
| 4.3. | Эрсдэлийн үнэлгээгээр их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн 1194 объектод хөдөлмөр, хөдөлмөрийн эрүүл ахуй, нийгмийн хамгааллын хяналтын чиглэлээр төлөвлөгөөт хяналт шалгалтыг зохион байгуулах, шалгалтын дүнд дүн шинжилгээ хийнэ. | Улсын төсөв | Хяналт шалгалт хийсэн объект /тоо/, /хувь/ | 0 | 30% | 37% | Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн хуралдаанаар Засгийн газрын 2025 оны 184 дүгээр тогтоолоор баталсан “2026 оны хяналт шалгалтын төлөвлөгөө” цуцлагдаж, 2026 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн 115 дугаар Салбарын хяналт шалгалтын талаар авах зарим арга хэмжээний тухай тогтоолоор албажсан.<br>Тогтоолтой холбогдуулан хөдөлмөр, хөдөлмөрийн эрүүл ахуй, нийгмийн хамгааллын хяналтын чиглэлээр худалдаа, үйлчилгээ, уул уурхай, тээвэр, боловсруулах үйлдвэрлэл, барилга, замын бүтээн байгуулалтын ажил үйлчилгээ эрхэлдэг 1194 объектод төлөвлөгөөт хяналт шалгалт хийх, уул уурхай, барилга, замын бүтээн байгуулалтын ажилд туслан гүйцэтгэх ажил үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж байгууллагуудад болон албан болон албан бус салбарт хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн байдалд хүүхдийн эрхийн улсын байцаагч нартай хамтран гүйцэтгэх урьдчилан сэргийлэх хяналт шалгалтууд цуцлагдсан.<br>Иймд гарч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлж, ажил хөдөлмөр эрхэлж буй хүний амь нас, эрүүл мэнд, | ҮБ |
| | | | Арилгасан зөрчил /хувь/ | 0 | 30% | 37% | | |
| | | | Хууль сахин мөрдөлтийн түвшин /хувь/ | 0 | 20% | 46% | | |
| | | | Эрсдэл үүсэх магадлал /хувь/ | 0 | 18% | 18% | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хөдөлмөрлөх эрхэд учруулж болзошгүй хохирол, эрсдэл, хяналт шалгалтаар илэрдэг нийтлэг зөрчлийн шалтгаан нөхцөлийг бууруулах, арилгуулах талаар 16 арга хэмжээг төлөвлөн, 2026 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 02/1415 дугаартай албан бичгээр Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар болон 21 аймаг, 9 дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэст арга хэмжээний төлөвлөгөөг хүргүүлсэн. Төлөвлөсөн 16 арга хэмжээнээс 6 арга хэмжээ бүрэн биелэгдсэн, бусад арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаа болоогүй байна. | |
| 4.4. | Албан болон албан бус салбарт хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн байдалд хүүхдийн эрхийн улсын байцаагчидтай хамтран урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх, танилцуулгад дүн шинжилгээ хийнэ. | Улсын төсөв | Хяналт шалгалт хийсэн объектын гүйцэтгэлийн хувь | - | Объектын тоо | Объектын тоо | Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн 115 дугаар Салбарын хяналт шалгалтын талаар авах зарим арга хэмжээний тухай тогтоолоор албан болон албан бус салбарт хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн байдалд хүүхдийн эрхийн улсын байцаагч нартай хамтран гүйцэтгэх урьдчилан сэргийлэх хяналт шалгалт цуцлагдсан.<br>Монгол Улсын Ерөнхий сайдын 2026 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн 10 дугаартай албан даалгаврын хүрээнд Салбарын улсын ерөнхий байцаагчийн 2026 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн 05-07/29 дугаартай удирдамжаар эрсдэл өндөртэй уул уурхай, барилга, зам, тээвэр, боловсруулах үйлдвэрлэл зэрэг салбарт төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг хийж гүйцэтгэхээр эхлүүлээд байна. Хяналт шалгалтаар уул уурхай, барилга, зам, тээвэр, боловсруулах үйлдвэрлэлийн салбарт үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагуудад насанд хүрээгүй | ХБ |
| | | | Илэрсэн зөрчил арилгалтын хувь | - | 30% | 40% | | |
| | | | Хууль сахин мөрдөлтийн түвшин (хувиар) | - | 30% | 30% | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хүний хөдөлмөр эрхлэлттэй холбоотой асуудлыг шалгаж, үйлдвэрлэлийн орчны хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг хангуулан, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ. | |
| 4.5. | Үйлдвэрлэл, үйлчилгээний салбарт болон өрхийн хэрэгцээнд зориулсан асаргаа, үйлчилгээний чиглэлээр Монгол Улсад хөдөлмөр эрхэлж буй гадаад ажилчдын хөдөлмөр эрхлэлтэд Гадаадын иргэн харьяатын газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газартай хамтран төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг зохион байгуулж, дүн шинжилгээ хийнэ. | Улсын төсөв | Хамрагдсан объектын тоо | 0 | 90 | 100 | C10 буюу өрхийн хэрэгцээнд зориулсан асаргаа, үйлчилгээний чиглэлээр хөдөлмөр эрхлүүлэх зөвшөөрлийг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газраас 2025 онд 50 аж ахуйн нэгж, байгууллага (109 гадаад иргэнд), 2026 оны 1-5 дугаар сард 26 аж ахуйн нэгж, байгууллага (45 гадаад иргэнд)-д тус тус олгосон байна. 2026 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар Монгол Улсад C10 зөвшөөрлийн хүрээнд 35 гадаад иргэн хөдөлмөр эрхэлж байна.<br>Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор баталсан "Шинэ сэргэлтийн бодлого"-ыг хэрэгжүүлэх эхний үе шатны үйл ажиллагааны хөтөлбөрийн 6.3.5, мөн 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 3.2.2.5-д заасныг тус тус хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газрын 2025 оны 113 дугаар тогтоолоор Монгол Улсад 2026 онд хөдөлмөр эрхлэх гадаад ажилтны тоонд хязгаарлалт тогтоохгүй гэж шийдвэрлэсэн. Энэхүү тогтоолд C6 буюу үйлдвэрлэл, үйлчилгээний салбарт хөдөлмөр эрхлэх гадаад ажилтны тоо хэмжээ хамаарч байна.<br>Монгол Улсын Ерөнхий сайдын 2026 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн 10 дугаартай албан даалгаврын хүрээнд хүний амь нас, эрүүл мэнд, нийтийн болон орчны аюулгүй байдалд учирч болзошгүй эрсдэл, хууль бус үйлдлээс | ХБ |
| | | | Зөрчил барагдуулалт (хувь) | 0 | 30% | 40% | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох зорилгоор төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг улсын хэмжээнд эхлүүлэх үүрэг даалгавар өгөгдсөн. Салбарын улсын ерөнхий байцаагчийн 2026 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн 05-07/29 дугаартай удирдамжаар эрсдэл өндөртэй уул уурхай, барилга, зам, тээвэр, боловсруулах үйлдвэрлэл зэрэг салбарт эрх бүхий байгууллагын шийдвэрээр төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг хийж гүйцэтгэхээр эхлүүлээд байна. Төлөвлөгөөт бус хяналт шалгалтын хүрээнд дээрх салбарт ажил хөдөлмөр эрхэлж буй гадаад ажилтны хөдөлмөр эрхлэлтийн асуудлыг хамтатган шалгана. Хяналт шалгалт 2026 оны 10 дугаар сар хүртэл үргэлжилнэ. Хугацаа хараахан болоогүй байна. | |
| Зорилт.5. | Хөдөлмөрийн аюулгүй байдал, хүний амь нас, эрүүл мэнд, орчны аюулгүй байдалд хяналт тавих эрх зүйн актыг боловсронгуй болгоно. | Улсын төсөв | Эрх зүйн акт /тоо/ | 1 | 1 | 2 | | Хөдөлмөрийн хяналтын хэлтэс |
| 5.1. | Хөдөлмөрийн хяналтын бодлогын баримт бичиг болон Хөдөлмөр, нийгмийн хамгааллын хяналтын журмыг батлуулна. | Улсын төсөв | Баримт бичиг /хувь/ | - | 50% | 100% | Хөдөлмөрийн хяналтын бодлогын баримт бичгийн төслийг 2023-2024 онд боловсруулж, нийгмийн түншлэгч талуудад 2024 оны 09 дүгээр сарын 27-ны өдөр танилцуулан, түншлэгч талуудаас ирүүлсэн саналыг бодлогын баримт бичигт тусгасан. Баримт бичгийн төсөлд 2024 онд ОУХБ-ын Хөдөлмөрийн хяналтын (LABGOV) хэлтсээс зөвлөмж ирүүлсэн. Зөвлөмжид дурдсан саналуудыг бодлогын баримт бичгийн төсөлд тусгаж ажилласан. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын | ХБ |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | төсөл, ОУХБ-ын Хөдөлмөрийн хяналтын 81 болон 129 дүгээр конвенцод нэгдэн орох тухай хуулийн төслүүдийг Монгол Улсын Их Хуралд өргөн барьсантай холбогдуулан бодлогын баримт бичгийн төслийг эцэслэн боловсруулах ажил хүлээгдэж байна. | |
| 5.2. | Гадаад ажилтны хөдөлмөр эрхлэлтийг шалгах болон иргэн хоорондын (туслах малчны, гэрийн үйлчилгээний ажилтны) хөдөлмөр эрхлэлтийн харилцааг шалгах хяналтын хуудас шинээр боловсруулна. | Улсын төсөв | Хяналтын хуудасны тоо | 0 | 50% | 100% | Хяналтын хуудас боловсруулах арга хэмжээний хүрээнд Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын Албан бус эдийн засгийг албажуулах төслийн дэмжлэгээр Удирдлагын академитай хамтран “Албан бус эдийн засагт ажиллаж байгаа ажилтны хөдөлмөр эрхлэлтийн нөхцөлд хяналт тавих нь” сэдэвт хөдөлмөрийн хяналтын улсын байцаагчдыг чадавхжуулах сургалтыг 2026 оны 5 дугаар сарын 20-21-ний өдрүүдэд зохион байгуулсан. Сургалтад яам, агентлаг, 21 аймаг, 9 дүүргийн хөдөлмөрийн хяналтын 69 улсын байцаагч хамрагдсан. Уг сургалтаар гэрийн үйлчилгээний ажилчид, туслах малчид, иргэн хоорондын хөдөлмөрийн гэрээгээр ажиллагсдын хөдөлмөр эрхлэлтийн харилцаатай холбоотой гол онцлог, шинжүүдийг тодорхойлох, хяналт шалгалтыг гүйцэтгэх онцлогийн талаарх ойлголт мэдлэгийг олгосон.<br>Мөн уг сургалтад оролцогчид бүлгээр ажиллаж, шинээр боловсруулж буй хяналтын хуудаст зайлшгүй оруулах шалгах асуумжуудыг боловсруулан, ОУХБ-ын зөвлөхөөс болон Удирдлагын академийн багш нараас арга зүйн зөвлөмж авсан. Гадаад ажилтны хөдөлмөр эрхлэлтийг шалгах болон иргэн хоорондын (туслах малчны, гэрийн үйлчилгээний ажилтны) хөдөлмөр эрхлэлтийн | 70 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | харилцааг шалгах хяналтын хуудасны төслийг 3 дугаар улиралд багтаан Сайдын тушаалаар эцэслэн батлуулна. | |
| 5.3. | Ажлын байран дахь тоосны өртөлтөөс ажилтны эрүүл мэндийг хамгаалах болон хязгаарлагдмал орчинд ажиллах аюулгүй ажиллагааны техникийн зохицуулалтын хэрэгжилтийг шалгах асуумжийг холбогдох хяналтын хуудсуудад тусгаж батлуулна. | Улсын төсөв | Хяналтын хуудасны тоо | 0 | 1 | - | Засгийн газрын 2024 оны 232 дугаар тогтоолоор баталсан "Ажлын байран дахь тоосны өртөлтөөс ажилтны эрүүл мэндийг хамгаалахад мөрдөх техникийн зохицуулалт" болон хязгаарлагдмал орчинд ажиллах аюулгүй ажиллагааны зөвлөмжийн дагуу 07.2.1 кодтой “Хөдөлмөрийн эрүүл ахуйг шалгах хяналтын хуудас”-д шалгах асуумжийг шинээр тусган шинэчлэн боловсруулж, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2026 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн А/75 дугаар тушаалаар батлуулан, хяналт шалгалтын үйл ажиллагаанд мөрдөн ажиллаж байна.<br>Шинэчлэн батлуулсан хяналтын хуудаст ажлын байран дахь тоосны өртөлтөөс ажилтны эрүүл мэндийг хамгаалах болон хязгаарлагдмал орчинд ажиллах аюулгүй ажиллагааны техникийн зохицуулалтын хэрэгжилтийг шалгах асуумжийг тус тус багтаан батлуулсан болно. | 100 |
| 5.4. | Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх дүрмийг шинэчлэн боловсруулна.<br><br>*/ГБХНХЯ-ны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелээгүй, цаашид үргэлжлүүлэн хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээ 4.3.2.1/* | ҮОМШӨДС | Шинэчлэн боловсруулсан дүрмийн төсөл /тоо/ | 0 | - | 1 | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх, хянан баталгаажуулахтай холбоотой зохицуулалтуудыг нарийвчлан тусгасан.<br>Хуулийн төслийг 2026 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжээд УИХ-д 2025 оны 05 дугаар сарын 29-ны өдөр өргөн мэдүүлсэн. | ХБ |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 5.5. | Шинээр томилогдсон улсын байцаагчдыг чиглүүлэх, мэргэшүүлэх сургалт зохион байгуулна. (Улаанбаатар хотод) | Улсын төсөв | Сургалтын тоо | 0 | - | 1 | Шинээр томилогдсон хөдөлмөрийн болон эрүүл ахуйн хяналтын улсын байцаагчдад яамны бодлого үйл ажиллагааг танилцуулах, эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг төлөвлөх, зохион байгуулах, чиг үүргээ хэрэгжүүлэхэд анхаарах асуудлаар чадавхжуулах сургалтыг 2026 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр зохион байгуулсан. Сургалтад 2023-2025 онд шинээр томилогдсон хөдөлмөр, хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын 32 хяналтын улсын байцаагчид хамрагдсан. | 100 |
| **СТРАТЕГИЙН ЗОРИЛГО 3. НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ ШИНЭЧИЛЖ, БОЛОВСРОНГУЙ БОЛГОЖ, НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭ, АСАРГААНЫ ХУВИЛБАРТ ҮЙЛЧИЛГЭЭГ ХӨГЖҮҮЛЖ, ХУВИЙН ХЭВШИЛ, ОРОН НУТАГ, ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГЫН ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЭН НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛНА.** | | | | **ХҮРЭХ ҮР ДҮН:** НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ ЗОРИЛТОТ БҮЛЭГТ ЧИГЛҮҮЛЖ, ТЭДНИЙ ХЭРЭГЦЭЭНД НИЙЦСЭН ҮЙЛЧИЛГЭЭГ ҮЗҮҮЛЭХ ЗАМААР ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛНЭ. | | | | |
| Зорилт.6. | Нийгмийн халамжийн үйлчилгээний хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгож, халамжийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна. | үйл ажиллагааны зардал | Боловсруулсан, батлуулсан баримт бичиг /тоо/ | - | 14 | 7 | | НХБГ |
| 6.1. | Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлнэ.<br><br>*/Алсын хараа-2050 3.1.4, МУХТЖҮЧ 2021-2025 3.1.3, МУЗГҮАХ 2024-2028, ГБХНХ-ын салбарын 2025-2028 оны стратеги төлөвлөгөө Зорилт-1-1.1/* | Үйл ажиллагааны зардал | Өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /тоо/ | 0 | 0 | 1 | Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг эцэслэн боловсруулж, Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх зөвшөөрөл хүссэн албан бичгийг 2025.05.18-ны өдрийн 01/1718 дугаар албан бичгээр Сангийн яаманд, мөн өдрийн 01/1717 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд тус тус хүргүүлсэн.<br>Хууль зүй, дотоод хэргийн сайд С.Амарсайханаас 2026.05.19-ний өдрийн 1/2642 дугаар албан бичгээр, Сангийн сайд З.Мэндсайханаас 2026.05.19-ний өдрийн 01/5603 дугаар | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | албан бичгээр тус тус Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх зөвшөөрөл ирүүлсэн.<br>Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу Нийгмийн халамжийн тухай хуулийн төслийн иж бүрдлийг ханган Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхээр бэлтгэж, 2026.05.19-ний өдрийн 01/1734 дүгээр албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. Хуулийн төслийг 2026.05.20-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсэн. | |
| | | | Боловсруулсан баримт бичиг /тоо/ | 0 | 10 | - | Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Засгийн газар, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхэд шаардлагатай дараах баримт бичгийг боловсруулсан. Үүнд:<br>1. Хуулийн төслийн үзэл баримтлал;<br>2. Нийгмийн халамжийн тухай хуулийн төсөл;<br>3. Дагалдах 23 хуулийн төсөл;<br>4. Хуулийн төслийн товч танилцуулга;<br>5. Хуулийн төслийн дэлгэрэнгүй танилцуулга;<br>6. Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн судалгааны тайлан;<br>7. Хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ;<br>8. Хуулийн төсөл хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо;<br>9. Хэлэлцүүлгийн тайлан /Олон нийт, холбогдох бусад байгууллага, иргэд/;<br>10. Олон улсын туршлагын мэдээлэл;<br>11. Бодлогын зөвлөмжийн нэгтгэл болон хуулийн төслийн | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хэлэлцүүлэгт шаардлагатай бусад материал.<br>Баримт бичгийг Хууль тогтоомжийн тухай хууль болон бусад баримт бичигт заасан шаардлагад нийцүүлэн боловсруулж, Монгол Улсын Их Хуралд өргөн барихад бэлэн болсон. | |
| 6.2. | Нийгмийн халамжийн үйлчилгээний хэрэгжилтийг зохион байгуулах хүрээнд Засгийн газрын тогтоолоор журмыг шинэчлэн батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллана. | үйл ажиллагааны зардал | Боловсруулж батлуулсан журам /тоо/ | 0 | 1 | - | Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж олгох процессыг хялбарчлах, иргэдийн санал гомдол, төлөвлөгөөт хяналт шалгалтын дүгнэлт болон Хүүхэд хамгааллын тухай хуулийг дагаж Нийгмийн халамжийн тухай хуульд орсон нэмэлт, өөрчлөлт зэрэгт үндэслэн Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн хугацаа, олгох журамд нэмэлт өөрчлөлт оруулан Засгийн газрын 2026 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн 31 дүгээр тогтоолоор батлууллаа. Журамд:<br>✓ байнгын асаргаа шаардлагатай эсэхийг тогтоох, сунгахдаа иргэнийг биечлэн ирүүлэхгүйгээр нотлох баримт бичигт үндэслэх эсхүл цахим хэлбэрээр шийдвэрлэх,<br>✓ гадаад улсад байгаа, отор хийж байгаа малчин өрхийн гишүүн болон байнга оршин суудаг газраас өөр орон нутагт эмчлүүлж байгаа хүнийг биечлэн ирүүлэхгүйгээр мэдээлэл, технологийн шийдлийг ашиглан байнгын асаргаа шаардлагатай эсэх болон хугацааг тогтоож, сунгах,<br>✓ төрөлжсөн асрамжийн газарт асруулж байгаа хүүхдийн нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийг банканд хадгалах, насанд хүрэх, асрамжаас гарах, нас барахад хүлээлгэн өгөх, хяналт тавих, | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | ✓ иргэдийн санал, гомдол, хүсэлтийг хүлээн авах, сэтгэл ханамжийг үнэлдэг болгох, тэтгэвэр, тэтгэмжид хамрагдсан иргэнийг үнэн зөв тогтоосон эсэхэд хийх хөндлөнгийн болон олон нийтийн хяналт, шалгалтыг зохион байгуулах зэрэг агуулгыг тусган батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Батлагдсан журмын нэмэлт өөрчлөлтийг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар, Эрүүл мэндийн яам, Хүүхэд гэр бүлийн хөгжил хамгааллын ерөнхий газарт албан бичгээр хүргүүлсэн. | |
| 6.3. | Халамжаас-хөдөлмөрт ядуурлыг бууруулах зорилтын хүрээнд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих замаар 5000 өрхийн амьжиргааг дээшлүүлэх хөтөлбөрийг орон нутгийн удирдлагатай хамтран улсын хэмжээнд хэрэгжүүлнэ. | үйл ажиллагааны зардал | Амьжиргаа дээшилсэн өрх /тоо/ | 0 | - | 1500 | Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2026 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор батлуулсан “Зорилтот өрхийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, амьжиргааг дээшлүүлэх хөтөлбөр”-ийг улсын хэмжээнд хэрэгжүүлж байна. Хөтөлбөрийн хүрээнд дараах ажлыг зохион байгуулсан. Үүнд:<br>1.“Зорилтот өрхийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, амьжиргааг дээшлүүлэх хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх чиглэлийг Аймаг, нийслэлийн Засаг даргад Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2026 оны 01/760 тоот албан бичгээр хүргүүлсэн.<br>2.“Зорилтот өрхийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, амьжиргааг дээшлүүлэх хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэхэд нэгдсэн удирдлага арга зүйгээр хангах удирдах хороог ГБХНХ-ын сайдын тушаалаар байгуулсан.<br>3.Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2026 оны 01/1012 тоот албан бичгээр “Зорилтот өрхийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, | ХБ |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | амьжиргааг дээшлүүлэх хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэхэд 2026 оны төлөвлөгөөг боловсруулан удирдах хороогоор батлуулсан.<br>4.Хөтөлбөрийн 2026 оны ймаг, нийслэл, дүүргийн Засаг даргад хүргүүлж, улмаар ГБХНХЯ-аас 21 аймаг, 9 дүүргийн орлогч дарга, нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга, хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын дарга болон холбогдох албан хаагчдад хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэхэд гол оролцогч байгууллагуудын удирдлагуудыг нэгдсэн мэдээллээр хангах, арга зүйн дэмжлэг үзүүлэх зорилгоор цахим болон болон танхим хосолсон уулзалтыг зохион байгуулсан.<br>5.Хөтөлбөрийн хүрээнд ХХҮЕГ-аас Нийслэлийн 9 дүүргийн ажлын хэсгийн гишүүдийг чадавхжуулах сургалтыг тавдугаар сард зохион байгуулсан. Цаашид орон нутгийн түвшинд бүсчилсэн сургалтыг зохион байгуулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.<br>“Зорилтот өрхийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, амьжиргааг дээшлүүлэх хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлыг нэгдсэн удирдлага, зохион байгуулалт, арга зүйгээр хангах зорилгоор Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2026 оны А/51 тоот тушаалаар “Удирдах хороо”-г байгуулсан.<br>Удирдах хороо нь хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт тавих, холбогдох байгууллагуудын уялдаа холбоог хангах, бодлого арга зүйн чиглэлээр нэгдсэн удирдамж өгөх чиг үүрэгтэйгээр ажиллаж байна. | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Удирдах хорооны анхдугаар хурлыг 2026 оны 03 дугаар сарын 13-ны өдөр зохион байгуулж, хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, зорилтот өрх сонголт, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний төлөвлөлт, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар хэлэлцэн шийдвэрлэсэн.<br>Удирдах хорооны хурлаар “Зорилтот өрхийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, амьжиргааг дээшлүүлэх хөтөлбөр”-ийг 2026 онд хэрэгжүүлэх нэгдсэн төлөвлөгөөг хэлэлцүүлэн баталж, хэрэгжилтийг хангах хүрээнд календарчилсан төлөвлөгөөг гарган хэрэгжүүлж байна.<br>Хөтөлбөрийг орон нутагт жигд, үр дүнтэй хэрэгжүүлэх зорилгоор Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2026 оны 01/1012 тоот албан бичгээр “Зорилтот өрхийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, амьжиргааг дээшлүүлэх хөтөлбөр”-ийг төлөвлөгөөг аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга нарт хүргүүлсэн.<br>Мөн ГБХНХЯ-аас 21 аймаг, 9 дүүргийн Засаг даргын орлогч, нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга, хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын дарга нар болон холбогдох албан хаагчдыг хамруулан хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулахад гол оролцогч байгууллагуудын удирдлагуудыг нэгдсэн мэдээллээр хангах, арга зүйн зөвлөмж, дэмжлэг үзүүлэх зорилгоор цахим болон танхим хосолсон уулзалт, сургалтыг үе шаттайгаар зохион байгуулан ажиллаж байна. | |
| 6.4. | Орлогыг орлуулан тооцох аргаар өрхийн амьжиргааны түвшинг | үйл ажиллагааны зардал | Боловсруулсан аргачлал /тоо/ | 0 | - | 1 | Өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох аргачлалыг шинэчлэх ажлын хүрээнд Үндэсний статистикийн хороо, Дэлхийн банктай хамтран | ХБ |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | тодорхойлох аргачлалыг шинэчлэн батлуулна. | | | | | | ажиллаж байна. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Үндэсний статистикийн хорооны даргын хамтарсан тушаалаар “Өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох аргачлалыг шинэчлэх ажлын хэсэг”-ийг байгуулж, ажлын хэсгийн уулзалтыг 3 удаа зохион байгуулсан. Уг уулзалтаар аргачлал шинэчлэх ажлын явцын талаар оролцогч талууд мэдээлэл солилцож, цаашдын хамтын ажиллагаа, уялдаа холбоог хангах чиглэлээр санал солилцож ажилласан. Мөн Дэлхийн банк болон холбогдох зөвлөхүүдтэй хамтран олон улсын туршлага, арга зүйн шийдлүүдийг судлан нэвтрүүлэх, шалгуур үзүүлэлт болон тооцооллын аргачлалыг боловсронгуй болгох ажлыг хэрэгжүүлж байна. Уг ажлын хүрээнд Дэлхийн банкны гэрээт зөвлөхийг шаардлагатай дата, мэдээллээр хангах, холбогдох дэмжлэг үзүүлэх асуудлаар Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газарт албан бичиг хүргүүлсэн.<br>Түүнчлэн аргачлалыг ашиглах явцад тулгарч буй асуудал, хүндрэл бэрхшээл, цаашид шинэчлэлд тусгах саналыг аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газруудаас авч, нэгтгэн Үндэсний статистикийн хороонд албан бичгээр хүргүүлсэн.<br>Аргачлалыг шинэчлэхэд шаардлагатай дата, мэдээллийг Нийгмийн даатгалын ерөнхий газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас албан бичгээр авч, датаг нэгтгэх, цэвэрлэх, эхний үнэлгээ хийх ажлуудыг хийж гүйцэтгэж байна. Цаашид аргачлалыг | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 2026 оны хоёрдугаар хагаст шинэчлэн батлуулахаар ажиллаж байна. | |
| 6.5. | Төрөлжсөн асрамжийн үйлчилгээний холбогдох журам, дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах, санхүүжилт олгох аргачлалыг шинэчилнэ. | үйл ажиллагааны зардал | Нэмэлт, өөрчлөлт оруулсан шийдвэр /тоо/ | 0 | - | 1 | Төрөлжсөн асрамжийн үйлчилгээний холбогдох журам, дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах, санхүүжилт олгох аргачлалыг шинэчлэх хүрээнд ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, эрсдэлт нөхцөлд байгаа 0-18 хүртэлх насны хүүхдийн төрөлжсөн асрамжийн үйлчилгээний холбогдох багц журмуудын хэрэгжилтийн байдалд тулгамдаж буй асуудал, өөрчлөлт оруулах саналыг авах зорилгоор яамнаас 2026.03.16-ны өдрийн “Санал ирүүлэх тухай” 02/857 дугаар албан бичгийг ХХҮЕГ, ХГБХХЕГ-т хүргүүлсэн. Үүний дагуу улс, орон нутаг, хувийн хэвшлийн асрамжийн газруудын саналыг нэгтгэн авч холбогдох журмуудад нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг боловсруулаад байна. Мөн 2026.04.16-ны өдрийн 02/1294 дүгээр албан бичгээр ХГБХХЕГ-т, 02/1289 дүгээр албан бичгээр ХХҮЕГ-т харьяа асрамжийн газруудаас асруулагчийн зардлын норм, нормативыг нэмэгдүүлэх, шинэчлэх тооцоо судалгааг хэрэглээний үнийн индексийн өөрчлөлт болон хүнс, өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний зах зээлийн бодит ханштай уялдуулсан тооцоо, судалгааг үндэслэлтэй гаргуулан нэгтгэн нягталж ирүүлэх чиглэл өгсөн. | ХБ |
| 6.6. | Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний холбогдох журамд нэмэлт, өөрчлөлт оруулна. | үйл ажиллагааны зардал | Нэмэлт, өөрчлөлт оруулсан шийдвэр /тоо/ | 0 | 1 | - | Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2026 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн А/16 дугаар тушаалаар “Тушаалын хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулах тухай” шинэчлэн батлуулсан. “Тушаалын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” тушаалын | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | талаар Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ нь Нийгмийн халамжийн тухай хуулийн 18 дугаар зүйлд заасан үйлчилгээг зорилтот бүлгийн өрх иргэнд иргэн, аж ахуйн нэгж, ТББ аар гэрээлэн гүйцэтгүүлдэг үйлчилгээ юм. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг үзүүлэх явцад 2025 онд зарим хүндрэлтэй асуудлууд гарсан тул үүсэж буй нөхцөл байдлын талаарх мэдээллийг 21 аймаг, 9 дүүргийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар, хэлтсээс авч, саналыг нэгтгэн дүгнэсний үндсэн дээр үйлчилгээний үнэ тарифыг шинэчлэн боловсруулсан. Ингэхдээ өмнө хэрэгжүүлж байсан жишиг үнэ, Хүүхэд хамгааллын үйлчилгээний баримталж байгаа жишиг үнэ, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн дэмжих төвийн жишиг үнэ, ахмадын идэвхтэй насжилтыг дэмжих болон асаргааны хувилбарт үйлчилгээний жишиг үнэ, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ, нэг цагийн сургалтын хөлс, зөвлөгөө өгөх үйлчилгээ зэргийн зах зээлийн өртөг үнийг судлан харьцуулж, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газраас ирсэн санал дээр үндэслэн, уулзалт, хурлууд хийж эцэслэн тооцон гаргасан болно. А/16 дугаар тушаалаар “Тушаалын хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулах тухай” батлагдсан журмын хэрэгжилтийг ханган ажиллах чиглэлийг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газарт 2026 оны 01 дүгээр сарын 29-ны өдрийн 01/245 дугаартай албан бичгээр хүргүүлж ажилласан. | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 2026 онд олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг хэрэгжүүлэхээр нийт 20 аймаг, 9 дүүрэгт 111 багцад 4.7 тэрбумын гэрээ хийхээр тендер зарлагдсан бөгөөд эхний хагас жилийн байдлаар 78 багцад 3.6 тэрбум төгрөгийн гэрээ байгуулан ажиллаж байна. Одоогоор 371,620,000.0 төгрөгийн санхүүжилт олгосон бөгөөд тарифын шинэчлэлтэй холбогдуулан нийгмийн халамжийн нэгдсэн e-halamj систем дээр хөгжүүлэлт хийлгэхээр ажлын даалгаврыг боловсруулан Санхүүгийн мэдээллийн технологийн төвд хүргүүлж, системийн туршилтын шатанд явж байна.<br>Шинэчлэгдсэн үнэ тариф болон нийгмийн халамжийн нэгдсэн “e-halamj” системийн хөгжүүлэлттэй холбоотой аймаг, дүүргийн мэргэжилтнүүдийг чадавхжуулах, тэдэнд мэдээлэл, зөвлөгөө өгч, мэргэжил арга зүйн зөвөлгөө өгч, санал солилцож ажилласан. | |
| 6.7. | Байнгын асаргаа шаардлагатай ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг тодорхойлох шалгуур үзүүлэлт, өвчин гэмтлийн жагсаалтыг шинэчлэн батлуулна. | үйл ажиллагааны зардал | Батлагдсан тушаал /тоо/ | | | | Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.1.1.25-д Хөгжлийн бэрхшээлийн үйлдлийн чадамжийг тогтоох олон улсын аргачлалыг үе шаттайгаар нэвтрүүлж, салбар дундын нийгмийн үйлчилгээний нэр төрөл, хүртээмжийг нэмэгдүүлж, мэдээллийн тэгш байдлыг хангаж ажиллахаар туссаны хүрээнд ХБИ-нийг илүү үйлдлийн чадамжид зарим шалгуурыг нийцүүлэх, тодорхой болгох зорилгоор Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2025 оны 12 дугаар сарын 12-ны А/233 дугаар тушаалаар "Байнгын асаргаа шаардлагатай ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэний өвчин, гэмтлийн | ХБ |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | 0 | - | 1 | жагсаалт", "Байнгын асаргаа шаардлагатай ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй насанд хүрсэн иргэнийг үнэлэх шалгуур, үзүүлэлт"-ийг шинэчлэн боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг Эрүүл мэндийн яамны дэргэдэх мэргэжлийн салбар зөвлөлийн төлөөлөл, эмч, мэргэжилтнүүд, яам, агентлагын холбогдох асуудал хариуцсан албан хаагчид оролцуулан байгуулсан. Ажлын хэсгийн хурлыг 2026 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр хуралдуулсан бөгөөд хурлаар ажлын хэсгийн ажиллах төлөвлөгөөг хэлэлцүүлэн баталж, ажлын хэсгийн дарга гишүүдэд төлөвлөгөөнд туссаны дагуу үүрэг чиглэл өгсөн. Үүний дагуу дотоодын зөвлөхийн боловсруулсан эхний шатны тайлан, саналыг ажлын хэсгээр хэлэлцүүлэхээр бэлтгэл ажил хангаж байна. | |
| 6.8. | Нийгмийн халамжийн сангаас ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүнд олгох протез, ортопед, тусгай хэрэгслийн жагсаалт, жишиг үнийг шинэчлэх төсөл боловсруулж, тооцоо судалгаа хийнэ. | үйл ажиллагааны зардал | Боловсруулсан тогтоол, тооцоо /тоо/ | 0 | - | 1 | Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 3.1.10-т "Нийгмийн халамжийн тусламж, дэмжлэг, үйлчилгээг хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээнд нийцүүлж, амьжиргааг нь дээшлүүлэхэд чиглүүлнэ";<br>Мөн Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 26 дугаар зүйлд ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд олгох протез, ортопед болон тусгай хэрэгслийн үнийн хөнгөлөлтийг нийгмийн халамжийн сангаас олгох журам, хэмжээг тус тус заасан.<br>Түүнчлэн хэрэглээний үнийн өсөлт, хөгжлийн бэрхшээлийн ялгаатай байдал, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн | ХБ |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | эцэг, эхийн төлөөлөл, ТББ-аас ирүүлсэн санал, хүсэлт болон шинэ дэвшилтэт технологиор тусгай хэрэгслийн бүтээгдэхүүнүүд шинэчлэгдэж байгаатай холбогдуулан протез, ортопедийн болон тусгай хэрэгслийн жагсаалт, жишиг үнийг шинэчлэх шаардлага бий болж байна.<br>Иймд Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх нийгмийн халамжийн үйлчилгээ, жишиг үнийг оновчтой тодорхойлох хүрээнд "Хөгжлийн бэрхшээлтэй хүнд тусламж, хөнгөлөлт үзүүлэх журам"-д нэмэлт, өөрчлөлт оруулах болон "Нийгмийн халамжийн сангаас олгох протез, ортопедийн болон тусгай хэрэгслийн жагсаалт, жишиг үнэ шинэчлэн тогтоох тухай" Засгийн газрын тогтоолын төслийг шинэчлэн боловсруулах зорилгоор Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2026 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн А/47 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулан ажиллаж байна.<br>Ажлын хэсгийн хурлыг 2026 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр хуралдуулсан бөгөөд хурлаар ажлын хэсгийн ажиллах төлөвлөгөөг хэлэлцүүлэн баталж, ажлын хэсгийн дарга гишүүдэд төлөвлөгөөнд туссаны дагуу үүрэг чиглэл өгсөн. Үүний дагуу дотоодын зөвлөхийн боловсруулсан эхний шатны тайлан, саналыг ажлын хэсгээр хэлэлцүүлэхээр бэлтгэл ажил хангаж байна. | |
| 6.9. | "Ажилтныг тэтгэвэрт бэлтгэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх арга зүй, төлөвлөгөөний жишиг | үйл ажиллагааны зардал | Шинэчлэн батлагдсан тушаал /тоо/ | 0 | - | 1 | Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 11 дүгээр хуралдааны тэмдэглэлийн 2 дахь хэсэгт "Ахмад настны талаар 2026-2028 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай" | ХБ |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | загвар"-ыг шинэчлэн батлуулна. | | | | | | Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж, холбогдох байгууллага, иргэдийн саналыг авч, Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхийг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдад үүрэг болгосон. Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн дагуу ахмадын байгууллагын удирдах ажилтнууд, ахмад настнуудын төлөөлөлтэй хийсэн уулзалтад "Ахмад настны талаар хэрэгжүүлэх арга хэмжээний 2026-2028 оны төлөвлөгөө"-ний төслийг боловсруулан танилцуулж саналыг авч тусгасан. Уг төлөвлөгөөний төслийн Үйл ажиллагаа 47-д "Ажилтныг тэтгэвэрт бэлтгэх жишиг хөтөлбөрийг шинэчлэн батлуулах" ажлыг яам, Монголын ахмадын холбоо хамтран батлуулахаар тусган боловсруулсан.<br>"Төлөвлөгөө батлах тухай" Засгийн газрын тогтоолын төсөл, танилцуулгад санал авах тухай авах тухай 2026 оны 05 дугаар сарын 26-ны өдөр 01/1835 дугаар албан бичгийг хүргүүлсэн. | |
| 6.10. | Ахмад настны идэвхтэй насжилтыг дэмжих болон асаргааны хувилбарт үйлчилгээ үзүүлэх төрийн бус байгууллага, ажилтан, хөдөлмөр халамжийн төв, орон нутгийн байгууллагын мэргэжилтнүүдийг чадавхжуулна. | Олон улсын байгууллага | Зохион байгуулсан сургалт /тоо/ | 0 | 2 | 3 | Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар ахмад настны цогц үнэлгээ, хэрэгцээ, шаардлагад суурилсан идэвхтэй насжилтыг дэмжих төвийн үйлчилгээ болон асаргааны хувилбарт үйлчилгээний эрх зүйн орчинг бий болгож, төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр гэрээлэн гүйцэтгүүлэх зохицуулалтыг тусган, 2025 оноос эхлэн хэрэгжүүлж байна.<br>Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар, Монголын улаан загалмай нийгэмлэгтэй хамтран ахмад настанд | 50 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | идэвхтэй насжилтыг дэмжих төвийн үйлчилгээ болон асаргааны хувилбарт үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулсан нийслэл, орон нутгийн байгууллагын төлөөлөл, аймаг, дүүргийн Ахмадын хороо, Улаан загалмайн дунд шатны хороодын дэргэдэх Идэвхтэй насжилтыг дэмжих төвийн төлөөлөлд сургалт зохион байгуулав.<br>Сургалтыг танхим, цахим хосолсон хэлбэрээр нийт 60 гаруй хүн оролцлоо. Сургалтаар ахмад настны үйлчилгээний журам, хэрэгжилтийн явцад анхаарах асуудал, ахмад настныг үнэлэх, кейс менежментэд суурилсан хөгжлийн үйлчилгээ, асаргаа сувилгааны үйлчилгээний талаар танилцуулга хийж, мэдээлэл өглөө.<br>2026 оны эхний хагас жилийн байдлаар улсын хэмжээнд Идэвхтэй насжилтыг дэмжих үйлчилгээ үзүүлэх болон Ахмад настанд асаргааны хувилбарт үйлчилгээ үзүүлэх байгууллагуудыг сонгон шалгаруулах ажлыг 21 аймаг 9 дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрууд хариуцан зохион байгуулж, 22 байгууллага гэрээ байгуулаад байна. Сургалтын үр дүн нь гэрээ байгуулсан байгууллагад ахмад настанд үйлчилгээг чанартай, хүртээмжтэй, мэргэжлийн түвшинд үзүүлэх, ажилтнуудын чадавхыг тогтмол сайжруулж, харилцан туршлагаа хуваалцаж байхад чухал ач холбогдолтой боллоо. | |

| | |
|---|---|
| **СТРАТЕГИЙН ЗОРИЛГО 4.НИЙГМИЙН ДААТГАЛЫН ТОГТОЛЦООНЫ ШИНЭЧЛЭЛИЙГ ҮРГЭЛЖЛҮҮЛЭН, ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОН, ХУВИЙН НЭМЭЛТ ТЭТГЭВРИЙН ТОГТОЛЦООГ БИЙ БОЛГОХ ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ БҮРДҮҮЛЖ, ИРЭЭДҮЙД АХМАД НАСТНУУД ОЛОН ЭХ ҮҮСВЭРЭЭС ТЭТГЭВЭР АВАХ БОЛОМЖИЙГ БҮРДҮҮЛЭН** | **ХҮРЭХ ҮР ДҮН:** ТЭТГЭВРИЙН ДААТГАЛЫГ ОЛОН ДАВХАРГАТ ТОГТОЛЦООНД ШИЛЖҮҮЛЭХ, ХУВИЙН НЭМЭЛТ ТЭТГЭВРИЙН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ БИЙ БОЛГОХ |

| ГАДААД УЛСАД АЖИЛЛАЖ, АМЬДАРЧ БАЙГАА МОНГОЛ УЛСЫН ИРГЭНИЙ НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ҮҮДНЭЭС НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ХЭЛЭЛЦЭЭРИЙГ ҮРГЭЛЖЛҮҮЛЭН БАЙГУУЛНА. | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Зорилт.7. | Олон давхаргат тэтгэврийн тогтолцоог нэвтрүүлнэ. | үйл ажиллагааны зардал | Хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн эсэх /тийм-1, үгүй-0/ | 0 | 1 | - | | НДХСБ Г |
| 7.1. | Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлнэ.<br><br>*/Алсын хараа-2050 3.1.4, ТТШТББ /2015-2030/ 3.2.17, МУХТЖҮЧ 2021-2025 3.1.1, МУЗГҮАХ 2024-2028 2.1.3.5, ГБХНХ-ын салбарын стратеги төлөвлөгөө зорилт-2- 2.1, ЗГХЭГ-аас ирүүлсэн 2026 оны ХЭГ/142 дугаар албан бичгийн 3 дахь заалт/* | Үйл ажиллагааны зардал | Хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн эсэх /тийм-1, үгүй-0/ | 0 | 1 | - | Тэтгэврийн олон давхаргат тогтолцоонд шилжих хүрээнд Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөл болон уг төсөлтэй дагалдуулан боловсруулсан хуулийн төслүүдийг Засгийн газрын 2026 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн дэмжиж, мөн өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн.<br>Мөн Улсын Их Хурлын Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны 2026 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн хуралдаанаар хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн. | 100 |
| | | | Дагах хуулийн төсөл /тоо/ | 0 | 10 | - | Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төслийг дагалдуулан Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд нэмэлт оруулах тухай гэсэн 12 хуулийн төслийг боловсруулсан. | |
| | | | Боловсруулсан үзэл баримтлал /тоо/ | 0 | 1 | - | Хуулийн төслийн үзэл баримтлалыг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Сангийн сайд нар 2026 оны 01 дүгээр сарын 07-ны өдөр хамтран баталсан. | |
| | | | Хавсаргасан тооцоо, судалгаа /тоо/ | 0 | 2 | - | Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандсан тухай тайлан, Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төслийн үр нөлөөг үнэлсэн судалгааны тайлан, Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөлд хийсэн зардлын тооцооны тайлан гэсэн 3 тайлан, судалгааг боловсруулсан. | |
| 7.2. | Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг актуар тооцоололд суурилан боловсруулна.<br><br>*/ЗГХЭГ-аас ирүүлсэн 2026 оны ХЭГ/142 дугаар албан бичгийн 3 дахь заалт/* | Үйл ажиллагааны зардал | Боловсруулсан хуулийн төсөл /тоо/ | 1 | 1 | 2 | Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон эдгээр хуулийг дагаж мөрдөх журмын тухай 3, дагах 3 | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хуулийн төслийг тус тус боловсруулсан. Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төслийг Засгийн газрын 2026 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн дэмжиж, мөн өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. | |
| 7.3. | Монгол Улсаас гадаад улстай нийгмийн хамгааллын олон улсын хэлэлцээр байгуулах чиглэлээр хамтран ажиллах, хэлэлцээ хийнэ.<br><br>*/МУЗГҮАХ 2024-2028 2.3.1.6/* | Үйл ажиллагааны зардал | Нийгмийн хамгааллын хэлэлцээр байгуулах чиглэлээр хамтран ажилласан улс /тоо/ | 2 | 2 | 1 | - Улсын Их Хурлаас Улаанбаатар хотноо 2025 оны 05 дугаар сарын 26-ны өдөр гарын үсэг зурсан “Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Австри Улс хоорондын хэлэлцээр”-ийг 2026 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр соёрхон баталж, хэлэлцэн тохиролцогч талууд дотоодын хууль тогтоомжийн шаардлагыг хангасан тул Хэлэлцээр 2026 оны 08 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжинэ.<br>- Улаанбаатар хотноо 2024 оны 10 дугаар сарын 29-ний өдөр гарын үсэг зурсан “Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Казахстан Улсын Засгийн газар хоорондын Тэтгэврийн асуудлаар хамтран ажиллах тухай хэлэлцээр”-ийг хэлэлцэн тохиролцогч талууд дотоодын хууль тогтоомжийн шаардлагыг хангаснаар 2026 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөж эхэлсэн.<br>- Монгол Улс, Бүгд Найрамдах Солонгосын Нийгмийн хамгааллын хэлэлцээрийг шинэчлэх яриа хэлэлцээг эхлүүлэх хүрээнд БНСУ дахь Монгол Улсын ЭСЯ-тай хамтран ажиллаж байна.<br>Нийгмийн хамгааллын тухай Монгол Улсын Засгийн газар болон Австрали | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төслийг хэлэлцэх 2 дахь шатны хэлэлцээг Улаанбаатар хотод 2025 оны 11 дүгээр сард зохион байгуулсан. 3 шатны хэлэлцээг 2026 онд зохион байгуулахаар Монгол Улсаас Австрали Улсад суугаа Элчин сайдын яам, Гадаад харилцааны яамтай хамтран ажиллаж байна. | |
| Зорилт.8. | Үндэсний баялгийн сангийн Хуримтлалын сангаар дамжуулан эрүүл мэнд, боловсрол, орон сууцжуулалтад дэмжлэг үзүүлэх зорилгоор хуримтлалын хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. */МУЗГҮАХ 2024-2028 2.1.3.1/* | Байгалийн баялаг, ногдол ашиг | Хэрэгжүүлсэн арга хэмжээ /тоо/ | 0 | 3 | - | | НДХСБГ |
| 8.1. | Үндэсний баялгийн сангаар дамжуулж хуримтлалын хөтөлбөрийг хэрэгжүүлж, иргэн бүрийн хуримтлалын нэрийн дансанд хүүгийн орлого болон ногдол ашгийг бүртгэнэ.<br><br>*/МУЗГҮАХ 2024-2028 2.1.3.1, УХЖТ-2026 2.12.1.1/* | Байгалийн баялаг, ногдол ашиг | Хуримтлуулсан хөрөнгийн хэмжээ /төгрөг/ | 954.4 тэрбум | - | 372.9 тэрбум | Үндэсний баялгийн сангийн тухай хууль хэрэгжсэн хоёр жилийн хугацаанд Хуримтлалын сангийн мөнгөн хөрөнгө 1,103.8 тэрбум төгрөгт хүрч, сангийн хөрөнгийг хөрөнгө оруулалтад оруулах замаар арвижуулсны үр дүнд иргэн бүрийн хуримтлалын нэрийн дансны хуримтлал 306.1 мянган төгрөгт хүрээд байна. | ХБ |
| 8.2. | Хуримтлалын сангийн үйл ажиллагааны удирдлагыг хэрэгжүүлэх хүрээнд Хуримтлалын санд 2026 онд төвлөрсөн мөнгөн хөрөнгийг хөрөнгө оруулалтад оруулах, гэрээ байгуулах ажлыг зохион байгуулна. | Хуримтлалын сангийн эх үүсвэр | Засгийн газрын тогтоол, гэрээ | - | Засгийн газрын тогтоол-1, Гэрээ-1 | - | Хуримтлалын сангийн 2026 оны хөрөнгө оруулалтын талаар "Хууль хэрэгжүүлэхтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай" Засгийн газрын 162 дугаар тогтоолыг 2026 оны 04 сарын 29-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулсан. Ингэснээр Хуримтлалын санд 2026 онд хуримтлуулах мөнгөн хөрөнгийн 60 хүртэлх хувийг төрөөс хэрэгжүүлж байгаа орон сууцны санхүүжилтийн | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хөтөлбөрт хөрөнгө оруулахаар зохицуулсан | |
| 8.3. | Хуримтлалын нэгдсэн сангийн мэдээллийн нэгдсэн санг шинээр нэвтрүүлэх ажлыг үе шаттай авч хэрэгжүүлнэ. | үйл ажиллагааны зардал | Мэдээллийн нэгдсэн систем | Бодлогын даалгавар | Hurimtlal. gov.mn Мэдээллийн систем | Hurimtlal. gov.mn Мэдээллийн систем | Засгийн газрын 2024 оны 224 дүгээр тогтоолоор батлагдсан "Монгол Улсын иргэн бүрд хуримтлалын нэрийн данс үүсгэх, хөтлөх, сангаас зарцуулалт хийх журам"-ын хэрэгжилтийг хангах хүрээнд иргэн хуримтлалын нэрийн дансанд хуримтлагдсан мөнгөн хөрөнгөө гэр бүлийн гишүүнд нэг удаа шилжүүлэх, Иргэний хуулийн холбогдох заалтын дагуу өвлүүлэх, 2030 оноос эрүүл мэнд, боловсрол, орон сууцны зориулалтаар зарцуулах зохицуулалтыг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангахаар тус яам Санхүүгийн мэдээллийн технологийн төвтэй хамтран Хуримтлалын сангийн мэдээллийн нэгдсэн систем (hurimtlal.gov.mn)-ийг хөгжүүлэн ажиллаж байна.<br>Хуримтлалын сангийн 2026 оны эхний хагас жилийн байдлаар сар бүр хөрөнгийн оруулалтын дүн, орлогын гүйцэтгэлийн мэдээллийг холбогдох шийдвэрийн хамт тухайн шийдвэр гарсан сард нэгтгэн олон нийтэд нээлттэй тайлагнаж, Шилэн дансны тухай хуульд заасан журмын дагуу шилэн дансны нэгдсэн цахим хуудсаар дамжуулан хуульд заасан хугацаанд тогтмол мэдээлэх хуулийн заалтыг хэрэгжүүлж ажиллаж байна. | 100 |
| Зорилт.9. | Нийгмийн даатгалын хууль, тогтоомжийг хэрэгжүүлнэ. | Улсын болон нийгмийн даатгалын сангийн төсөв | Шийдвэрийн тоо | 0 | 2 | 3 | | НДХСБГ |
| 9.1. | Нийгмийн даатгалын сангаас олгох дундаж тэтгэврийн хэмжээг инфляцын түвшинтэй уялдуулан нэмэгдүүлнэ. | Улсын төсөв | Тэтгэврийн нэмэгдэл /хувь/ | 6 | 8.6 | - | Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсэгт тэтгэвэр авагчийн тэтгэврийн хэмжээг өмнөх оны инфляцын жилийн дундаж | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | */МУЗГҮАХ 2024-2028 2.1.1.22, ГБХНХ-ын салбарын стратеги төлөвлөгөө зорилт-4- 4.1/* | | | | | | түвшинтэй уялдуулж жил бүрийн 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн нэмэгдүүлэхээр заасан.<br>Энэ хүрээнд ахмад настны тэтгэврийн үнэ цэнийг бууруулахгүй байх, нийгмийн баталгааг нь хангах зорилгоор нийгмийн даатгалын сангаас олгож байгаа болон цэргийн алба хаасны 524.7 мянган тэтгэвэр авагчийн тэтгэврийн хэмжээг 2026 оны 01-р сарын 01-ний өдрөөс 80,000 төгрөгөөр нэмэгдүүлж, тэтгэврийн зардалд 496.1 тэрбум төгрөгийг олгосон. Ингэснээр бүрэн тэтгэврийн доод хэмжээ 769,000 төгрөг, хувь тэнцүүлэн тогтоолгох тэтгэврийн доод хэмжээ 652,400 төгрөг, дундаж тэтгэврийн хэмжээ 950,200 төгрөгт хүрсэн. | |
| 9.2. | Даатгуулагчийн шимтгэл төлөх болон тэтгэвэр, тэтгэмж тогтоолгох цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын өнөөгийн үнэ цэнийг тодорхойлоход 2027 онд хэрэглэх итгэлцүүрийг батлуулна. | Улсын төсөв | Засгийн газрын тогтоол /тоо/ | 0 | - | 1 | Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 22 дугаар зүйлийн 22.2-т заасны дагуу Засгийн газрын 2025 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн 65 дугаар тогтоолоор “Даатгуулагчийн шимтгэл төлөх болон тэтгэвэр, тэтгэмж тогтоолгох цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын өнөөгийн үнэ цэнийг тодорхойлоход 2026 онд хэрэглэх итгэлцүүр”-ийг баталсан. Тус тогтоолыг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж байна.<br>2027 онд хэрэглэх итгэлцүүрийн тооцооллыг хийж Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулан Төрийн нарийн бичгийн даргын 2026 оны 06 дугаар 08-ны өдрийн 01/1994 дугаар албан бичгээр Үндэсний статистикийн хорооноос санал авахаар хүргүүлсэн. Засгийн газрын тогтоолын төслийг 2026 оны 08 дугаар 01-ний өдрөөс өмнө буюу III улиралд багтаан батална. | ХБ |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 9.3. | Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлээс 2026 онд Засгийн газрын үнэт цаас худалдан авахад зарцуулах хөрөнгийн хэмжээг батлуулна. | Нийгмийн даатгалын сангийн төсөв | Засгийн газрын тогтоол /тоо/ | 0 | 1 | - | Засгийн газрын 2026 оны 1 дүгээр сарын 28-ны өдрийн “Засгийн газрын болон Монголбанкны үнэт цаас худалдан авах хөрөнгийн хэмжээг батлах тухай” 32 дугаар тогтоолоор нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлээс Засгийн газрын урт хугацаат (нэг жил болон түүнээс дээш) бонд, Монголбанкны үнэт цаас худалдан авахад зарцуулах хөрөнгийн дээд хэмжээг 2026 онд 300.0 (гурван зуун) тэрбум хүртэлх төгрөгөөр баталсан. | ХБ |
| 9.4. | Тэтгэврийн нөөц сангийн хөрөнгийг нэмэгдүүлнэ.<br><br>*/МУХТЖҮЧ 2.2.1.3/* | Улсын төсөв | Хөрөнгө оруулалтад оруулсан хөрөнгө /хувь/ | 0 | - | 15 | Тэтгэврийн нөөц сангийн хөрөнгийг өсгөхөөр ЗГДҮЦ/2026/-003 дугаартай 40.0 тэрбум төгрөгийн Засгийн газрын үнэт цаас, ЗГДҮЦ/2026/-004 дугаартай 45.0 тэрбум төгрөгийн Засгийн газрын үнэт цаас худалдах-худалдан авах гэрээг 2026 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр байгуулсан. Гэрээний дагуу хугацааны эцэст 35.6 тэрбум төгрөгийн хүүгийн орлогоор сангийн хөрөнгийг өсгөх боломжийг бүрдүүлсэн. | ХБ |
| Зорилт.10. | Нийгмийн даатгалын сангуудын тогтвортой байдлыг хангах, нийгмийн даатгалын хууль, тогтоомжийн хэрэгжилтийг эрчимжүүлнэ. | Улсын болон нийгмийн даатгалын сангийн төсөв | Боловсруулсан судалгаа, шийдвэр /тоо/ | 0 | 3 | 3 | | НДХСБГ |
| 10.1. | Даатгуулагчийн шимтгэл төлөх болон тэтгэвэр, тэтгэмж тогтоолгох цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын өнөөгийн үнэ цэнийг тодорхойлох итгэлцүүр тооцох аргачлал боловсруулна. | - | Аргачлал /тоо/ | 0 | - | 1 | Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 22 дугаар зүйлийн 22.2-т заасны дагуу Засгийн газрын 2025 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн 65 дугаар тогтоолоор “Даатгуулагчийн шимтгэл төлөх болон тэтгэвэр, тэтгэмж тогтоолгох цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын өнөөгийн үнэ цэнийг тодорхойлоход 2026 онд хэрэглэх итгэлцүүр”-ийг баталсан. Тус тогтоолыг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж байна. | ХБ |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 2027 онд хэрэглэх итгэлцүүрийн тооцооллыг хийж Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулан Төрийн нарийн бичгийн даргын 2026 оны 06 дугаар 08-ны өдрийн 01/1994 дугаар албан бичгээр Үндэсний статистикийн хорооноос санал авахаар хүргүүлсэн. Засгийн газрын тогтоолын төслийг 2026 оны 08 дугаар 01-ний өдрөөс өмнө буюу III улиралд багтаан батална. | |
| 10.2. | Тэтгэвэр тогтоох сарын цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын дээд хэмжээг өөрчлөхтэй холбоотой тооцоолол, судалгаа хийж, Нийгмийн даатгалын сангийн 2027 оны төсөвт тусгах санал хүргүүлнэ. | Улсын төсөв | Тэтгэвэр тогтоох сарын цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын дээд хэмжээ | 2013 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнөх тэтгэвэр тогтоох сарын цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын дээд хэмжээ 1,404,000 төгрөг | - | Тэтгэвэр тогтоох сарын цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын дээд хэмжээ 1,920,000 төгрөг | 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдөрөөс өмнөх тэтгэвэр тогтоох сарын цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын дээд хэмжээг 2,400.0 мянга болгох тооцоолол, судалгаа хийж, Нийгмийн даатгалын сангийн 2027 оны төсөвт 353.8 тэрбум төгрөгийг тусгуулахаар төсвийн хязгаар, хүрээний мэдэгдэлд саналаа хүргүүлсэн. | 100 |
| 10.3. | Ажилгүйдлийн даатгалын сангийн орлого, зарлагын тэнцвэрийг хадгалах чиглэлээр холбогдох арга хэмжээ авна. | Нийгмийн даатгалын сангийн төсөв | Боловсруулж, хүргүүлсэн баримт бичиг /тоо/ | - | 1 | 1 | Ажилгүйдлийн даатгалын сангийн 2016-2025 оны үйл ажиллагаанд иж бүрэн дүн шинжилгээ хийж, сангийн орлого, зарлагын урт хугацааны тэнцвэрийг хангах, эрх зүйн орчныг боловсронгуй болгох санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2026 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн А/19 дүгээр тушаалаар байгуулан ажилласан. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Ажилгүйдлийн даатгалын сангийн 2016-2025 оны үйл ажиллагаанд иж бүрэн дүн шинжилгээ хийж, сангийн орлого, зарлагын тэнцвэр алдагдах, тэтгэмжийн зардал өсөлтөд нөлөөлж буй хүчин зүйлийг тодорхойлсон. Судалгаан үндэслэн ажилгүйдлийн даатгалын сангийн орлого, зарлагын тэнцвэрийг зохистой харьцаанд хадгалах зорилгоор ажилгүйдлийн тэтгэмжийн параметрийн өөрчлөлт хийх буюу даатгуулагчийн шимтгэл төлсөн байвал зохих нөхцөлийг өөрчлөх, өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн тохиолдолд ажилгүйдлийн тэтгэмж олгох хугацааг бууруулах, нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээнд сан хооронд зохицуулалт хийх буюу үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийн хувь хэмжээнээс 0.1 пунктийг ажилгүйдлийн даатгалын санд шилжүүлэхтэй холбоотой зохицуулалтыг Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгаад байна. Хуулийн төслийг Засгийн газрын 2026 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн дэмжиж, УИХ-д өргөн мэдүүлсэн. | |
| 10.4. | Хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтоох, сунгах, цуцлах, ажлын цагийг богиносгох, хөдөлмөрийн нөхцөл солих үйл ажиллагааг санамсаргүй түүврээр шийдвэрлэх боломжийг бүрдүүлнэ. | үйл ажиллагааны зардал | “Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Засгийн газрын тогтоол /тоо/ | 0 | 1 | - | 2026 оны сүүлийн хагас жилд “Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Засгийн газрын тогтоолыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлнэ. | 0 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 10.5. | Хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтоох, сунгах, цуцлах, ажлын цагийг богиносгох, хөдөлмөрийн нөхцөл солих үйл ажиллагааг олон улсын жишигт нийцүүлэн санамсаргүй түүврээр иргэний харьяалал харгалзахгүйгээр шийдвэрлэх тогтолцооны шинэ шийдлийг туршин нэвтрүүлнэ.<br><br>*/Алсын хараа-2050 3.1.5, МУЗГҮАХ 2024-2028 2.1.3.2/* | Үйл ажиллагааны зардал | Хөгжүүлсэн програм хангамж /тоо/ | 0 | - | 1 | Монгол Улсын Засгийн газраас иргэдийн нийгмийн хамгааллын асуудлыг онцгойлон анхаарч, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлж байгаагийн нэг нь даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, шалтгааныг магадлан тогтоох, хөдөлмөр зохицуулалт хийх ажил юм. Энэ хүрээнд хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтооход даатгуулагч, хүний эрүүл мэндийн зайлшгүй шаардлагатай солилцох мэдээллийн жагсаалтыг шинээр боловсруулахаар холбогдох яамдтай хамтран ажилласан.<br>Үүний үр дүнд даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалт тогтоох, сунгах, цуцлах, ажлын цагийг богиносгох, хөдөлмөрийн нөхцөл солих, хөгжлийн бэрхшээлтэй хүний байнгын асаргааг тодорхойлох, сэргээн засах, сувилал, эмнэлгийн хуудас олгох, хяналт хийхэд шаардлагатай мэдээллийг санамсаргүй түүврийн аргаар өөр аймаг, дүүргийн зөвлөл тогтоож, шийдвэрлэх шинэ тогтолцооны судалгаа хийж зураглалыг боловсруулж цахимаар салбар дундын мэдээллийг солилцох, шийдвэрлэх боломжийг бүрдүүлэх зорилгоор “Мэдээлэл солилцох тухай” Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын 2025 оны А/125 А/212 дугаар хамтарсан тушаалыг батлуулсан.<br>Түүнчлэн, Эрүүл мэндийн сайдад 2026 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтоох, сунгах, цуцлах үйл ажиллагаа түүний | ХБ |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | харьяаллын аймаг, дүүргийн эрүүл мэндийн магадлалын зөвлөлөөр тогтоохгүйгээр, санамсаргүй түүврийн аргаар өөр аймаг, дүүргийн зөвлөл тогтоож болох нөхцөлийг бүрдүүлж, олон улсын жишигт нийцсэн программ хангамжийг шинээр нэвтрүүлэх, хамтран ажиллах тушаалын хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар 01/1248 дугаар албан бичиг хүргүүлж, хамтран ажиллаж байна. | |
| 10.6. | Даатгуулагчид эмнэлгийн хуудас олгох үйл ажиллагааг чирэгдэлгүй хүргэх зорилгоор маягтын загвар, журмыг шинэчлэн боловсруулна. | Нийгмийн даатгалын сангийн төсөв | “Журам, маягтын загвар батлах тухай” Эрүүл мэнд болон Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын хамтарсан тушаалын нэмэлт өөрчлөлт | - | - | 1 | 2026 оны сүүлийн хагас жилд даатгуулагчид эмнэлгийн хуудас олгох үйл ажиллагааг чирэгдэлгүй хүргэх зорилгоор маягтын загвар, журмыг шинэчлэн боловсруулна. | ХБ |
| 10.7. | Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөр хөдөлмөрийн чадвараа алдсан даатгуулагчид тусламж үйлчилгээ үзүүлэх, нөхөн сэргээн засах үйлчилгээг сайжруулна. | Нийгмийн даатгалын сангийн төсөв | “Журам батлах тухай” Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоол | - | 1 | - | 2026 оны сүүлийн хагас жилд “Журам батлах тухай” Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоолыг батлуулна. | 0 |
| 10.8. | Засгийн газрын үнэт цаасны нээлттэй арилжаанд оролцож, нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг эрсдэлгүй эх үүсвэрт байршуулан өсгөх нөхцөлийг бүрдүүлнэ. | - | “Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Засгийн газрын тогтоол /тоо/ | 0 | 1 | - | "Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах тухай" журамд нэмэлт, өөрчлөлт оруулах “Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан, 2026 оны 04 дүгээр сарын 14-ний 01/1253 тоот албан бичгээр Засгийн газрын гишүүдээс санал авахаар хүргүүлсэн. Нийт 17 | 90 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | санал ирж, холбогдох саналыг тогтоолын төсөлд тусгасан. Тогтоолын төслийг 2026 оны 05 дугаар сарын 19-ны 02/1730 тоот албан бичгээр Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн ажлын албанд хүргүүлж, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хангаж байна.<br>"Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" Засгийн газрын тогтоолын төслийг 2026 оны сүүлийн хагас жилд Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлнэ. | |
| 10.9. | Нийгмийн даатгалын үйлчилгээний чанарыг сайжруулна.<br><br>*/МУХТЖҮЧ 2.2.1.1/* | үйл ажиллагааны зардал | Үйлчлүүлэгч /ажил олгогч, даатгуулагч/-ийн сэтгэл ханамжийн үнэлгээ | 0 | - | 1 | Нийгмийн даатгалын байгууллагаас үзүүлж байгаа нийгмийн даатгалын үйлчилгээний чанар, хүртээмжийн байдалд иргэдийн сэтгэл ханамжийн үнэлгээг хийх арга хэмжээг зохион байгуулахаар Нийгмийн даатгалын ерөнхий газарт сэтгэл ханамжийн судалгааны тухай 2026 оны 04 дүгээр сарын 22-ны 02/1369 тоот албан бичгийг хүргүүлсэн.<br>Энэ хүрээнд нийгмийн даатгалын үйлчилгээний чанар, хүртээмжийн байдалд иргэдийн сэтгэл ханамжийн үнэлгээг хийх арга хэмжээг 2026 оны сүүлийн хагас жилд зохион байгуулна. | ХБ |
| 10.10. | Нийгмийн даатгалын шимтгэлийн өр төлбөрийг бууруулах чиглэлээр мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллана. | үйл ажиллагааны зардал | Үйл ажиллагааны /тоо/ | 0 | 2 | 3 | Нийгмийн даатгалын шимтгэлийн өртэй төсөвт байгууллагын өр, авлагыг бууруулах чиглэлээр хамтран ажиллах тухай 2026 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 01/1526 тоот албан бичгийг Эрүүл мэндийн яам, 2026 оны 05 дугаар сарын 01-ны өдрийн 01/1497 тоот албан бичгийг Эрчим хүчний яам, 2026 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 01/1525 тоот албан бичгийг Зам, тээврийн яам, 2026 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 01/1527 тоот албан бичгийг Боловсролын яам, 2026 | 70 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | оны 05 дугаар сарын 06-ны өдрийн 01/1573 тоот албан бичгийг Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам, 2026 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 01/1524 тоот албан бичгийг Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам, 2026 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 01/1522 тоот албан бичгийг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамдад тус тус хүргүүлж, шимтгэлийн өр ихээр үүссэн салбарын төсөвт байгууллагуудын судалгаа хүргүүлсэн. | |
| **СТРАТЕГИЙН ЗОРИЛГО 5.ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БОЛОН ХҮНИЙ НӨӨЦИЙН УДИРДЛАГЫН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ, ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ, БАЙГУУЛЛАГЫН СОЁЛЫГ ТӨЛӨВШҮҮЛЭХ, ЯАМНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ЗӨВЛӨГӨӨ, ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ, ХУУЛЬ ТОГТООМЖ СУРТАЛЧЛАХ, СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ, ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГААГ ХӨГЖҮҮЛЭН, ӨРГӨЖҮҮЛЖ, ЯАМНЫ САНХҮҮГИЙН ӨДӨР ТУТМЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИЦУУЛНА.** | | | | **ХҮРЭХ ҮР ДҮН:** ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БОЛОН ХҮНИЙ НӨӨЦИЙН УДИРДЛАГЫН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ, ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ, ЯАМНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ЗӨВЛӨГӨӨ, ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ. | | | | |
| Зорилт.11. | Салбарын гадаад хамтын ажиллагааг эрхэлж, гадаад орон, олон улсын байгууллага, төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтийг зохицуулахад дэмжлэг үзүүлэх | Улсын төсөв | Салбарын гадаад хамтын ажиллагааны чиглэлээр төлөвлөсөн арга хэмжээ хэрэгжсэн эсэх | 0 | гүйцэтгэлээр /тоо/ | 1 | | ТЗУГ |
| 11.1. | Монгол Улс, гадаад улс хоорондын хөдөлмөр, нийгмийн хамгааллын чиглэлээр хэлэлцээр болон санамж бичиг байгуулахад зохицуулалтаар хангах, арга зүйн дэмжлэг үзүүлнэ. | Улсын төсөв | Англи хэл дээр боловсруулсан баримт бичиг /тоо/ | 0 | гүйцэтгэлээр /тоо/ | гүйцэтгэлээр /тоо/ | 1. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөр эрхлэлтийн бодлогын газрын дарга Б.Алимаа, Малайз Улсын Берхад дахь Хөгжлийн судалгааны төвийг төлөөлж Ахлах эдийн засагч, доктор Мохд Юсоф Саари, Монголын бүтээмжийн төвийг төлөөлж гүйцэтгэх захирал Я.Эрхэмбаяр нар Монгол Улсын үндэсний бүтээмж, өрсөлдөх чадварыг | 90 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | нэмэгдүүлэх бодлогын зорилтыг дэмжих хүрээнд Үндэсний бүтээмжийн мастер төлөвлөгөөтэй уялдуулан судалгаа шинжилгээ хийх, чадавх бэхжүүлэх, бодлого боловсруулах, мэдлэг түгээх үйл ажиллагааг хамтран хэрэгжүүлэх Санамж бичигт гарын үсэг зурсан.<br>2. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аубакир, Японы Хүүхдийг ивээх сангийн Монгол дахь суурин төлөөлөгч Л.Баян-Алтай нар Нийгмийн хамгааллын салбарт хамтран ажиллаж, хүүхэд, гэр бүлд ээлтэй орчинг бүрдүүлэх тэдний эрх хамгаалал, хөгжлийг дэмжих хүрээнд Хамтран ажиллах санамж бичиг байгуулав.<br>3. Япон Улстай "Ур чадвар хөгжүүлэх хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх чиглэлээр хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ, зохион байгуулалт, оролцогч байгууллагуудын төлөөллүүд цахим уулзалт хийсэн.<br>4. Канад Улсын Гадаад хэргийн яамны санхүүжилтээр хэрэгжүүлж байгаа төслийн бүрдэл хэсгийн хүрээнд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам болон Олон улсын эрх зүйн хөгжлийн байгууллага хоорондын “Монгол Улсад Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх тогтолцоог бэхжүүлэх нь” II шатны төслийг эцэслэн зурахад бэлдэж байна.<br>5. Монгол Улсын Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам болон БНХАУ-ын Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нэгдсэн холбоо хооронд Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үйлчилгээ үзүүлэх, туслах технологийн чиглэлээр хамтран ажиллах тухай Харилцан | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | ойлголцлын санамж бичгийн төслийг ГХЯ-нд дамжуулан айлын талд албан ёсоор уламжилсан. Хариуг хүлээн байна.<br>6. Монгол Улсын Ерөнхийлөгчийн Бүгд Найрамдах Казахстан Улсад хийсэн айлчлалын мөрөөр тус улсын Хөдөлмөр, хүн ам, нийгмийн хамгааллын яамтай Хүүхэд хамгаалал, аутизмтай хүүхэдтэй ажиллах албан тушаалтнуудыг чадавхжуулах чиглэлээр хамтран ажиллах санал, баримт бичиг байгуулах талаар ГХЯ-аар дамжуулан айлын талд албан захидлаар хүргүүлсэн. /Нийт -3/ | |
| | | | Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын чиглэлээр гадаад улсуудтай хамтран ажилласан, ЗГ хоорондын комиссын хурлуудаар хэлэлцсэн эсэх | 0 | гүйцэтгэлээр /тоо/ | гүйцэтгэл-ээр /тоо/ | Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Чех Улсын Засгийн газар хоорондын комиссын IX хуралдаан Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аубакираар ахлуулсан төлөөлөгчид 2026 оны 05.12-16-ны өдрүүдэд Прага хотноо амжилттай зохион байгуулагдав. Хуралдааныг Монголын талаас Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аубакир, Чехийн талаас Бүгд Найрамдах Чех Улсын Үйлдвэр, худалдааны дэд сайд Ян Сехтер нар тус тус тэргүүлэн оролцов.<br>Хуралдааны төгсгөлд Монгол, Чехийн Засгийн газар хоорондын комиссын IX хуралдааны протоколд Монгол Улсын Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аубакир, Бүгд Найрамдах Чех Улсын Үйлдвэр, худалдааны дэд сайд Ян Сехтер нар гарын үсэг зурж, тохиролцсон ажлуудыг хэрэгжүүлэхэд талууд идэвхтэй хамтран ажиллахаа баталгаажуулав. | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Айлчлалын хүрээнд Монгол Улсын Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аубакир Бүгд Найрамдах Чех Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Үйлдвэр, худалдааны сайд Карел Хавличек, Хөдөлмөр, нийгмийн хэргийн сайд Алеш Юхелка нартай албан ёсны уулзалт хийв. Уулзалтуудын үеэр хоёр улсын хамтын ажиллагааны цаашдын чиглэл, тулгамдаж буй зарим асуудлыг шийдвэрлэх талаар дэлгэрэнгүй санал солилцож, хамтын ажиллагааг бодит үр дүнд хүргэхэд анхаарч ажиллахаар тохиролцов | |
| 11.2. | НҮБ-ын төрөлжсөн байгууллагууд, Хөгжлийн байгууллагуудтай хамтран ажиллана. | Улсын төсөв | Чуулган болон бага хуралд оролцуулах төлөөлөгчийн бэлтгэл хангасан эсэх /тийм-1, үгүй-0/ | 0 | 1 | 1 | 1. АНУ-ны Нью Йорк хотноо 2026 оны 03 дугаар сарын 11-22-ний өдрүүдэд болсон НҮБ-ын Эмэгтэйчүүдийн Аж байдлын Хорооны 70 дугаар чуулганд ГБХНХ-ын сайд тэргүүтэй төлөөлөгчид оролцлоо. Эмэгтэйчүүдийн аж байдлын комиссын 70 дугаар чуулган нь эмэгтэйчүүд, охидын шударга ёсны хүртээмж, эрх зүйн хамгаалалт, тэгш боломжийг хангах асуудлыг олон улсын түвшний төвд нь авч үзсэн чухал арга хэмжээ болж өндөрлөв. Тэргүүлэх сэдвээр зөвшилцсөн дүгнэлт зөвшилцлөөр бус санал хураалтаар батлагдсан нь жендэрийн асуудлаарх олон улсын хэлэлцээ улам нарийн, мэдрэмтгий болж байгааг харуулж байгаа хэдий ч хэлэлцүүлгийн явцад дэвшүүлсэн асуудлууд нь улс орнуудын бодлого, үйл ажиллагаанд чиг баримжаа өгөх ач холбогдлоо хадгалж байгааг нотлов.<br>2. Азид хамтын ажиллагаа, итгэлцлийг бэхжүүлэх бага хурал (CICA)-ын хүрээнд "Тогтвортой өсөлтийн төлөө CICA-д эмэгтэйчүүдийн дуу хоолойг нэмэгдүүлэх нь" сэдэвт олон улсын | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | бага хурал 2026 оны 4 дүгээр сарын 14-ний өдөр Азербайжан Улсын нийслэл Баку хотноо зохион байгуулагдав. Тус арга хэмжээнд Монгол Улсын Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхзул оролцож, “Байгаль орчныг хамгаалах, тэсвэртэй байдлыг бэхжүүлэхэд эмэгтэйчүүдийн манлайлал” сэдэвт хуралдаанд үг хэлэв. Монгол Улс CICA-ийн хүрээнд идэвхтэй оролцогч орны хувьд бүс нутгийн итгэлцэл, хамтын ажиллагааг бэхжүүлэхэд хувь нэмрээ оруулж байна. Тус бага хурал нь эмэгтэйчүүдийн манлайлал, оролцоог нэмэгдүүлэх замаар тогтвортой хөгжлийг дэмжих бодлого, санаачилгыг урагшлуулах чухал ач холбогдолтой арга хэмжээ боллоо.<br>3. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны төлөөллүүд болон нийгмийн түншлэлийн гурван талын төлөөлөгчид 2026 оны 06 дугаар сарын 01-07-ны өдрүүдэд Швейцарын Холбооны Улсын Женев хотноо болсон Олон Улсын Хөдөлмөрийн Бага хурлын ээлжит 114 дүгээр чуулганд оролцов.<br>Чуулганы нэгдсэн хуралдаанд Женев дэх Байнгын төлөөлөгч, Элчин сайд үг хэлж, Монгол Улсын урт хугацааны бодлого, Засгийн газраас баримталж буй чиг хандлага, зохистой хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцаа, нийгмийн хамгаалал, жендэрийн тэгш байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж буй бодлого, эрх зүйн шинэчлэл, тулгамдаж буй сорилт, цаашид хэрэгжүүлэх бодлого, чиглэлийн талаар байр сууриа илэрхийлэв. | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 4. Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Бээжин хотноо зохион байгуулагдах “Ядуурлыг бууруулах дэлхийн хүчин чармайлтыг нэгтгэх нь” сэдвийн хүрээнд “Ядуурлыг бууруулах ба хөгжлийн дээд түвшний форум”-д Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аубакир 2026 оны 5 дугаар сарын 26-29-ний өдрүүдэд амжилттай оролцов. Форумаар дэлхийн хэмжээнд ядуурлыг бууруулах, тогтвортой хөгжлийг дэмжих чиглэлээр зохион байгуулагдсан өндөр түвшний хэлэлцүүлэг болж Монгол Улсын байр суурийг илэрхийлэх, ядуурлыг бууруулах чиглэлээр хэрэгжүүлж буй бодлого, арга хэмжээг танилцуулж, “Ядуурлыг бууруулах ба хөгжлийн дэлхийн түншлэл” (Global Partnership for Poverty Alleviation and Development – GPPAD)-ийн үйл ажиллагаанд оролцож, мөн БНХАУ-ын холбогдох удирдлагуудтай хоёр талт уулзалт хийж хамтын ажиллагааны асуудлаар санал солилцсон. Сайд Т.Аубакир форумын нэгдсэн хуралдаанд үг хэлэхдээ НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилтуудад тусгагдсан ядуурлыг бүх хэлбэрээр устгах зорилт нь өнөөдөр дэлхий нийтийн өмнө тулгамдсан хамгийн чухал хөгжлийн зорилтуудын нэг хэвээр байгааг онцлон тэмдэглэсэн. “Ядуурлыг бууруулах ба хөгжлийн дээд түвшний форум”-д оролцсон нь Монгол Улсын ядуурлыг бууруулах, хөдөөгийн хөгжил, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгааллын чиглэлээр хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагааг олон улсын түвшинд сурталчлан таниулах, харилцан туршлага солилцох, шинэ түншлэл, хамтын ажиллагааг | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой форум болов. | |
| | | | Англи хэл дээр боловсруулсан баримт бичиг, санал, тайлан /тоо/ | 0 | гүйцэтгэлээр /тоо/ | гүйцэтгэлээр /тоо/ | Чуулган, дээд хэмжээний форум, арга хэмжээнд хэлэх үг, яриа хэлэлцээний сэдэв, агуулга англи хэл дээр боловсруулагдсан. | |
| 11.3. | Салбарын стратеги төлөвлөгөө болон байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, яамны ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн болон яамны 2026 оны сар бүрийн үйл ажиллагааны тайлан гаргах ажлыг зохион байгуулна. | үйл ажиллагааны зардал | Салбарын стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх ГБХНХЯ-ны 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийн тайлан /тоо/ | 0 | 1 | 2 | ГБХНХ-ын сайдын 2025 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн А/119 дүгээр тушаалаар баталсан “Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын 2025-2028 оны стратеги төлөвлөгөө”-нд 2026 онд хийхээр төлөвлөсөн нийт 17 зорилтын 64 шалгуур үзүүлэлтийн биелэлтийг 2025 оны жилийн эцсийн байдлаар гарган 2026 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр СХШҮДАГ-т хүргүүлсэн.<br>2026 онд төлөвлөсөн 16 зорилтын 64 шалгуур үзүүлэлтийг чиг үүргээр нь авч үзвэл:<br>1.Хүн амын гэр бүлийг дэмжих хөгжлийн бодлогын 3 зорилт 18 шалгуур үзүүлэлт;<br>2.Хөдөлмөрийн бодлогын 4 зорилтын 10 шалгуур үзүүлэлт;<br>3.Нийгмийн халамжийн бодлогын 3 зорилтын 13 шалгуур үзүүлэлт;<br>4/ Нийгмийн даатгал, хуримтлалын сангийн бодлогын 5 зорилтын 9 шалгуур үзүүлэлт;<br>5.Салбарын цахимжилт, мэдээллийн технологийн 1 зорилтын 14 шалгуур үзүүлэлт байна.<br>Түүнчлэн Засгийн газрын 2026 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 2 дугаар хуралдааны тэмдэглэлийн дагуу “Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын 2025-2028 оны стратеги төлөвлөгөө”-г Улсын Их Хурлын 2025 оны 109 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсыг 2026-2023 онд | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-тэй уялдуулан нэмэлт, өөрчлөлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2026 оны А/63 дугаар тушаалаар байгуулсан. Ажлын хэсгийн хурлыг 2026 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр, 2026 оны 05 дугаар сарын 12, 20-ны өдөр 3 удаагийн хурлыг 317 тоот хурлын танхимд зохион байгуулсан бөгөөд ажлын хэсгийн гишүүдэд хугацаатай үүрэг даалгавар өгсөн. 2026 оны 06 дугаар сард багтаан Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын 2025-2028 оны стратеги төлөвлөгөөг батлуулахаар ажиллаж байна. | |
| | | | Яамны 2026 оны ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн тайлан /тоо/ | 0 | 1 | 2 | ГБХНХЯ-ны Нээлттэй мэдээллийн ил тод байдлын нийт 48 заалтын хэрэгжилтийг 2025 оны жилийн эцсийн байдлаар нэгтгэн боловсруулж 2026 оны 01 дүгээр сарын 11-ний өдөр СХШҮДАГ-т хүргүүлэв.<br>Үүнд:<br>1.Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдлын 10 заалт;<br>2.Хүний нөөцийн талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдлын 6 заалт;<br>3.Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдлын 14 заалт;<br>4.Үзүүлж байгаа үйлчилгээний талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдлын 2 заалт;<br>5.Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдлын 16 заалтын биелэлтийг тус тус нэгтгэв. /Засгийн газрын 2026 оны | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 144 дүгээр тогтоолоор тайлагнах давтамжид нэмэлт, өөрчлөлт орсон./ 2026 оны жилийн эцсийн тайланг хуулийн хугацаанд багтаан СХШҮДАГ-т хүргүүлэхээр ажиллаж байна. Хугацаа болоогүй. | |
| | | | 2026 оны сар бүрийн үйл ажиллагааны тайлан /тоо/ | 0 | 6 | 12 | ГБХНХЯ-ны 2026 оны 1, 2, 3, 4, 5 дугаар саруудын үйл ажиллагааны тайланг хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох, бодлого төлөвлөлтийг сайжруулах, бодлогын хэрэгжилтийг зохицуулах, санхүү, хөрөнгө оруулалт, дотоод ажил, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх гэсэн 6 чиглэлээр, гүйцэтгэсэн ажлыг тулгамдсан болон хоцорч буй ажил, УИХ, ЗГ-т өргөн барьсан, үр дүнд хүрсэн гэсэн 3 төрлөөр тус тус гарган СХШҮДАГ-т цахим хэлбэрээр хуулийн хугацаанд хүргүүлсэн. ГБХНХЯ-ны 06 дугаар сарын тайланг 2026 оны 06 дугаар сарын 30-ны өдөр цахим хэлбэрээр хүргүүлэхээр ажиллаж байна. | |
| 11.4. | Бодлогын баримт бичигт гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын чиглэлээр 2026 онд хэрэгжүүлэхээр дэвшүүлсэн зорилт, арга хэмжээ, ГБХНХЯ-ны 2026 оны эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн хэрэгжилтийн тайлан гаргах ажлыг зохион байгуулна. | үйл ажиллагааны зардал | Бодлогын баримт бичгийн тайлан /тоо/ | 0 | 4 | 8 | 1. Монгол Улсын Их Хурлын 2020 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын дэвшүүлсэн зорилт, арга хэмжээний 82 зорилтын 84 арга хэмжээний хэрэгжилтийн тайланг холбогдох газар, нэгжүүдээс авч нэгтгэн боловсруулж хуулийн хугацаанд СХШҮДАГ-т хүргүүлэхээр ажиллаж байна. Засгийн газрын 2026 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн 144 дүгээр тогтоолын 01 дүгээр хавсралтаар тус тайланг тайлагнах | 100 |
| | | | Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн тайлан /тоо/ | 0 | 1 | - | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | давтамж өөрчлөгдөж 5 жилд нэг удаа тайлагнахаар болсон.<br>2. Монгол Улсын Их Хурлын 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 109 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын дэвшүүлсэн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн тайланг тайлагнах давтамжид Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн 144 дүгээр тогтоолоор нэмэлт, өөрчлөлт орсон тул жилийн эцсээр тайлагнана.<br>3. Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 218 дугаар тогтоолоор баталсан “Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээ”-ний төлөвлөгөөний 2025 оны хагас жилийн биелэлтээр “Үр дүнгүй” үнэлэгдсэн 41 арга хэмжээний тайлан, тайлбарыг нотлох баримтын хамт нэгтгэн боловсруулж 2026 оны 03 дугаар сарын 24-ний өдөр нэгтгэн боловсруулж СХШҮДАГ-т хүргүүлэв. Эхний хагас жилийн хэрэгжилтийг тайлагнах давтамжид Засгийн газрын 2026 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн 144 дүгээр тогтоолоор нэмэлт, өөрчлөлт орж жилийн эцсээр тайлагнадаг болсон.<br>4. Монгол Улсын Их Хурлын 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн 48 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө”-нд гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн тайланг тайлагнах | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | давтамжид Засгийн газрын 2026 оны 144 дүгээр тогтоолоор нэмэлт, өөрчлөлт орсон тул жилийн эцсээр тайлагнана.<br>5. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын 2025 оны жилийн эцсийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн тайланг холбогдох газруудаас авч нэгтгэн боловсруулж 2026 оны 02 дугаар сарын 26-ны өдөр СХШҮДАГ-т цахим хэлбэрээр хүргүүлсэн<br>Хугацаа болоогүй. | |
| 11.5. | Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг цахимд байршуулж, хэрэгжилтийн тайланг нэгтгэн боловсруулах ажлыг зохион байгуулна. | үйл ажиллагааны зардал | ЗГ-ын шийдвэрийг ABLE-д байршуулсан эсэх /тийм-1, үгүй-0/ | 0 | 1 | 1 | Монгол Улсын Засгийн газрын хуралдааны цахим системээс 2026 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн байдлаар Засгийн газрын тогтоол, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл 112 шийдвэрийг татан авч "ABLE" системд нийт албан хаагчдад харагдах байдлаар байршуулан бүртгэв.Үүнд:<br>1.Засгийн газрын тогтоол-39<br>2.Засгийн газрын тэмдэглэл-51<br>3.Монгол Улсын Ерөнхий сайдын захирамж-15<br>4.Монгол Улсын Ерөнхий сайдын албан даалгавар-7<br>Дээрх тогтоол шийдвэрийн биелэлтэд хяналт тавьж албан хэрэг хөтлөлтийн системээр албан хаагчид болон нэгжийн удирдлагуудад тогтоол шийдвэрийн биелэлтэд анхаарч ажиллах талаар тогтмол зар мэдээг хүргэж ажиллаж байна. | 100 |
| | | | Тайлан /тоо/ | 0 | 2 | 4 | Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 2026 оны 1 дүгээр улирлын яамны хэрэгжилтийг Төрийн захиргааны удирдлагын газрын Хууль, эрх зүйн хэлтэс нэгтгэн боловсруулж яамны Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт хүргүүлсэн. | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 11.6. | Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын хэмжээнд Төрийн албаны салбар зөвлөлийн чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллана. | -Яамны сул орон тоог нөхөх тусгай шалгалт зохион байгуулах зардал-5,0 сая төгрөг | Төрийн албаны салбар зөвлөлийн 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөө /тоо/ | 0 | 1 | - | Төрийн албаны зөвлөлийн Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны дэргэдэх салбар зөвлөлийн 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг салбар зөвлөлийн хуралдаанд танилцуулж, 13 дугаар тогтоолоор батлуулан, хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаж байна. Төлөвлөгөөний дагуу Салбар зөвлөлийн хуралдааны бэлтгэлийг ханган, хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг тухай бүр боловсруулан хуралдааныг дэгийн дагуу хуралдуулан, хурлаас гарсан шийдвэрийг 3 хоногийн дотор эцэслэн албажуулан ажиллалаа.<br>Салбар зөвлөлийн хурлыг 5 удаа зохион байгуулж дараах асуудлуудыг хэлэлцүүлж шийдвэр гаргасан байна. Үүнд:Төрийн албаны удирдах болон гүйцэтгэх албан тушаалын сул орон тоог нөхөх сонгон шалгаруулалт зохион байгуулах ажлын хэсэг томилох тухай, Харьяа байгууллагуудын зарим удирдах болон гүйцэтгэх албан тушаалын сул орон тоог нөхөх тусгай шалгалтын тайлан, Албан тушаалд нэр дэвшүүлж, санал болгох тухай зэрэг асуудлыг хэлэлцэн, Төрийн захиргааны албан хаагчийн тангараг өргүүлэх тухай, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны салбарын төрийн жинхэнэ албан хаагчдын албан тушаалын зэрэг дэв шинээр болон ахиулан олгох тухай, шагналд уламжлах тухай зэрэг хэлэлцсэн асуудлаар хүлээгдэж буй гүйцэтгэлээр 97 тогтоол гаргасан байна. | 100 |
| | | | Хэрэгжилтийн тайлан /тоо/ | 0 | 1 | 2 | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 11.7. | Яамны хүний нөөцийг чадавхжуулж, сургалт зохион байгуулна. | Улсын төсөв | Зохион байгуулсан сургалт /тоо/ | 0 | 1 | 3 | Яамны албан хаагчдыг чадавхижуулах 2026 оны сургалтын төлөвлөгөөг боловсруулж, Төрийн нарийн бичгийн даргаар батлуулахаар ажиллаж байна.<br>Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас Удирдлагын академийн Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 2 албан хаагч хамрагдаж, төгссөн. | 30 |
| | | | Сургалтад хамрагдсан албан хаагчийн эзлэх хувь | 0 | 40 хувь | 60 хувь | | |
| 11.8. | ГБХНХЯ-ны албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах дунд хугацаа (2026-2029 он)-ны хөтөлбөрийг боловсруулан батлуулна. | үйл ажиллагааны зардал | 2026 оны хөтөлбөрийн хэрэгжилт /хувь/ | 0 | 10 хувь | 15 хувь | Хугацаа болоогүй. | 0 |
| | | | Тухайн жилдээ Нийгмийн баталгааны хөтөлбөрт хамрагдсан албан хаагчдын хувь | 0 | - | 80 хувь | | |
| | | | Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар баталсан хөтөлбөр /тоо/ | 0 | - | 1 | | |
| 11.9. | ГБХНХ-ын сайдын 2026 оны тушаалын болон албан даалгаврын хэрэгжилтийн тайлан мэдээг сар бүр нэгтгэж, удирдлагуудад танилцуулж, Сайдын зөвлөлийн хуралдаан болон Төрийн нарийн бичгийн даргын шуурхай хуралдааныг товлосон хугацаанд зохион байгуулж, хурлаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг нэгтгэн | үйл ажиллагааны зардал | Сайдын 2026 оны тушаалын хэрэгжилтийн тайлан /тоо/ | 0 | 1 | 2 | 1. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2026 оны эхний хагас жилийн тушаалын хэрэгжилтийг 2026 оны III дугаар улиралд гаргаж СХШҮДАГ-т хүргүүлэхээр ажиллаж байна.<br>Хугацаа болоогүй. | 100 |
| | | | -Тус яамны 7 газарт өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт /хувь/;<br>- Тайлан /тоо/ | 0 | Хэрэгжилтийн хувь /явцын гүйцэтгэл/ | Хэрэгжилт-ийн хувь /явцын гүйцэтгэл/ | 2. Сайдын шуурхай хуралдааныг 1 удаа зохион байгуулж, салбарын хууль эрх зүйн шинэчлэлийн хүрээнд шинэчлэн найруулж буй болон нэмэлт өөрчлөлт оруулж буй хуулиудын явцтай танилцаж, холбогдох үүрэг даалгавар өгсөн. | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | удирдлагуудад танилцуулна. | | | | | | Тус хуралдааны тэмдэглэлийг хөтөлж Төрийн нарийн бичгийн дарга болон ТЗУГ-ын даргад танилцуулсан.<br>Сайдын шуурхай хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг нэгтгэн, удирдлагуудад танилцуулахад бэлтгэж сайдын зөвлөхөд танилцуулсан.<br>3. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын зөвлөлийн өргөтгөтгөсөн шуурхай хуралдааны 2026 оны 06 дугаар сарын 04-ний өдөр зохион байгуулсан. Хурадааны бэлтгэл ажлыг ханган харьяа 4 агентлаг, 2 газрын удирдлага болон хүний нөөцийн мэргэжилтнүүд мөн яамны газар, хэлтсийн дарга нарт зар хүргэж бэлэн байдлыг хангаж ажилласан. Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газраас төрийн байгууллага дахь процессын дахин инженерчлэл, гэр бүл хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны болон харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд хийсэн тандалт, судалгааны талаар мэдээлэл хийсэн. Мөн түүнчлэн сайдаас салбарын хууль тогтоомжийг УИХ-р хэлэлцүүлэх, яамны бүтэц орон, тоо, тэтгэвэр тэтгэмж, цалингийн талаарх асуудлыг хөндөн удирдлагуудтай ярилцсан шуурхай хурлын тэмдэглэлийг хөтөлсөн | |
| | | | Сайдын зөвлөлийн хуралдааны тэмдэглэл хөтөлсөн эсэх /тийм-1, үгүй-0/ | 0 | 1 | 1 | 1. Сайдын шуурхай хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг нэгтгэн, удирдлагуудад танилцуулахад бэлтгэж сайдын зөвлөхөд танилцуулсан. | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Сайдын зөвлөлийн хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврын биелэлт /хувь/; | 90 хувь | - | 100 хувь | 2. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын Төрийн нарийн бичгийн даргын шуурхай хуралдааныг Даваа гараг бүрийн 09:00 цагт зохион байгуулж, хуралдааны тэмдэглэлийг тухай бүр хөтлөсөн. 2026 оны эхний хагас жилийн байдлаар нийт 9 удаагийн шуурхай хуралдааныг зохион байгуулж, шуурхайн хуралдааны тэмдэглэлийг хөтлөн баримтжуулсан.<br>3. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын эрхлэх асуудлын хүрээнд Төрийн нарийн бичгийн даргын шуурхай хуралдаан 2026 оны эхний хагас жилийн байдлаар нийт 9 удаа шуурхай хуралдсан. Шуурхай хуралдаанаар өгсөн үүрэг даалгаврыг заалт бүрээр нь ангилан холбогдох газар, хэлтсүүдэд хүргүүлэн хэрэгжилтийн явцад тогтмол хяналт тавьж ажиллаж байна. | |
| | | | Төрийн нарийн бичгийн даргын шуурхай хуралдааны тэмдэглэл хөтөлсөн эсэх /тийм-1, үгүй-0/ | 0 | 1 | 1 | | |
| | | | Төрийн нарийн бичгийн даргын шуурхай хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврын биелэлт /хувь/; | 90 хувь | 50 хувь | 95 хувь | | |
| 11.10 | Байгууллагын эрсдэлийн удирлагын төлөвшлийн үнэлгээ хийнэ, төлөвлөгөө боловсруулна. | Үйл ажиллагааны зардал | Байгууллагын эрсдэлийн удирлагын төлөвшлийн үнэлгээ хийсэн эсэх /тийм-1, үгүй-0/ | 0 | 1 | - | Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны 2025 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн 03 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн байгууллагын эрсдэлийн удирдлагын бодлого", "Төрийн байгууллагад эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх заавар", Төрийн байгууллагын эрсдэлийн удирдлагын хэрэгжилтийг үнэлэх аргачлал"-ын дагуу Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны эрсдэлийн удирдлагын төлөвшлийн өөрийн үнэлгээг хийсэн. | 100 |
| | | | 2026 оны эрсдэлийн удирдлагын төлөвлөгөө /тоо/ | 0 | 1 | - | Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны эрсдэлийн удирдлагын төлөвшлийн үнэлгээ, төлөвшлийн түвшинд үндэслэн 2026-2027 онд авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | газарт 2026 оны 01 дүгээр сарын 30-ны 02/315 дугаар албан бичгээр хүргүүлсэн. | |
| 11.11. | ГБХНХЯ-ны архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулж, архив, албан хэрэг хөтлөлтийн 2025 оны улсын үзлэгийн зөвлөмжийн хэрэгжилтийг хангана. | Үйл ажиллагааны зардал | Баримт нягтлан шалгах комисс байгуулсан Төрийн нарийн бичгийн даргын тушаал /тоо/ | 0 | - | 1 | *1. Баримт нягтлан шалгах комисс байгуулсан Төрийн нарийн бичгийн даргын тушаал*<br>ГБХНХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2026 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн А/56 дугаар тушаалаар баталсан.<br>*2. Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт*<br>ГБХНХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2026 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн А/64 дүгээр тушаалаар Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг батлуулсан.<br>*3. 2026 онд хүлээн авсан баримт /тоо/*<br>ГБХНХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2026 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн А/59 дүгээр тушаалаар “Архивт баримт хүлээн авах хуваарь” баталсан. Батлагдсан хуваарийн дагуу Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтад заасны дагуу зохион байгуулалтын газар, нэгжүүдээс нийт 155 хадгаламжийн нэгжийг хүлээн авсан. Үүнд:<br>1.Байнга-85<br>2.Түр-70<br>Бүртгэл үйлдсэн. | 100 |
| | | | 2026 онд Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт баталсан эсэх /тийм-1, үгүй-0/ | 0 | 1 | - | | |
| | | | 2026 онд хүлээн авсан баримт /тоо/ | 0 | гүйцэтгэл /тоо/ | гүйцэтгэл /тоо/ | | |
| 11.12. | Байгууллагын албан хэргийг хос бичгээр хөтлөн явуулахаар заасны дагуу Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам хос бичгийн ашиглалтыг сайжруулна. | Үйл ажиллагааны зардал | Хос бичгээр явуулах албан бичгийн нийт албан бичигт эзлэх хувь | 0 | 85 хувь хүртэл | 90 хувь хүртэл | Монгол хэлний тухай хуулинд 2025 оны 01 сарын 01-с эхлэн Төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага албан хэргээ кирилл болон үндэсний хос бичгээр хөтлөн явуулахаар заасны дагуу ГБХНХЯ 2025 оны 01 дүгээр сарын 02-с эхлэн хос бичгээр хөтлөх журмыг хэрэгжүүлж ажиллаж байгаа бөгөөд “ABLE” системийг ашиглан үндэсний хос бичгээр хөтлөн 80-90%-тай албан бичгийг илгээсэн байна. | 90 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 11.13 | Өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хуулийн хугацаанд судалж, шийдвэрлүүлнэ.<br><br>-Мэдээ, тайланг хуулийн хугацаанд холбогдох газруудад хүргүүлнэ. | үйл ажиллагааны зардал | Тухай жилд хуулийн хугацаанд судалж шийдвэрлүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийн нийт өргөдөл, гомдол, санал хүсэлтэд эзлэх хувь | 0 | 85 хувь | 90 хувь | 2026 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн байдлаар ирүүлсэн өргөдөл гомдол санал, хүсэлтийг хуулийн хугацаанд шийдвэрлүүлэхэд хяналт тавьж ажиллаж сар бүр өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн мэдээг гаргаж, тайлан мэдээ хариуцсан мэргэжилтэнд хүргүүлсэн.<br>-2026 оны 1-р улиралд салбарын хэмжээнд ирүүлсэн өргөдөл гомдол шийдвэрлэлтийн мэдээ тус бүрийг дэлгэрэнгүй, хураангуй байдлаар гарган Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2026 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн 02/1194 тоот албан бичгээр ЗГХХГ-т хүргүүлсэн.<br>Нийт ирсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийн тоо- 3803<br>Үүнээс:<br>Бичгээр 167<br>Иргэд олон нийттэй харилцах төвд 1145<br>Цахим хэлбэрээр 219<br>Утсаар хандсан 26<br>Биечлэн уулзсан 2246<br>Нийт ирсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэсэн байдал<br>Шийдвэрлэсэн 2664<br>Уламжлагдаж ирсэн 98<br>Бусад байгууллагад шилжүүлсэн 15<br>Шийдвэрлэх шатандаа явж байгаа 341<br>Нийт шийдвэрлэлтийн явц 94 %-тай. | 90 |
| | | | ЗГХЭГ-т хүргүүлсэн улирлын тайлан /тоо/ | 0 | 2 | 4 | - 2026 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн байдлаар ирүүлсэн өргөдөл гомдол санал, хүсэлтийг хуулийн хугацаанд шийдвэрлүүлэхэд хяналт тавьж ажиллаж сар бүр өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн мэдээг гаргаж, тайлан мэдээ хариуцсан мэргэжилтэнд хүргүүлсэн. | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | - 2026 оны 1-р улиралд салбарын хэмжээнд ирүүлсэн өргөдөл гомдол шийдвэрлэлтийн мэдээ тус бүрийг дэлгэрэнгүй, хураангуй байдлаар гарган Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2026 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн 02/1194 тоот албан бичгээр ЗГХХГ-т хүргүүлсэн.<br>Нийт ирсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийн тоо- 3803<br>Үүнээс:<br>Бичгээр 167<br>Иргэд олон нийттэй харилцах төвд 1145<br>Цахим хэлбэрээр 219<br>Утсаар хандсан 26<br>Биечлэн уулзсан 2246<br>Нийт ирсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэсэн байдал<br>Шийдвэрлэсэн 2664<br>Уламжлагдаж ирсэн 98<br>Бусад байгууллагад шилжүүлсэн 15<br>Шийдвэрлэх шатандаа явж байгаа 341<br>Нийт шийдвэрлэлтийн явц 94 %-тай.<br>Нийт ирсэн өргөдлийн Нийгмийн даатгал тэтгэвэртэй хобоотой өргөдөл 60%-тай байна.<br>-ГБХНХЯ-нд 2026 оны 06 дугаар сарын 08 -ны байдлаар нийт ирсэн өргөдлийн тоо 700<br>Үүнээс: Төрлөөр<br>Хүсэлт 343<br>Гомдол 242<br>Санал 104<br>Мэдээлэл 2<br>Талархал 6<br>Шаардлага 3<br>Үүнээс: Ирсэн хэлбэрээр<br>Бичгээр 258<br>ИОНХТ 11.11 төвөөр 424<br>Цахимаар 11 | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Утсаар 2<br>Биечлэн 5<br>Нийт ирсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэсэн байдал<br>Шийдвэрлэсэн 626<br>Шийдвэрлэх шатандаа явж байгаа 74<br>Нийт шийдвэрлэлтийн явц 89,4 %-тай.<br>Нийт Ирсэн өргөдөл гомлын 40 хувийг НДХСБГ-т Тэтгэврийн асуудлаар, 30 хувийг Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцаа цалин хөлс, хөдөлмөрийн маргаантай асуудлаар тус тус ирсэн.<br>Салбарын болон яамны өргөдөл гомдлын тайлан мэдээг долоо хоног, сараар, улирлаар гаргаж Төрийн захиргааны удирдлагын газар /дарга/-т болон СХШҮДАГ /дарга/-т тус тус тухай бүр танилцуулж, хугацаа хэтэрсэн өргөдөл гомдлыг шийдвэрлүүлэх талаар мэдээлэл өгч ажилласан.<br>- “Able” систем ашигладаг байгууллагууд гаргасан өргөдөл, гомдлын бүртгэл, ангилал, шийдвэрлэлтийн талаарх мэдээллийг “Хур” системээр дамжуулан тухай бүр өргөдөл, гомдлын нэгдсэн мэдээллийн санд нэгтгэх тохиргоог хийж бүртгэгдсэн. | |
| | | | Тус яамны СХШҮДАГ-т хүргүүлсэн хагас, бүтэн жилийн тайлан /тоо/ | 0 | 1 | 2 | Тайланг эхний хагас жилээр гарган СХШҮДАГ-т хүргүүлсэн. | |
| | | | Сар бүр гаргадаг мэдээ /тоо/ | 0 | 6 | 12 | ГБХНХЯ-ны сар бүрийн үйл ажиллагааны нэгдсэн тайланд 6 удаа холбогдох мэдээ тайланг хүргүүлсэн. | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | СХШҮДАГ-аас гаргасан маягтын дагуу Төрийн нарийн бичгийн даргын шуурхай хуралдаанд удирдлагуудад танилцуулсан 7 хоног бүрийн мэдээ /тоо/ | 0 | 22 | 44 | Өргөдөл, гомдол, ирсэн бичгийн шийдвэрлэлтийн мэдээг 7 хоног бүрийн баасан гаригт тайлан гаргаж Төрийн захиргааны удирдлагын газрын даргад танилцуулан ажиллаж байна. Нийт 21 удаа айлан гаргасан байна. | |
| 11.14. | Байгууллагын ил тод байдлыг хангах, хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллах, бодлого, үйл ажиллагаа, цаг үе, үйл явдлын мэдээ мэдээллийг шуурхай бэлтгэн түгээх, байгууллагын вэб сайт болон сошиал сувгуудыг хөтөлж, хөгжүүлнэ. | Улсын төсөв | Вэб сайтад байршуулах цаг үе үйл явдлын мэдээ мэдээлэл /тоо/ | 0 | 120 | 130 | 1. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас зохион байгуулсан хурал, зөвлөгөөнийг баримтжуулж, фото зураг авч, текст мэдээ бэлтгэн яамны пэйж хуудас байршуулсан болно. Мөн шаардлагатай үед видео бичлэг хийж, хэвлэл мэдээллийн байгууллагаар түгээх ажлыг хийж байна. 2026 оны эхний хагас жилийн байдлаар нийт 152 мэдээ бэлтгэн нийтэлсэн.<br>2. Фейсбүүк пэйжийн дагагчдын тоо 135263 болж нэмэгдсэн.<br><br>3. Нийгмийн сүлжээнд мэдээг олон төрлийн контент хэлбэрээр бэлтгэн мэдээллийн хүртээмжийг дээшлүүлж байна. Шинэ итгэл-Эрс шинэтгэл хөтөлбөрийн 6 постер, нэгдсэн арга хэмжээний урилга хөтөлбөр танилцуулга мэдээлэл бүхий 24 постер, тэмдэглэлт өдрийн талаар 8 постер гэх мэт **100** гаруй постер бэлтгэж, түгээв.<br>Тайлант хугацаанд нийт **96** видео контент байршуулсны дотор шууд дамжуулалт, албаны хүний яриа, рийл, тв мэдээ, заавар зөвлөмж бүхий богино видео, шторк зэрэг олон төрөл багтаж байна. | 100 |
| | | | Фейсбүүк пэйжийн дагагчдын тооны нэмэгдүүлэлт /тоо/ | 132,000 | 136.000 | 140.000 | | |
| | | | Мэдээллийн хүртээмжтэй байдлыг дээшлүүлэхэд чиглэсэн постер, видео, рийль, стори г.м бүтээсэн контент олон төрөл эсэх | 0 | 1 | 2 | | |

| Зорилт.12. | Хууль тогтоомжийн үзэл баримтлал, төсөл боловсруулахад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх; | Улсын төсөв | Арга хэмжээ /тоо/ | 0 | 1 | 4 | | ТЗУГ ХЭЗХ |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 12.1. | Аймаг, нийслэлийн Засаг дарга нартай 2026 онд хамтран ажиллах гэрээний төслийг яамны нэгж, орон нутгаас санал авч бэлтгэнэ. | Улсын төсөв | Батлагдсан гэрээний тоо | 0 | 22 | - | 2026 онд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын хууль тогтоомж, бусад баримт бичигт заасан эрх хэрэгжүүлж, үүрэг гүйцэтгэх гэрээг боловсруулж, яамны газрууд мөн аймаг, нийслэлийн Засаг даргад гэрээний төсөл хүргүүлж саналыг авч нэгтгэн гэрээг эцэслэн боловсруулж, Төсвийн тухай хуульд заасан хугацаанд аймаг, нийслэлийн Засаг дарга нар Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдтай **22** гэрээ байгуулсан | 100 |
| 12.2. | Сайд, Төрийн нарийн бичгийн даргын баталсан захиргааны хэм хэмжээний акт, шийдвэр, гэрээ, хэлэлцээрийн төслийн хууль зүйн үндэслэлийг хянах, бусад яам, газруудаас боловсруулсан хууль, Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоол, шийдвэр, гэрээ, хэлэлцээр болон бусад шийдвэрийн төсөлд салбарын бодлого, хууль тогтоомжид нийцүүлэн санал боловсруулна. | үйл ажиллагааны зардал | Тухайн жилд шаардлага хангаж, эрх бүхий байгууллагад бүртгэгдсэн захиргааны акт, захиргааны хэм хэмжээний актын нийт актад эзлэх хувь | 0 | 100 хувь | 100 хувь | 1. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 126 тушаалын төслийн хууль зүйн үндэслэлийг хянаж, эрх зүйн зөрчилгүй ажилласан. Тайлант хугацаааанд шүүх, бусад эрх бүхий байгууллагаас хүчингүй болгосон тушаал, шийдвэр гараагүй. Төрийн нарийн бичгийн даргын 194 тушаалын төслийн хууль зүйн үндэслэлийг хянаж ажилласан.<br>2. Яамны газар, хэлтсийн албан хаагчийн иргэн, хуулийн этгээд, төрийн болон төрийн бус байгууллагуудтай байгуулах гэрээний төсөл боловсруулахад тухай бүр мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэн, хянахын зэрэгцээ нийт **74** гэрээг бүртгэн, дугаар олгон ажилласан.<br>3. Бусад яам, газруудаас боловсруулсан хууль, Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоол, шийдвэр, гэрээ, хэлэлцээр болон бусад шийдвэрийн **303** төсөлд салбарын бодлого, хууль тогтоомжид | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | нийцүүлэн санал боловсруулж, хүргүүлсэн.<br>4. Сайдын 2026 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн А/62 дугаар тушаалаар салбарын хэмжээнд хүчин төгөлдөр үйлчилж байгаа ЗХХАкт, дүрэм, журам, заавар, аргачлалд дүн шинжилгээ хийх үүрэг бүхий ажлын хэсгийг Төрийн нарийн бичгийн даргаар ахлуулж яамны газар, харьяа 4 агентлаг, 2 байгууллагын 18 албан хаагчдыг бүрэлдэхүүнтэйгээр байгуулан ажилласан.<br>Ажлын хэсэг нь захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлтэй Нийгмийн даатгалын үйл ажиллагаатай холбоотой 14, Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн аюулгүй байдал, мэргэжлийн боловсролын сургалтын үйл ажиллагаатай холбоотой 35, Нийгмийн халамж, ахмад настны үйл ажиллагаатай холбоотой 14, гэр бүл, хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэний үйл ажиллагаатай холбоотой 15, сайдын дангаар баталсан 55 болон бусад сайд нартай хамтран баталсан 22 нийт 77 захиргааны хэм хэмжээний акт, дүрэм, журам, зааварт удирдамжийн дагуу дүн шинжилгээ хийж тайланг 2026 он 05 дугаар сарын 11-ний өдрийн 01/1609 тоот албан бичгээр ХЗДХЯ-д хүргүүлсэн.<br>Мөн салбарын хуулиудад захиргааны хэм хэмжээний акт батлах хуулиар тусгайлан эрх олгосон заалтын судалгааг ХЗДХЯ-аас ирүүлсэн хүснэгт аргачлалын дагуу хийж байна. | |
| 12.3. | Тус яамтай холбогдолтой эрүү, иргэн, захиргааны хэрэг хянан шийдвэрлэх | | Тухайн жилдээ амжилттай шийдвэрлэгдсэ | 0 | - | 50 хувь хүртэл | Сайдын эрхлэх асуудлын хүрээний асуудлаар эрх зүйн дэмжлэг үзүүлэн | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | ажиллагаанд итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцож, харьяа агентлаг, газруудад хууль, эрх зүйн зөвлөгөө өгч ажиллана. | үйл ажиллагааны зардал | н хэрэг, маргааны нийт шүүхээр шийдвэрлэсэн хэрэг маргаанд эзлэх хувь | | | | ажилласан, шүүх, хуулийн маргаанд яамыг төлөөлөн ажиллаж байна:<br>-Тайлант хугацаанд **4** иргэний маргаан, 2 эрүүгийн маргаан, 1 захиргааны маргаан нийт **7** маргаанд яамны төлөөлөгчөөр томилогдон ажилласан. Үүнд:<br>**Иргэний маргаан**:<br>- У.Баасансүрэн<br>- Хөх тавилан ХХК<br>- О.Шинэбаярын<br>- Ц.Ганхуягийн<br>**Захиргааны маргаан:**<br>- А.Цогоо<br>**Эрүүгийн маргаан:**<br>- Ж.Хатанбаатар нарын 3 яллагдагч<br>- Ц.Эрдэнэтуяа<br>- Япон Улс дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн гэрээ хэлэлцээр тэдгээрийн хэрэгжилт, зохион байгуулалт болон өдөр тутмын үйл ажиллагаа хариуцсан мэргэжилтнээр ажилаж байсан У.Баасансүрэнгийн “ажлын байран эргүүлэн тогтоолгох, ажилгүй байсан хугацааны цалин хөлсийг гаргуулах, нийгмийн даатгал болон эрүүл мэндийн шимтгэлийг нөхөн төлүүлж нөхөн бичилт хийлгэх тухай” нэхэмжлэлтэй Хан-уул дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх хуралд 2026 оны 03 дугаар сарын 16-ны өдөр оролцсон.<br>Нийт 111,863,943 төгрөг нэхэмжилсэнээс 27,423,313 төгрөгийг гаргуулахаар, 84,440,630 төгрөгийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн.<br>Нийслэлийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүхэд 2026 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр 27,423,313 төгрөгийг хэрэгсэхгүй болгуулахаар давж заалдах гомдол гаргасан. | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Нийслэлийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүх хурал товлогдоогүй байна.<br>- Хөх тавилан ХХК-ийн нэхэмжлэлтэй, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд 115.684.418 (нэг зуун арван таван сая зургаан зуун наян дөрвөн мянга дөрвөн зуун арван найм) төгрөг гаргуулах тухай иргэний хэргийн Давж заалдах болон Хяналтын шатны шүүх хуралдаанд итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцож, шүүхээс нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн.<br>- Яллагдагч Ж.Хатанбаатар нарын 3 яллагдагчид холбогдох эрүүгийн 2501000170222 дугаартай хэрэгт хохирогчийн хууль ёсны төлөөлөгчөөр оролцож, хохирогчийн байр суурьнаас мэдүүлэг өгсөн. АТГ-ын дуудсан цагт бэлэн байж, нийт 33 хавтас хэргийн материалтай танилцсан. Тус хэрэгт яллах дүгнэлт үйлдэгдэж шүүхэд шилжих шатанд байна.<br>- Багануур дүүргийн Нийгмийн даатгалын газраас Ц.Эрдэнэтуяад холбогдуулан гаргасан, 118 иргэний нийгмийн даатгалын баримт бичгийг хуурамчаар үйлдэж, шүүхээр ажилласан жилийг тогтоолгон нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр тогтоолгосон гэх эрүүгийн 2204001840109 дугаартай хэрэгт Давж заалдах гомдлын шүүхэд гаргах хариу тайлбарын төслийг боловсруулж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох талаар мэргэжил арга зүйн зөвөлгөө өгч ажилласан.<br>- Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн иргэнийн хэргийн анхан шатны тойргийн шүүхэд О.Шинэбаярын нэхэмжлэлтэй, Гэр | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдад 3,000,000,000 (гурван тэрбум) төгрөг гаргуулах тухай иргэний хэргийн шүүх хуралдаанд итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр 2 удаа оролцож, тус хэргийн шүүх хуралдаанд жич товлохоор хойшилсон.<br>Ц.Ганхуягийн нэхэмжлэлтэй иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд Монгол Улсын Засгийн газрын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр ХХХЭБХЗГ-ын дарга Б.Алимаа, Цалингийн зөрүү 4,948,662, алданги 2,474,331, инфляциас тооцсон 1,978,259 нийт 9,401,252 төгрөг.<br>**Анхан шатны шүүх:**<br>2026 оны 05 дугаар сарын 06-ны өдөр хэлэлцээд хэрэгсэхгүй болгосон.<br>- Нэхэмжлэгч А.Цогоогийн нэхэмжлэлтэй захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд Монгол Улсын Засгийн газрын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр НДЕГ-ын дарга Б.Батжаргал, яамны ТЗУГ-ын дарга Д.Мөнгөнтуул, Нийгмийн даатгал, хуримтлалын сангийн бодлогын газрын дарга В.Рэнцэнханд, тус газрын шинжээч Э.Цэрэнбат нар томилогдсон бөгөөд итгэмжлэгдсэн төлөөлөгч нартай хамтран ажилласан. Нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ бүхэлд нь татгалзсанаар тус хэрэг хэрэгсэхгүй болсон. | |
| 12.4. | Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны албан хаагчдыг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, зөрчил гаргасан эсэхийг хянан шалгаж, дүгнэлт гаргах, харьяалах байгууллагын | Соён гэгээрүүлэх, сургалт, гишүүдийн урамшуулал 15.0 сая төгрөг | Сургалт, нөлөөллийн ажилд хамрагдсан албан хаагчдын хувь | 50 | 70 хувь | 85 хувь | Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Ёс зүйн дэд хороог яамны нийт албан хаагчдын санал асуулгын үр дүнд 7 гишүүний бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулж, Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн А/106 дугаар тушаалаар албажуулж, үйл ажиллагаа явуулж байна. Тус дэд | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
